



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.06.11 № 3Г-1/62

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264002504



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.06.08 № 118/1980

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг хэлэлцэн дэмжээд, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Хавсралт ¹³⁹ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265006925



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2026.06.03 № 01/6681

танай 2026.06.02-ны № 01/1910 -Т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР ТАНАА

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн
төсөл болон дагалдуулан боловсруулсан бусад
хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн
20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг
үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх
зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн



З.МЭНДСАЙХАН

9761000975



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.06.05. № 1/3022

танай 2026.05.27-ны № 09/1840 -т

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР
ТАНАА**

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн
төсөл болон дагалдуулан боловсруулсан бусад
хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20
дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын
Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгов.



С.АМАРСАЙХАН


152841111 ХЗДХЯ-ны А5

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“18.ХЭЛЭЛЦСЭН нь: Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.




ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**БАТЛАВ.
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

Т.АУБАКИР

2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр



ATA12944 9132155 902470603

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД**

С.АМАРСАЙХАН

(Handwritten signature)



ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын Арван зургаадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй”, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” гэж тус тус заасан.

Монгол Улс 1969 оны 5 дугаар сарын 10-ны өдөр нэгдэн орсон Эхчүүдийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 103 дугаар конвенцын 4.1-д “Жирэмсний болон хүүхэд төрүүлсний чөлөөнд байгаа эмэгтэй мөнгөн тэтгэмж болон эмнэлгийн үйлчилгээ авах эрхтэй”, 4.2-т “Мөнгөн тэтгэмжийн хэмжээг үндэсний хууль тогтоомжоор тогтоох бөгөөд энэ нь эх, хүүхдийн амьдралын зохистой түвшинд эрүүл, бүрэн бүтэн байдлыг хангахуйц байна” гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан байна. Монгол Улс нь Үндсэн хуульдаа тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бүрдүүлэх үүргийнхээ дагуу Гэр бүлийн тухай бие даасан хуулийг 1999 онд батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 2.3-т “Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ” гэж, 2.3.1-д “Хүн амын төрөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.3.1-д “Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.2-д “Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, “Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.”, 2.1.1.3-т “Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ.”, 2.1.1.4-д “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20 өдрийн 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 102-т “Гэр бүлийг дэмжих тухай (Анхдагч хууль) гэж туссан зэрэг нь Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах үндэслэл болж байна. Энэхүү хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу хийсэн тандан судалгаагаар хуулийн төсөл боловсруулах шаардлагатай гэж дүгнэсэн. 1999 оны Гэр бүлийн тухай хууль нь хувийн эрх зүйд хамаарах гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох нөхцөл, журам, эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа, тэжээн тэтгэх, үрчлэлт, хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлэх, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдон гэр бүлийн гишүүдийн хооронд үүссэн эд хөрөнгийн бус амины харилцааг зохицуулдаг. Гэтэл гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн хөгжил, сайн сайхан байдлыг дэмжих эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа ба нийгмийн анхан шатны нэгж гэр бүлийг бэхжүүлэх шаардлага байна.¹

Гэр бүл, эх, хүүхдэд олгож буй тусламж, дэмжлэгийг Нийгмийн халамжийн тухай, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулиудаар зохицуулж байна. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 95-д Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар тусгасан бөгөөд энэ хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээг оновчтой болгон зорилтот бүлэгт чиглүүлж, эх, хүүхдэд чиглэсэн тусламж, дэмжлэгтэй холбоотой зохицуулалтыг нийгмийн халамжийн хуулиас салгах юм. Үүнтэй холбоотойгоор хүүхэд, гэр бүл, эхчүүдэд чиглэсэн тэтгэмж, хөнгөлөлт үзүүлэхтэй холбоотой хуулийн эрх зүйн орчинг нэгтгэн нэг хуулиар зохицуулах үүднээс хуулийн төсөл боловсруулах шаардлагатай байна.²

1.2.Практик шаардлага

Манай улс хүн амаа өсгөх, төрөлтийг дэмжих зорилгоор олон хүүхэдтэй эхчүүдэд хүүхдийн тоог харгалзан тэтгэмж олгож ирсэн. Тухайлбал: БНМАУ-ын Ардын Их Хурлын 1962 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн чуулганаар батлагдсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдэд улсаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулиар 3 ба түүнээс дээш хүүхэдтэй эхчүүдэд хүүхдийн тоог харгалзан 300-800 төгрөгийг жилд нэг удаа олгож байсан. Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1971 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 140 дүгээр зарлигаар Олон хүүхэдтэй эхчүүдэд улсын тэтгэвэр олгох журамд өөрчлөлт оруулж, төрүүлж


¹ Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан, х5

² Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан, х49

өсгөсөн 4 ба түүнээс дээш тооны бага насны олон хүүхэдтэй эхэд 16 хүртэл насны хүүхдийн тоог харгалзан жилд нэг удаа тэтгэмж олгож байжээ. Эдгээр арга хэмжээ нь манай улсын хүн амыг өнгөрсөн зуунд эрчимтэй өсөхөд чухал нөлөө үзүүлсэн.

Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн эхэн үе 1991 оноос хүн амын өсөлт буурсаар 2005 оноос эхлэн бага боловч тогтмол өсөлттэй байж, 2014-2015 онд 2.2³ хувь хүрсэн. Ийнхүү өсөхөд 2010 онд батлагдсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай, 2017 онд батлагдсан Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн хүрээнд жирэмсэн болон 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхчүүдэд сар бүр олгох тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эхийг Эхийн алдар одонгоор урамшуулж жил бүр тэтгэмж олгох зэрэг бодлогын арга хэмжээнүүд хувь нэмрээ оруулсаныг дараах хүснэгтээс харж болно.

ХҮН АМЫН ТОО, ӨСӨЛТИЙН ХУВЬ
сая хүнээр



ХҮН АМЫН ӨСӨЛТ БОЛОН ХЭТИЙН ТООЦОО
хувиар



2019 оны Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулиар 4 ба түүнээс дээш хүүхдийн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эхчүүдийн тэтгэврийн хэмжээг 50,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн, 2023 онд шинэчлэн баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 23.1.4-т заасны дагуу эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцох хугацааг түүний төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сараар нэмэгдүүлэн тооцдог болсон нь салбарын бодлого, хуулийг гэр бүлд ээлтэй болгож байгаагийн илрэл юм.

Нийгмийн халамжийн сангаас олгогддог ахмадуудад олгох насны хишиг, эхийн алдар одонгийн мөнгөн тусламж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарч байгаа эх, эцэгт олгож байгаа тэтгэмж, хүүхдийн мөнгө зэрэг нь гэр бүлд чиглэсэн нийтлэг мөнгөн тусламж буюу халамжийн сангийн хөрөнгийн 80 орчим хувь нь зорилтот бүлгээс илүүтэй нийтийг хамарсан шинжтэй үйлчилгээнд⁴, үлдсэн буюу 20 орчим хувь нь нийгмийн халамжийн зорилтот бүлгийн иргэдэд зарцуулагдаж байгаагаас харахад нийгмийн халамжийн хөрөнгийн ихэнх нь халамжийн бус зориулалтаар зарцуулагдаж байна.

Тодруулбал, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу 65, түүнээс дээш настай ахмад настанд насны хишиг, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу зургаан хүүхэд төрүүлж өсгөсөн "Эхийн алдар" нэгдүгээр зэргийн одонтой, дөрвөн хүүхэд төрүүлж

³ Үндэсний статистикийн мэдээллийн сан, 1212.мн

⁴ Нийгмийн халамжийн салбарын бодлогын шинжилгээ, 2024 он

өсгөсөн "Эхийн алдар" хоёрдугаар зэргийн одонтой эхэд олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийн урамшуулал, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь хэсэгт заасны дагуу хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 0-18 хүртэлх насны хүүхдэд, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу жирэмсний таван сартайгаас эхлэн хүүхэд төрүүлэх хүртэлх хугацаанд эхэд сар бүр олгох тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцэгт сар бүр хүүхэд асарсны тэтгэмж, дөрөв хүртэл насны ихэр хүүхэдтэй эх, эцгийн нэг удаагийн тэтгэмжид тус тус зарцуулагдаж байна.

Сүүлийн жилүүдэд манай улсад үүссэн ажиллах хүчний хомсдол нь ажлын байр, цалингийн шалтгаанаас гадна "хүн ам зүйн учир шалтгаантай" байна.⁵ Учир нь өнөөдрийн, цаашдаа ч хэсэг хугацаанд гол байх ажиллах хүчний гол бүлэг одоогийн 18-33 насныхан 1991-2005 онд төрсөн бага төрөлтийн үеийнхэн юм. Энэхүү бүлэг насныхан гол ажиллах хүчнээс гадна нөхөн үржихүйн ид үедээ байгаа тул бидэнд одоо л төрөлтийг дэмжих шаардлага байна.

Монгол Улсын Хүн амын 2020-2050 оны шинэчилсэн хэтийн тооцоогоор "Монгол Улсын хүн амын өсөлтийн хувь 2033 он хүртэл тогтмол аажмаар жилд дунджаар 0.1 нэгж хувиар буурсаар, 2036-2046 он хүртэл аажмаар өсөх боловч 2050 онд буурч 1.3 хувь болно" гэж⁶ тооцоолсноос өмнө хүн амын өсөлт буурахаар байна. Иймээс бид хүн ам зүйн нөхцөл байдлыг сайжруулах үүднээс төрөлт, эх, хүүхэд, гэр бүлийг дэмжих үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх нь зүйн ёсны хэрэг болох юм. Учир нь төрөлтийн ерөнхий коэффициент буюу 1000 хүн амд ногдох төрөлт 2014 оноос эхлэн жилээс жилд буурч 2014 онд 28 байснаа 2023 онд 19 болсон байна.⁷

2023 оны байдлаар Монгол Улсын 3,504,741 хүн ам нь 983,485 өрхөд бүртгэгдэн амьдарч байгаа бөгөөд нэг өрхөд дунджаар 3.56 хүн ногдож байна. Нийт 566,999 өрх хүүхэдтэй байгаа нь нийт өрхийн 57.7 хувь болж байна. Үүнээс 18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 54,873 байгаа нь нийт өрхийн 5.6 хувийг, хүүхэдтэй өрхийн 9.7 хувийг эзэлж байна.

Улсын хэмжээнд 2020-2023 онд жилд дунджаар 16,338 хос гэрлэлтээ бүртгүүлсэн бол 4,009 хос гэрлэлтээ цуцлуулсан байна. 2023 онд гэрлэлтээ бүртгүүлсэн хосын тоо 17,408 байж, өмнөх оноос 116-аар буюу нэг орчим хувиар буурсан бол гэр бүл цуцлалт 4,776 болж, өмнөх оноос 4,9 хувиар буюу 223-аар нэмэгджээ.

Өрхийн орлого, зарлагын байдлыг шинжлэхэд сүүлийн 5 жилийн 3 жилд нь өрхийн зарлага нь орлогоосоо давсан байдалтай байна. Тухайлбал, 2024 оны III улирлын байдлаар нэг өрхийн сарын дундаж орлого 2,617,237 төгрөг байхад зарлага нь 2,696,940 төгрөг байж, зарлага 79,703 төгрөгөөр орлогоо давсан байна. Мөн хугацааны сарын дундаж цалин 2,479,600 төгрөг байгаа ба өрхийн нийт орлогын 95 хувийг бүрдүүлж байна.⁸ Ядуурлын түвшин буюу нийт хүн амд ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй хүн ам 27,1 хувийг эзэлж байна.⁹

⁵ ХНХЯ, Монгол Улсын хөдөлмөрийн зах дээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн таамаглал судалгааны тайлан, 2024 он, х13

⁶ Монгол Улсын Хүн амын 2020-2050 оны шинэчилсэн хэтийн тооцоо, ҮСХ, 2021 он

⁷ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 1212.mn

⁸ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 1212.mn

⁹ Ядуурлын үндсэн үзүүлэлт, ҮСХ, 2022 он

“Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт” судалгаагаар¹⁰ гурван гэр бүл тутмын нэг нь санхүүгийн, таван гэр бүл тутмын нэг нь орон байрны асуудалтай гарсан байна. Гэр бүлийн зөрчил, маргааны 55.3 хувь нь санхүү, өр зээлийн асуудлаас, 15.7 хувь нь согтууруулах ундааны хэрэглээнээс, 15.3 хувь хүүхэдтэй холбоотой асуудлаас, 11 хувь нь үзэл бодлын зөрчлөөс болж байна гэж үзжээ. Судалгаанд оролцогчдын 57.6 хувь хөдөлмөр эрхлэх боломж, өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, 55.4 хувь орлого нэмэгдүүлэх, 18.6 хувь гэр бүлийн боловсрол олгох, 17.7 хувь гэр бүлийн харилцаа, сэтгэл заслын зөвлөгөө хэрэгтэй гэжээ. Залуу гэр бүл ажлын байр, орон сууцтай болох, орлогоо нэмэгдүүлэхийг хүсэж байхад дунд насны гэр бүл санхүү, хүүхдийн боловсрол, хүмүүжлийн асуудлыг чухалчилсан байна. Судалгааны дүнгээс иргэд эхлээд гэр бүлийн материаллаг хэрэгцээгээ хангахыг чухалчилдаг нь харагдаж байгаа бөгөөд тулгамдсан асуудлууд ихэнхдээ салбар дундын шинжтэй байна.

Гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн газар, хэлтэс, гэр бүлд зөвлөгөө өгөх төв нь байгуулагдсан цагаас иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг хэрэгжүүлж, жилд дунджаар гэр бүлийн 25-40 хувийг хамруулж байна. Тухайлбал, 2023 онд 418,139 хүнд урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө, үйлчилгээ үзүүлжээ. Гэсэн хэдий ч гэр бүлийн боловсролыг иргэдэд бага наснаас олгох, нийгмийн үйлчилгээг улам бүр өргөжүүлж гэр бүлд нийгэм сэтгэл зүйн цогц үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн нийгмийн хөгжлийн чиг хандлага, иргэдийн завгүй амьдралын нөхцөлтэй уялдуулан бие даан суралцах, цахим боловсрол олж авах боломжийг бүрдүүлж онлайн боловсрол, зөвлөгөө үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай юм.

Дээр дурдсан практик шаардлагыг багцлан дүгнэвэл хүн амын өсөлт, төрөлтийг дэмжих зорилгоор эх, хүүхэд, гэр бүлд боломжит дэмжлэгийг үзүүлэх, гэр бүлийг орлогыг сайжруулах үүднээс хөдөлмөрийн чадвартай гэр бүлийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, залуу гэр бүлд орон сууцны дэмжлэг үзүүлэх, иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлд цогц үйлчилгээ үзүүлэх, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг чанартай хүргэх, гэр бүлд ээлтэй орчинг бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

Гадаадын улс орнууд эдгээр тулгамдсан асуудлыг шийдвэрлэж, гэр бүлийг дэмжиж буй туршлагыг судлан үзэхэд дэлхийн 40 гаруй орон хүүхэд, эх, эцэг, гэр бүлд мөнгөн дэмжлэг үзүүлж, ажил, амьдралын тэнцвэрийг хангаж, гэр бүлд ээлтэй орчинг бүрдүүлж байна.¹¹ Улс орнуудын гэр бүлийг дэмжиж буй ерөнхий зарчмыг харахад нийгмийн тэгш байдлыг бий болгох үүднээс хүүхдийн тоо, гэр бүл, эцэг, эхийн орлогын түвшнээс хамааран тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, шатлалаар тогтоох зарчим баримталж байна.¹² Швед, Австрали, Герман, Унгар, Япон, Өмнөд Солонгос, Оросын Холбооны зэрэг улсууд нь хүүхдийн тооноос хамаарсан тэтгэмж дэмжлэг дээр нэмж гэр бүлд татварын хөнгөлөлт, орон сууцны дэмжлэг үзүүлж байна.¹³ Түүнчлэн гэр бүлийн орлого өндөр бол хүүхдийн тэтгэмж

¹⁰ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, 2019 он

¹¹ ОУЭЗХАХБ-ын болон Европын холбооны гишүүн өндөр болон дунд орлоготой 41 орны гэр бүлд ээлтэй бодлогын талаар НҮБХАС-гийн илтгэл, 2019 он

¹² Нийгмийн халамжийн хуулийн төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээний тайлан, Дэлхийн банк, 2022 он

¹³ Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан, 2024, х34-48

олгохгүй байх, багасгах зарчим ч харагдаж байна. Хүүхдийн мөнгийг Франц Улс хүүхдийн тооноос хамаарч шатлалаар, Япон улс 3 дахь хүүхдээс эхлэн 50 хувиар нэмэгдүүлсэн хэмжээгээр тус тус олгож байна. БНСУ өрхийн орлогын түвшин хамгийн өндөр 10 хувийн 0-6 насны хүүхдээс бусад бүх хүүхдэд мөнгөн тэтгэмж олгодог бол Казахстан Улс 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд өрхийн орлогыг харгалзахгүйгээр, харин цөөн хүүхэдтэй өрхөд хүүхдийн тооноос хамааруулан олгож байна.

Унгар Улс гэр бүлийг дэмжих, төрөлтийг нэмэгдүүлэх зорилгоор нэг хүүхэдтэй эхэд сард 32 евро, 2 хүүхэдтэй эхэд 60 евро, 3 хүүхэдтэй ээж сард 99 еврогийн татварын хөнгөлөлт, 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн бол татвараас насан туршид нь чөлөөлдөг. ОХУ эхний 2 хүүхдэд тус бүр сард 1400 рублийн, 3 дахь хүүхдээс 3000 рублийн татварын хөнгөлөлт үзүүлдэг байна. Татварын хөнгөлөлт нь ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг дэмжиж, нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлдэг байна.

Өмнөд Солонгос Улс нь гэр бүлд ээлтэй нийгмийн орчинг дэмжих тухай хуулийг¹⁴ хэрэгжүүлж, гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг ажиллуулж байна. Гэр бүлд ээлтэй нийгмийн орчин гэж ажил, амьдралын тэнцвэрийг хангах, хүүхэд өсгөх хүмүүжүүлэх, гэр бүлийг дэмжих хариуцлагыг бүх түвшинд хуваалцан хэрэгжүүлдэг орчныг үздэг байна. Гэр бүлийн хөгжлийн цогц төв нь гэр бүлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэх, гэр бүлийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, бусад төвүүдийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.¹⁵

Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж, гэр бүлийн харилцааны хувийн эрх зүйн орчинг сайжруулахаар ажиллаж байгаатай зэрэгцүүлэн гэр бүлийн хөгжил, гэр бүлд ээлтэй орчинг дэмжих эрх зүйн орчин бий болгох, түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 95-д заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн найруулахтай холбогдуулан Нийгмийн халамжийн тухай, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай, Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулиар нийтлэг хэлбэрээр эх, хүүхдэд олгож байгаа тэтгэмж, тусламж, урамшууллыг гэр бүлийг дэмжих нийгмийн бодлогын бусад арга хэмжээтэй нэгтгэн тусдаа хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагыг тус тус үндэслэн Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг шинээр боловсруулахыг зүйтэй гэж үзсэн болно.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл нь эх, хүүхдийн хөгжлийг дэмжих, гэр бүлд ээлтэй орчныг бүрдүүлэх, гэр бүлд хөгжлийн цогц үйлчилгээ үзүүлэх, ажил, амьдралын тэнцвэртэй байдлыг хангах замаар гэр бүлийн тогтвортой байдал, хүн амын өсөлтийг дэмжихэд оршино. Хуулийн төсөлд дараах агуулгыг бүлэглэн тусгана:

Хуулийн зорилт, нэр томъёоны тодорхойлолт, гэр бүлийг дэмжихэд баримтлах зарчмыг тусгана;

¹⁴ Act on the promotion of creation of family-friendly social environment, Act No.17438, Jun 9, 2020

¹⁵ БНСУ-д "Монгол гэр бүлийн өдөрлөг" зохион байгуулсан тайлан, 2024, х2

Нийгмийн халамжийн хуулийн дагуу хүүхэд, эх, гэр бүлд тэтгэмж олгох, хөнгөлөлт үзүүлэх, олон хүүхэдтэй эхийг шагнах, урамшуулахтай холбогдсон харилцааны зохицуулалтыг тусгана;

Гэр бүлд үзүүлэх нийгмийн үйлчилгээг тодорхойлж, иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээ, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө, эрүүл мэнд, хууль зүйн зөвлөгөө, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх, онлайн сургалт, зөвлөгөө, үйлчилгээний мэдээллийн платформ, гэр бүлийн хөгжлийн цогц төв, үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зэрэг харилцааг тусгана. Аймаг, дүүргүүдэд Гэр бүлийн хөгжлийн цогц төв ажиллаж, гэр бүл, хүн амын бүлэгт нэгдсэн, төрөлжсөн хөтөлбөрөөр үйлчилгээг үзүүлэх, алслагдсан газарт амьдарч буй гэр бүлд явуулын үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг тусгана;

Орон нутаг, аж ахуйн нэгж, байгууллага гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах, гэр бүлд ээлтэй хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах, иргэд, олон нийтэд чиглэсэн гэр бүл хамтаараа байх, гэр бүлийн өдрийг тэмдэглэхийг дэмжих харилцааны зохицуулалтыг тусгана;

Гэр бүлийн хөгжлийг дэмжих төрийн байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, салбар дундын зохицуулалт, хэрэгжилт, хяналт, мэдээлэл солилцох, 5 жил тутамд гэр бүлийн суурь судалгаа, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ тус тус хийх, хүний нөөцийг бэлтгэхтэй холбоотой зохицуулалтыг тусгана;

Хууль зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтны үйлдэлд холбогдох хуульд заасан хариуцлага, хууль дагаж мөрдөх шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгана.

Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон заалт тусгахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 болон 27¹ дүгээр зүйлд заасан шаардлагыг баримтална. Харин одоогийн мөрдөгдөж буй захиргааны хэм хэмжээний актыг хуулийн төсөлд тусгаж, захиргааны хэм хэмжээний актын тоог багасгана. Тухайлбал, хуулийн төсөлд Хүүхдийн мөнгөн дэмжлэгтэй холбогдох эрх зүйн зохицуулалтыг тусгаснаар Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам баталсан 236 дугаар тогтоол хүчингүй болж, хуулиар зохицуулагдана.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг тайлагнах, үр дүнг хянах, хариуцлагыг нэмэгдүүлэх, ил тод байх зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарч, холбогдох санхүү, үйл ажиллагааны тайлангаа хариуцсан байгууллагад гаргах, ил тод байлгах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, ялангуяа бага насны хүүхэдтэй, олон хүүхэдтэй гэр бүлийн амьдралын чанарыг сайжруулах, эх, нялхсын эрүүл мэнд, иргэдийн хөгжлийг цогц байдлаар дэмжих боломж бүрдэнэ. Төрийн зүгээс нийгмийн анхан шатны нэгж-гэр бүлд эрүүл,

үндэсний ухамсартай, хүмүүнлэг, ёс суртахуунтай, өв тэгш, эх оронч иргэнийг өсгөн бойжуулах, төлөвшүүлэх нөхцөл бүрдүүлснээр Монгол Улсын хүн амын тогтвортой өсөлт хангагдах таатай нөхцөл бүрдэнэ.

Олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжсэнээр гэр бүлийн аж амьдрал дээшилж, гэр бүлийн харилцаа бат, тогтвортой болох, ажил, хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг дэмжсэн бодлого бодитойгоор хэрэгжиж, хөдөлмөрийн бүтээмж, нийгмийн чинээлэг дундаж давхаргын эзлэх хувь нэмэгдэнэ.

Түүнчлэн эх, хүүхдийг дэмжих бодлогыг нийгмийн халамжийн бодлогоос ялгаж заагласнаар халамж хавтгайрсан гэх иргэд, олон нийтийн ойлголт, хандлага өөрчлөгдөнө.

Энэ хуульд тусгах гэр бүл, эх, хүүхдэд үзүүлэх мөнгөн дэмжлэгүүд нь одоо мөрдөгдөж буй Нийгмийн халамжийн тухай болон Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай, Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулиар зохицуулагдаж байгаа тул төсөв нэмж шаардагдахгүй болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Орон сууцны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын төслийг тус тус боловсруулна.

---oOo---

ТАНИЛЦУУЛГА

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай
хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай” 01 дүгээр тогтоолын 7-д “хүн амын өсөлт, нөхөн үржихүй, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор жирэмсэн эмэгтэй, эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, асаргаа сувилгааны чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхдийн тооноос хамааруулан гэр бүлд дэмжлэг үзүүлэх талаар холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасан.

Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 95-д Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар, 102-т “Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай (Анхдагч хууль) тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.2-д “Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, “Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.”, 2.1.1.3-т “Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ.”, 2.1.1.4-д “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Дээр дурдсан хууль, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтад заасны дагуу Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/37 дугаар тушаалаар, холбогдох байгууллагын албан тушаалтан, судлаач, эрдэмтдийг оролцуулан байгуулж, хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсрууллаа.

Энэхүү хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл боловч Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг шинэчлэх хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээг оновчтой болгон зорилтот бүлэгт чиглүүлж байгаатай холбоотойгоор хүүхэд, эх, эцэгт чиглэсэн мөнгөн тэтгэмжийг хүн амын бодлогын арга хэмжээ гэж үзэж, нийгмийн халамжийн хөтөлбөрөөс хасч энэ хуулийн төсөлд оруулахаар болж байна.

Олон улсын хэмжээнд гадаад орнууд гэр бүлийг хэрхэн дэмжиж буйг судлан үзэхэд Олон улсын эдийн засаг хамтын ажиллагаа, хөдөлмөрийн байгууллагын болон Европын холбооны гишүүн өндөр болон дунд орлоготой 41 орны гэр бүлд ээлтэй бодлого, болон бусад нийтлэг туршлагыг үзэхэд хүүхдийн сайн сайхан байдал, эцэг,

эх, асран хамгаалагчийн ажил, амьдралын тэнцвэрийг хангах гэр бүлд ээлтэй нийгмийн орчин бий болгохыг чухалчилж байна. Иймд гэр бүлийн дэмжих үйл ажилагаа тухайлбал, шууд хэлбэрээр мөнгөн дэмжлэг олгох, бусад хэлбэрээр буюу орон сууц, татварын дэмжлэг үзүүлэх, ажил, амьдралын тэнцвэрийг хангах, гэр бүлийн боловсрол, эрүүд мэндийг дэмжих, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, эдгээртэй холбогдулан төрийн болон орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүрэг, санхүүжилтийн асуудлыг зохицуулж, тодорхойлсон Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

Гэр бүлийн хөгжлийг дэмжих

Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны чиглэллийг тодорхойлсон. Гэр бүлд орон сууцны дэмжлэг үзүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, ажил, амьдралын тэнцвэрийг хангах, гэр бүлийн боловсрол, эрүүл мэндийг дэмжих, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, хүн амын бүлэгт чиглэсэн хөтөлбөрт үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн өдрийг тэмдэглэхтэй холбоотой зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусгалаа.

Гэр бүлд орон сууцны дэмжлэг үзүүлэх

Иргэн, гэр бүл хүний амьдралын үндсэн нөхцөл болох орон байртай болгохыг дэмжих, ялангуяа хүүхэдтэй залуу гэр бүл, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл анх удаа ипотекийн зээлээр орон сууц худалдан авахаар ипотекийн зээлийн зорилтот бүлгийн жагсаалтад орсон тохиолдолд орон сууцны зориулалтын дэмжлэгийг тэргүүн ээлжинд хамруулах, улмаар ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргахаар тусгалаа. Ипотекийн зээлд хамрагдаж чадахгүй, урьдчилгаа төлбөр бүрдүүлж чадахгүй байгаа гэр бүл, ялангуяа дэмжлэгт хамрагдах боломжгүй хүүхэдтэй залуу гэр бүл эсхүл 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг тэргүүн ээлжинд түрээсийн орон сууцанд хамруулах байдлаар орон байртай болгох зохицуулалтыг Засгийн газраас хэрэгжүүлэхээр тусгалаа.

Гэр бүл өмчилсөн, эсхүл гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар эзэмших эрхтэй газар дээрээ стандартад нийцсэн эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын стандарт хангасан амины орон сууц барихад нь дэмжлэг үзүүлэх орон нутаг өөрийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай уялдуулан шийдвэрлэхийг зүйтэй гэж үзлээ.

Ажил, амьдралын тэнцвэрийг хангах

Ажил ба амьдралын тэнцвэрийг хангах нь гэр бүл аз жаргалтай байх үндсийг тавьж өгдөг. Хөдөлмөрийн тухай хуульд ажилтны хөдөлмөр зохион байгуулалт, ажлын цагийг уян хатан зохицуулахыг ажил олгогчид зөвшөөрсөн боловч хэрэгжилт төдийлөн сайн биш байгааг харгалзан ажил, амьдралын тэнцвэрийг хангах зорилгоор зарим тодорхой зохицуулалтыг тусгалаа. Хуулийн төсөлд ажил олгогч цэцэрлэг, сургуулийн

насны хүүхэдтэй ажилтанд хүүхдээ сургууль, цэцэрлэг рүү хүргэж өгөх, авахад нь зориулж өдрийн ажлын цагийг богиносгох, ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулах, гэр бүлийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа ажилтанд гэрээсээ, эсхүл зайнаас ажиллах боломжоор хангах, ерөнхий боловсролын сургуульд суралцдаг хүүхэдтэй ажилтан хичээлийн жилийн өвлийн амралтын хугацаанд ээлжийн амралтаа авах тохиолдолд нэмэгдэл амралтын хугацаа олгох, байгууллагын цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээ ажиллуулах, хүүхдийн насны онцлогт тохирсон хүүхдийн өрөө бий болгох, ажилтны нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээндээ тусган хэрэгжүүлэхээр тусгалаа.

Гэр бүлийн боловсролыг дэмжих

Гэр бүлд үзүүлэх иргэдэд гэр бүлийн боловсролыг албан болон албан бус боловсролоор олгох, гэр бүлийн албан бус боловсрол олгох сургалтыг гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв, насан туршийн суралцахуйн төвтэй хамтран зохион байгуулах, мэргэжлийн төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэхээр тусгалаа. Гэр бүлийн боловсролын асуудал нь олон салбарын асуудал тул боловсрол, соёл, гэр бүлийн хөгжлийн байгууллага хамтран хэрэгжүүлэхийг зүйтэй гэж үзэж тусгасан.

Эрүүл мэндийг дэмжих

Гэр бүлийн эрүүл мэндийг дэмжих үйлчилгээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл мэндийн байгууллага өөрийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэхдээ гэр бүлийг онцлон гэр бүлд хүргэх үйлчилгээнүүдийг бий болгох, гэр бүлээрээ эрт илрүүлэгт хамрагдах, мөн гэр бүл нь хүн ам өсч торинох чухал орчин тул гэрлэгчдийн нөхөн үржихүй, гэр бүл төлөвлөлт, энэ талаарх эрүүл мэндийн үзлэгийг гэрлэгчдэд хүртээмжтэй байлгах, чанартай үйлчилгээ үзүүлэх, иргэдийг эрүүл дадал, ёс зүйд сургах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх

Гэр бүлд нийгмийн зүгээс ирж буй сөрөг хүчин зүйл, нийгмийн дарамтаас ангид байж, урьдчилан сэргийлэх, төвөгтэй асуудлыг даван туулахад нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ ихээхэн чухал байдаг. Иргэдийн сэтгэхүйг өөрчлөх, харицлагатай гэр бүлийн гишүүн болгох, гэр бүлийн хүчирхийллээс ангид байх, нэгэнт тулгамдсан асуудлыг шийдэхэд нийгмийн ажлын үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх зэрэг асуудлыг гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага, нийгмийн ажилтан хэрэгжүүлж байх зохицуулалтыг тусгалаа.

Гэр бүлийн өдрийг тэмдэглэх

Эрүүл, тогтвортой гэр бүлийг төлөвшүүлэхэд хувь хүн, гэр бүл, нийгэм нийтээрээ идэвхтэй оролцох, гэр бүлд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.5-д заасан “Гэр бүлийн өдөр” тохиосон долоо хоногийг нийтээр тэмдэглэх, эдгээр өдрүүдэд гэр бүл рүү чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг зохион байгуулах, угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, удаан хугацаанд хамт

амьдарсан, үр хүүхдээ зөв өсгөж хүмүүжүүлсэн гэр бүл, түүнчлэн гэр бүлд ээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын урамшуулах, алдаршуулах үйл ажиллагааг зохион байгуулахаар хуулийн төсөлд тусгалаа.

Хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг

Нийгмийн халамжийн шинэчлэл хийгдэж, халамжийн хууль тогтоомжийг зорилтот хэсэг рүү чиглүүлж байгаатай холбоотойгоор амьжиргааны түвшингээс хамааралгүй олгогддог - хүүхдийн мөнгө, хүүхэд асарсны мөнгөн тэтгэмж /цалинтай ээж/, жирэмсэн эх, ихэр хүүхдэд олгодог мөнгөн дэмжлэгтэй холбоотой Нийгмийн халамжийн тухай хууль, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн зохицуулалтыг нэгтгэн энэхүү хуулийн төсөлд тусгалаа. Эдгээр нь хүн амын өсөлт, гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн амьдралын үндсэн хэрэгцээг хангахад чиглэсэн бодлого, арга хэмжээ гэж үзсэн. Мөнгөн дэмжлэгийн хэмжээг Засгийн газар тогтоох бөгөөд ингэхдээ мөнгөн дэмжлэгийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлж байх заалтыг хуулийн төсөлд тусгасан.

Хүүхдийн мөнгөн дэмжлэг

Хүүхдийн мөнгөн дэмжлэгийн тухайд Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.6-д “хүүхдийн мөнгөн тэтгэмж” нэрээр туссан бөгөөд Засгийн газрын 2023 оны 236 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-аар олгож байна. Хүүхдийн мөнгөн дэмжлэгийг одоо байгаа зохицуулалтаар хэвээр олгоно.

Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг

Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэгийг 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцэгт олгодогыг хэвээр үлдээв. Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг авагч өөрөө хүсвэл 24 сарын хугацаанд авах мөнгөн дэмжлэгийг нэг удаа бөөнөөр, үлдсэн хугацаанд сар бүр авч болох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа. Мөн Засгийн газар хүүхэд асарсны мөнгөн дэмжлэгийн хэмжээг байгаа нөөц боломжийн хэмжээнд бодлогоор нэмэгдүүлэхээр тусгалаа.

Гэр бүлийг дэмжих тогтолцоо

Хуулийн төсөлд гэр бүлийг дэмжих чиглэлээр гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн гэр бүлийн асуудал төрийн байгууллага, сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүрэг, гэр бүлийг дэмжих санхүүжилтийн талаарх зохицуулалтуудыг нарийвчлан тусгалаа. Түүнчлэн аймаг, дүүрэгт гэр бүлийг дэмжих үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий гэр бүлийн цогц үйлчилгээний төвийг төвийг орон нутгийн соёл, спорт, хүүхэд, залуучууд, ахмад, иргэдийн хөгжлийн төв зэргийг түшиглэн ажиллуулна. Үндэсний статистикийн хороо, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран гэр бүл, хүн амын өсөлтийг дэмжих урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлт, стратегийг тодорхойлох зорилгоор гэр бүлийн суурь судалгааг таван жил тутамд хийх зохицуулалтыг төсөлд тусгалаа.

Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв

Иргэд гэр бүлээрээ амралт чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөж, хэрэгтэй үйлчилгээгээ нэг дор авч чадах гэр бүлийн гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг аймаг, дүүрэг болгон ажиллуулах асуудлыг тусгалаа. Түүнчлэн орон нутгийн зүгээс өөрийн орон нутгийн иргэдийн шилжих хөдөлгөөн, хүн амын бүтэц, нөөц боломжийг түшиглэн хүн амын бүлгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байх зохицуулалтыг хуулийн төсөлд тусгалаа.

Гэр бүлийн үйлчилгээний цахим систем

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2025 оны эхнээс гэр бүлийн хөгжлийн цахим үйлчилгээний E-Family платформыг бүтээх ажлыг гүйцэтгэж байна. Тус платформоор дамжуулан иргэд, нийт гэр бүл өөрсдийн хэрэгцээнд тохирсон тухайлбал, залуу гэр бүл, дунд насны гэр бүл, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй зэрэг гэр бүлд чиглэсэн гэр бүлийн боловсрол, санхүүгийн зөвлөгөө, гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө, эрүүл мэнд, хууль зүйн зөвлөгөө үйлчилгээг цахимаар нээлттэй авах боломжтой болно. Мөн тус цахим платформоор хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэгийг хүсэлтийг цахимаар хүлээн авах, цахимаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ.

Дагалдан боловсруулах хууль тогтоомж

Хуулийн төсөлтэй холбогдуулан Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Орон сууцны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсрууллаа.

Хөдөлмөрийн тухай хууль нь ажил, амьдралын тэнцвэрийг хангахад чухал хууль тул Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан оруулж байна.

Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөгдөж байгаа боловч хуулийг нэг мөр хэрэглэх, ойлголтыг нэгтгэх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа. Үүнд:

1. Монгол үндэстний уламжлалт Цагаан сар, Үндэсний их баяр наадмыг ёслол хүндэтгэл, зан үйл, цар хүрээг харгалзан үзэж зөвхөн эдгээр баярын өдрүүд нь долоо хоног бүрийн амралтын өдрүүдтэй давхацсан тохиолдолд дараагийн долоо хоногийн ажлын өдрүүдэд шилжүүлэн амрахаар зохицуулах боломжтой юм. Баярын өдрүүдийг нөхөн амарснаар цагаан сарын баярын амралтын өдөр Бямба, Ням гарагтай давхацвал 6 өдөр дараалан амрах, Үндэсний их баяр наадмын өдрүүдээр 8-10 өдөр амрах болно. Жишээлбэл, Үндэсний их баяр наадмын өдөр 2025 оны 7 дугаар сарын

10, 11, 12, 13, 14, 15-ны өдөр 6 өдөр үргэлжлэх байсныг хуулийн төсөлд зааснаар өөрчилбөл 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17-ны өдөр буюу нийт 8 өдөр дараалан амрах боломжтой болно.

2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаас удаа дараа гаргаж байгаа санал, хүсэлтийн дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.4 дэх хэсэгт өөрчлөлт оруулах санал боловсрууллаа. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүн гэснийг өөрчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүний байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагын, нийт ажилтны дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр худалдан авч байгаа ажил олгогчийг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй төлбөрөөс зохих журмын дагуу хөнгөлж, эсхүл чөлөөлнө.

Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль болон Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн зохицуулалтууд нийтлэгээрээ Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулинд туссан учир эдгээр хуулиудыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийг боловсруулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасны дагуу олгож байгаа мөнгөн дэмжлэгийг төлбөр гаргуулж болохгүй орлогод тооцуулахаар нэмэлт тусгасан.

Орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай зэрэг гэр бүлд ээлтэй орчныг хүртээмжтэйгээр төлөвлөх заалтыг Орон сууцны тухай хуульд нэмэлтээр оруулах төсөл боловсрууллаа.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зохицуулалтыг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд оруулж байгаа тул Нийгмийн халамжийн тухай хуулиас хассан.

Авто тээврийн тухай хуульд "17¹.4. Энэ хуулийн 17¹.3-т заасан орлогыг Хүүхдийн төлөө санд төвлөрүүлнэ" гэсэн 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон заалтыг буцаан нэмэхээр боловсруулсан.

ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай” 01 дүгээр тогтоолын 7-д “хүн амын өсөлт, нөхөн үржихүй, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор жирэмсэн эмэгтэй, эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, асаргаа сувилгааны чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхдийн тооноос хамааруулан гэр бүлд дэмжлэг үзүүлэх талаар холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасан.

Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн “Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 95-д Нийгмийн халамжийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар, 102-т “Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай (Анхдагч хууль) тус тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.2-д “Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, “Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.”, 2.1.1.3-т “Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ.”, 2.1.1.4-д “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Дээр дурдсан хууль, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтад заасны дагуу Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/37 дугаар тушаалаар, холбогдох байгууллагын албан тушаалтан, судлаач, эрдэмтдийг оролцуулан байгуулж, хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсрууллаа.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлал, Хуулийн тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн 6 бүлэг, 32 зүйлтэйгээр боловсруулав. Хууль тогтоомжийн тухай хуулийн 33.4-т “Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад шинэчилсэн найруулга бол бүлгээр, ... багцлан тусгана” гэж заасны дагуу танилцуулгыг доорх байдлаар боловсруулан бэлтгэв.

Хуулийн төсөлд ГБХНХ-ын сайдын “Санал авах тухай” 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/1630 болон 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 01/3178 тоот албан бичгээр 2 удаа холбогдох байгууллагуудаас санал авч тусгасан болно.

Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл

Энэ бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, гэр бүлийн хөгжлийг дэмжихэд баримтлах зарчмыг тусгасан.

Хуулийн үйлчлэх хүрээ

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд “энэ хуульд заасан шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын харьяат иргэн, Монгол Улсад хууль ёсоор оршин сууж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэдгээрийн гэр бүлд хамаарна” гэж зааж өгсөн. Харин хүүхэд, эх эцэгт олгох мөнгөн дэмжлэгийг хуульд заасан шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7, 5.1.8-д заасан хүн хамаарахаар тусгасан. Хуулийн төсөлд тусгасан орон сууцны дэмжлэгт Монгол улсын иргэн хамаарахаар тусгасан.

Энэ хууль батлагдсанаар Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай болон Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль хууль хүчингүй болно.

Хуулийн нэр томьёо

Хуулийн нэр томьёонд “гэр бүлд ээлтэй орчин”, “ажил, амьдралын тэнцвэрийг хангах”, “гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа”, “залуу гэр бүл”, “гэр бүлийн үйлчилгээний цахим мэдээллийн сан” зэрэг шинэ нэр томьёонуудыг тусгаж, тодорхойлсон. “асран хамгаалагч, харгалзан дэмжигч”, “хүүхэд үрчлэн авах”, “хүүхдээ асарч байгаа” зэрэг нэр томьёо нь Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулиар тодорхойлсон нэр томьёонууд бөгөөд энэ хууль батлагдсанаар тус хууль хүчингүй болох тул эдгээр нэр томьёог хуульд оруулсан болно.

Хоёрдугаар бүлэг Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа

Энэ бүлэгт гэр бүлийн хөгжлийг дэмжих дараах үйл ажиллагаануудыг тусгасан.
Үүнд:

- орон сууцны дэмжлэг үзүүлэх;
- ажил, амьдралын тэнцвэрийг хангах;
- гэр бүлийн боловсролыг дэмжих;
- эрүүл мэндийг дэмжих;
- нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх;
- гэр бүлийн өдрийг тэмдэглэх.

Мөн гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа нь дээрхээр хязгаарлагдахгүй бөгөөд бусад хууль тогтоомжид заасан бусад дэмжлэг байж болно.

Орон сууцны дэмжлэг

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол Улсад 2025 оны байдлаар 1,011,078 өрх байна.

- **Өрхийн бүтэц:**

- Ганц бие өрх: 191,542 буюу нийт өрхийн 19.2%.
- 4 ам бүлтэй өрх: 177,826 буюу 17.8% (хамгийн түгээмэл).
- 3 ам бүлтэй өрх: 161,372 буюу 16.2%.
- Олон ам бүлтэй өрх: 10-аас дээш ам бүлтэй өрх 6,472 буюу 0.6% байна.

Эндээс харахад Монгол Улсад **4 ам бүлтэй өрх хамгийн олон** байдаг ба энэ нь нийт өрхийн ойролцоогоор **17.8%-ийг** эзэлдэг.

- **Малчин өрх:** 2020 оны тооллогоор 181,050 малчин өрх байгаа бөгөөд 15-34 насны малчид 30%-ийг эзэлж байна.

- **Гэрлэлт ба цуцлалт:**

- 2019 оны гэрлэлттэй (20,043) харьцуулахад 2025 онд гэрлэлт (12,582) буюу 27%-иар буурсан.
- Гэр бүл цуцлалтын тоо 5%-иар өссөн.

- **Өрхийн амьдрах орчин:**

- Өрхийн 33% нь монгол гэрт, үлдсэн нь тусдаа байшин эсвэл нийтийн орон сууцанд амьдарч байна.

Гэр бүлд орон сууцны дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь гэр бүл ипотекийн зээлээр орон сууц худалдаж авах, түрээсийн орон сууцан хамруулах гэсэн арга хэмжээнээс бүрдэнэ. Гэр бүл ипотекийн зээлээр орон сууц худалдаж авах тохиолдолд хүүхэдтэй залуу гэр бүл, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл анх удаа ипотекийн зээлээр орон сууц худалдан авах гэж байгаа бөгөөд ипотекийн зээлийн зорилтот бүлгийн жагсаалтад орсон тохиолдолд Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасны дагуу ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргах” хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ.

Анх удаа ипотекийн зээлээр орон сууц худалдан авах гэж байгаа эсвэл түрээсийн орон сууцанд хамрагдахаар бүртгүүлсэн хүүхэдтэй залуу гэр бүл болон 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг тэргүүн ээлжид хамруулах арга хэмжээг Засгийн газраас хэрэгжүүлэхээр заасан.

Одоогийн байдлаар нийслэл болон зарим аймагт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцанд зорилтод бүлгийн иргэдийг хамруулахтай холбоотой журмыг батлан мөрдүүлж байна.¹ Өөрөөр хэлбэл, орон нутгийн өмчийн түрээсийн орон сууцанд хэнийг хамруулах эсэхийг тухайн орон нутаг нь өөрөө бие даан шийдвэрлэх бөгөөд үүнд төрөөс оролцохгүй байх нь зүйтэй.

¹ Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн зорилтод бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ыг баталсан, мөн Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтод бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ыг баталсан.

Ажил, амьдралын тэнцвэрийг хангах

2021 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-т “Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ” хэмээн анх удаа “ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах” зохицуулалт тусгагдсан. Гэвч хэрхэн “ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах” нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй байна.

Хөдөлмөр эрхэлж буй таван хүн тутмын хоёр нь илүү цагаар ажиллаж байна. Нийт ажиллагчдын 411.2 мянга (34.8%) нь илүү цагаар (долоо хоногт 48 цагаас их) ажиллаж байгаа бөгөөд эрэгтэйчүүд (44.6%) эмэгтэйчүүдээс (23.7%) 20.9 хувиар илүү цагаар ажиллаж байна. Илүү цагаар ажиллах нь ажиллагчдын бие, сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна ажил, амьдралын тэнцвэрийг нь алдагдуулдаг. Цаашлаад, гэр бүл төлөвлөлт, хүүхдийн хүмүүжил болон ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлдөг². Ажил олгогч гэр бүлтэй, хүүхэдтэй, мөн гэр бүлд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан байдаг ажилтны хөдөлмөр эрхлэлтэд уян хатан нөхцөл хэрэглэх, ажил, амьдралын тэнцвэрийг хангахад чиглэсэн цалин хөлсийг бууруулахгүйгээр ажлыг цагийг богиносгох, зайнаас, цахимаар ажиллуулах, ээлжийн амралтын өдрийг нэмэгдүүлэх, хүүхдийн өрөө бий болгох зэрэг арга хэмжээг ажилтны төлөөлөлтэй зөвшилцөн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээндээ тусган хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан.

Ажилчдын хэрэгцээ, шаардлага, нөхцөл байдал харилцан адилгүй байдаг, мөн ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах нь ажил олгогч ба ажилтан хоёрын аль алиных нь хэрэгцээг хангах, харилцан үр ашигтай харилцааг бий болгох бий болгох зорилготой тул эн арга хэмжээ талуудын сайн дурын оролцоо, зөвшилцөлд суурилах шаардлагатай. Иймд Хуулийн төслийн 8 дугаар зүйлд гэр бүлтэй ажилчдын онцлогт тохирсон ажил, амьдралын тэнцвэрийг хангах арга хэмжээнүүдийг тусгасан байх ба эдгээрийг хэрэгжүүлэхийг ажил олгогчид заавал үүрэг хүлээлгээгүй, харин ажил олгогч, ажилтнуудтайгаа зөвшилцөн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээндээ тусган хэрэгжүүлэхээр тусгасан.

Гэр бүлийн боловсролыг дэмжих

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны зүгээс монгол гэр бүлийн харилцааны байдал, өөрчлөлт, хэв шинжийн судалгааг 2010, 2018, 2024 онуудад хийж ирсэн. Тус судалгааны дүнгээс харахад гэр бүлийн доторх зөрчил маргаан, гэр бүл салах шалтгаан нь үзэл бодлын зөрүү, санхүү, орон сууцны асуудал, хардалт, гэр бүлээс гадуурх харилцаа зэрэг асуудлууд давамгайлсан хэвээр байна. Энэ нь нэг талдаа орлогын ядуурал, нийгэм, эдийн засгийн үр нөлөөнөөс хамаарч байгаа

² АЖИЛЛАХ ХҮЧНИЙ БОЛОН АЛБАДАН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СУДАЛГААНЫ ҮНДСЭН ТАЙЛАН, УСХ, 2022.

ч, нөгөө талдаа гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн боловсрол дутмаг, гэр бүлийг дэмжих цогц тогтолцоо бүрэн гүйцэд бүрэлдээгүйтэй холбоотой юм.

2024 оны судалгаагаар өрхийн тэргүүний боловсролын түвшинг түүний эхнэр/нөхрийн боловсролын түвшинтэй харьцуулахад хосуудын хувьд ерөнхийдөө өөртэйгөө адил, ойролцоо боловсролын түвшний хүнтэй гэр бүл болох сонирхолтой байгаа нь харагдаж байна. Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын олонх буюу 58 хувь нь гэр бүл болохоос өмнө бэлгийн харилцаанд орохыг хүлээн зөвшөөрч байгаа нь бэлгийн болон ёс суртахууны талаарх үзэл хандлага нээлттэй болж, нийгмийн уламжлалт хэв загвараас өөрчлөгдөж байгааг харуулж байна. Харин 33 хувь нь үүнийг үл зөвшөөрч, уламжлалт үнэт зүйлсийг баримталж буйг илэрхийлж байгаа бөгөөд үлдсэн 9 хувь нь тодорхой байр суурьгүй байгаа нь энэ сэдвийн талаар төдийлөн сонирхоогүй анхаарал хандуулаагүй байна. Энэ нь гэр бүлийн боловсрол, бэлгийн хүмүүжил, нийгмийн үнэт зүйлсийн талаарх ойлголтыг цаашид өргөжүүлэх шаардлагатай байна.

Гэр бүлийн боловсрол нь гэр бүлийн гишүүдийн харилцаа, үүрэг хариуцлага, ойлголт, харилцан хүндэтгэл, шийдвэр гаргалт зэрэг гэр бүлийн амьдралд шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмших, хөгжүүлэх зорилготой боловсролын үйл ажиллагаа юм. Энэ нь гэр бүлийн хүчирхийлэл бууруулах, үр хүүхдээ өсгөх, амьдралаа зөв төлөвлөх, эрүүл, тогтвортой гэр бүлийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Уг асуудал хуулиар шууд зохицуулагдаагүй ч одоогийн байдлаар Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар хамтран гэр бүлийн боловсрол олгох сургалтын модулийг гаргаж, сургагч багш нарыг бэлтгэн, гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж байна. Иймд гэр бүлийн боловсролыг дэмжих үйл ажиллагааг хуульчилж, энэ талаарх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг аймаг, нийслэл, дүүргийн боловсролын, соёлын болон гэр бүлийн асуудал хариуцсан төрийн байгууллага зохион байгуулах зохицуулалтыг тусгасан.

Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх

Гэр бүлийн хүрээнд үүсэж буй зөрчил, маргаан нь олон хүчин зүйлээс хамааран бий болдог.

Тухайлбал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2024 онд хийсэн “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” судалгаанд оролцогчдын 29.2 хувь нь үзэл бодлын зөрчлөөс, 24.4 хувь нь согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэснээс, 22.8 хувь нь харилцан ойлголцдоггүйгээс, 21.5 хувь нь мөнгө санхүүгийн хомсдолоос гэр бүлийн зөрчил, маргаан үүсдэг гэж үзжээ. Гэр бүлийн зөрчил, маргааны шалтгааныг хот болон хөдөөгөөр тодруулахад судалгаанд хамрагдсан хотын гэр бүлүүдийн хувьд харилцан үл ойлголцол (25.3%), мөнгө санхүүгийн хомсдол (24.7%) голлох шалтгаан болж байгаа бол хөдөөгийн гэр бүлүүд архидалтаас (26.1%), харилцан ойлголцдоггүйгээс (21.1%) үүдэлтэйгээр зөрчил маргаан гардаг байна.

Үүнтэй холбогдуулан иргэдээс төрөөс хүсч байгаа дэмжлэг туслалцааны төрөлд орлого, ажлын байр нэмэгдүүлэх саналтай адил буюу судалгаанд

оролцогчдын 30 гаруй хувь нь сэтгэлзүйн зөвлөмж, тусламж, сэтгэл заслын үйлчилгээг нэмэгдүүлэхийг хүссэн байна.

Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг гэрлэгчдийн харилцааг сайжруулах, гэрлэлт цуцлалт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх; эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх; эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхэд хүмүүжлийн зэрэг аргын ур чадвар олгох сургалт зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх; эх, эцгээсээ тусдаа амьдарч байгаа хүүхдэд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх; гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх; гэр бүлийн гишүүдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах зэрэг чиглэлээр аймаг, дүүргийн гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага, гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв зохион байгуулж хүргэнэ.

2024 онд “Гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд тавигдах шаардлага” MNS 7038:2024 стандартыг батлан мөрдөж байна. Нийгмийн ажилтан гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхдээ энэхүү стандартыг дагаж мөрдөнө. Аймаг, дүүргийн гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага, гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв нь гэрлэгчдийн харилцааг сайжруулах, гэрлэлт цуцлалт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулах бөгөөд мөншүүх дэх эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллаж гэрлэгчдийн харилцааг сайжруулах, гэрлэлт цуцлалтаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа үр нөлөөтэй явуулах нь чухал юм.

Гэр бүлийн өдрийг тэмдэглэх

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.5-д Жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрийн “Гэр бүлийн өдөр” болгож нийтээр тэмдэглэхээр заасан байдаг. Уг өдөр тохиосон долоо хоногийн хүрээнд орон нутаг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны боловсролын, соёлын болон гэр бүлийн асуудал хариуцсан төрийн байгууллагатай хамтран гэр бүл рүү чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, угийн бичиг хөтлөхийг дэмжих, 25 ба түүнээс дээш жил хамт амьдарч, үр хүүхдээ зөв өсгөж хүмүүжүүлсэн гэр бүл болон гэр бүлд ээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, алдаршуулах гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулна.

Мөн гэр бүл нийтээрээ амрах, жрүүл, тогтвортой гэр бүлийг төлөвшүүлэхэд хувь хүн, гэр бүл, нийгэм нийтээрээ идэвхтэй оролцох оролцоог дэмжих зорилгоор манай улсын уламжлалт баяр болох Үндэсний их баяр наадам, Цагаан сарын баярын өдөр долоо хоногийн амралтын өдөр тохиовол дараагийн ажлын өдөрт шилжүүлж, нийтээр амардаг зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Гуравдугаар бүлэг

Хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг

Уг бүлэг хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэгийн зохицуулалтыг тусгасан. Эдгээр мөнгөн дэмжлэг дараах төрөлтэй байна. Үүнд:

- хүүхдийн мөнгөн дэмжлэг;
- жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг;
- хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг;
- ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг;
- олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн урамшуулал.

Дээрх мөнгөн дэмжлэгүүд нь шинээр бий болгож байгаа мөнгөн дэмжлэгүүд биш бөгөөд хүн амын өсөлтийг дэмжих төрийн бодлогын хүрээнд өөр өөр хуулиар зохицуулагдан олгогдож байгаа мөнгөн дэмжлэгүүд юм. Тодруулбал, хүүхдийн мөнгөн дэмжлэгийн тухайд Нийгмийн халамжийн тухай хуульд “хүүхдийн мөнгөн тэтгэмж” нэрээр туссан бөгөөд Засгийн газрын 2023 оны 236 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-аар, жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг, хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг, ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг зэрэг нь “Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль”-аар зохицуулагдаж байгаа бөгөөд эдгээр мөнгөн дэмжлэгийг энэ хуульд нэгтгэж, нэг хуулиар зохицуулна” гэсэн үг. “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль”-аар зохицуулагддаг олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн урамшуулалын харилцааг мөн нэгтгэж энэ хуулиар зохицуулж шийдвэрлэнэ.

Дээрх мөнгөн дэмжлэгийн хүрээнд зарчмын шинжтэй өөрчлөлтүүд гэвэл “хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг”-ийг 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцэгт олгож байгааг хэвээр үлдээв. Ингэхдээ “Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж авахаар тогтоолгосон эх, эцэг, асран хамгаалагч тэтгэмжийг эрх дуусах хүртэл хугацаанд сар бүр хэвээр олгох” шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн урамшууллыг хамгийн бага хүүхэд нь 18 хүрсэн бол уг мөнгөн урамшууллыг зогсооно. Харин энэ зохицуулалт нь энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд заасны дагуу “Эхийн алдар” одонгоор шагнагдсан эхэд хамаарахгүй” байх шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгасан. Эдгээр өөрчлөлтийг хийснээр мөнгөн дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Журмаар зохицуулж байгаа харилцааг хуулиар зохицуулна

Засгийн газрын Засгийн газрын 2021 оны 199 дүгээр тогтоолоор “Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж журам”, 2023 оны 236 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-ын зохицуулалтыг хуульд оруулсан, тухайлбал эдгээр мөнгөн тэтгэмж /хуулийн төсөлд мөнгөн дэмжлэг гэж нэршлээр тусгасан/-ийг зогсоох үндэслэл, суутгал хийх, мөн асрамжийн газар амьдарч байгаа, цагдан хоригдож байгаа, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад

ял эдэлж байгаа хүүхдийн мөнгийг хэрхэн олгох, хүүхдийн эрхийг зөрчсөн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдийн мөнгийг олгохгүй, түдгэлзүүлэх үндэслэлийг хуульд тусгасан.

Харин хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэгийг авах хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх журмыг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгасан. Тодруулбал, хүсэлтийг цахимаар эсхүл бичгээр хэрхэн хүлээн авах, ямар баримт бичиг бүрдүүлэх, нийгмийн халамжийн байгууллага үүнийг хэдийн хугацаанд, хэрхэн шийдвэрлэх, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох зэрэг асуудлыг хуулиар биш журмаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн.

Дөрөвдүгээр бүлэг **Гэр бүлийн хөгжлийг дэмжих тогтолцоо**

Энэ бүлэгт гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, аймаг, дүүргийн гэр бүлийн асуудал хариуцсан байгууллагын чиг үүрэг, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны чиг үүрэг, орон нутаг буюу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын чиг үүргийг заасан. Мөн аймаг, дүүрэгт шинээр “гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв”-ийг байгуулж, тус төвийн орон нутгийн соёл, спорт, хүүхэд, залуучууд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв болон бусад боломжтой байгууламжийг түшиглэн ажиллуулна.

“Гэр бүлийн үйлчилгээний цахим мэдээллийн систем”-ийг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллуулах хүрээнд хүний хувийн мэдээллийг хадгалах, хамгаалах, цахим системээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх, цахим зөвшөөрөл авах, нууцлал, аюулгүй байдал, цахим системийн талаар төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргийг тусгасан.

Гэр бүл, хүн ам зүйн судалгаа

Гэр бүл, хүн амын өсөлтийг дэмжих урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлт, стратегийг тодорхойлох, мөн бодлого боловсруулахад нотолгоонд суурилсан байх шаардлагыг хангах зорилгоор гэр бүлийн суурь судалгааг Үндэсний статистикийн хороо, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран таван жил тутамд хийнэ.

Гэр бүлийн үйлчилгээний цахим мэдээллийн систем

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2025 оны эхнээс гэр бүлийн хөгжлийн цахим үйлчилгээний E-Family платформыг бүтээх ажлыг гүйцэтгэж байна. Тус платформоор дамжуулан иргэд, нийт гэр бүл өөрсдийн хэрэгцээнд тохирсон тухайлбал, залуу гэр бүл, дунд насны гэр бүл, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй зэрэг гэр бүлд чиглэсэн гэр бүлийн боловсрол, санхүүгийн зөвлөгөө, гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээ, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө, эрүүл мэнд, хууль зүйн зөвлөгөө үйлчилгээг цахимаар нээлттэй авах боломжтой болно. Мөн тус цахим платформоор хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн

дэмжлэгийг хүсэлтийг цахимаар хүлээн авах, цахимаар шийдвэрлэх боломжийг бүрдүүлнэ.

Тавдугаар бүлэг Санхүүжилт ба хяналт

Энэ бүлэгт Гэр бүлийг дэмжих үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгасан. Үүнд:

- улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр;
- төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн санхүүжилтээр;
- Зээлийн батлан даалтын сангийн мөнгөн хөрөнгөөр;
- дараа эргэн төлөгдөх нөхцөлөөр байгуулсан гэрээний үндсэн дээр банкны зээл болон хувийн хэвшлийн байгууллагаас гаргах хөрөнгөөр;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан орон нутгийн сангийн хөрөнгөөр;
- хүн, хуулийн этгээд, гадаад улс, олон улсын байгууллагын хандив тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр;
- хуульд заасан бусад эх үүсвэр.

Улс, орон нутгийн төсвөөс гэр бүлийг дэмжих чиглэрээр энэ хуульд заасан үйл ажиллагаа, арга хэмжээг санхүүжүүлэхийг тодорхой заасан. Гэр бүлийг боловсролыг дэмжих, эрүүл мэндийг дэмжих, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхэд шаардагдар зардлыг санхүүжүүлэх аргачлал, зардлын нормативыг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, зардлыг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн болон холбогдох салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусгаж санхүүжүүлнэ.

Зургаадугаар бүлэг Бусад зүйл

Энэ бүлэгт шилжилтийн үеийн зохицуулалт, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тусгасан.

Энэхүү хуульд шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгах зайлшгүй шаардлага байна. Хуулийг дагаж мөрдөхөөс өмнө эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж авахаар тогтоолгосон эх, эцэг, асран хамгаалагч тэтгэмжийг эрх дуусах хүртэл хугацаанд сар бүр хэвээр үргэлжлүүлэх авах зохицуулалтыг тусгасан.

Түүнчлэн олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн урамшууллыг эхийн бага хүүхэд аль хэдийн насанд хүрч, бүр 40 гарсан байхад ч гэсэн эхэд олгосоор байдаг энэ гажуудлыг арилгахыг зүйтэй гэж үзэж, бага хүүхэд нь 18 хүрсэн бол зогсоож байх зорхицуулалтыг тусгалаа. Гэхдээ энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд заасны дагуу “Эхийн алдар” одонгоор шагнагдсан эхэд хамаарахгүй.

--оОо--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, ажил, амьдралын тэнцвэрийг хангах, гэр бүлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хүүхэд, эх, эцэгт мөнгөн дэмжлэг олгох, гэр бүлийн хөгжлийг дэмжих тогтолцоог тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж

2.1.Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулийн гуравдугаар бүлэгт заасан дэмжлэг, үйлчилгээнд хуульд заасан шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн болон Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7, 5.1.8-д заасан хүн хамрагдана.

3.2.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан дэмжлэгт Монгол Улсын иргэн хамрагдана.

3.3.Энэ хуулийн 3.1, 3.2-т зааснаас бусад бүлэг, зүйлд заасан дэмжлэг, үйлчилгээнд хуульд заасан шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор оршин сууж байгаа гадаадын иргэн, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7, 5.1.8-д заасан хүн, тэдгээрийн гэр бүлийн гишүүн хамрагдана.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“гэр бүл” гэж Гэр бүлийн тухай хуулийн 3.1.2-т заасныг;

4.1.2.“гэр бүлд ээлтэй орчин” гэж хүүхэд, гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдал, хэрэгцээг нэн тэргүүнд харгалзсан нийгмийн эрүүл, аюулгүй, тав тухтай,

гэр бүлд ээлтэй ажлын байр, олон нийтийн газар, тэдгээрийн хүртээмжтэй байдлыг;

4.1.3.“ажил, амьдралын тэнцвэрийг хангах” гэж ажилтан хувийн амьдрал, гэр бүл, ажил хөдөлмөртөө зохистой цагийг зарцуулж, бүтээлч байх, ажил, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ажил олгогчоос хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл, орчныг бүрдүүлэх, ажилтанд тусламж дэмжлэг үзүүлэх зэргээр хоёр талаас тэнцвэрт байдлаа хангах зохицуулалт хийхийг;

4.1.4.“гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа” гэж гэр бүлийн үнэт зүйл, сайн сайхан байдал, тогтвортой байдлыг дэмжих, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, ёс суртахууныг бэхжүүлэх, ажил амьдралын тэнцвэрийг хангахад чиглэсэн орон сууц, боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн олон талт хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээг;

4.1.5.“залуу гэр бүл” гэж гэрлэгчдийн аль нэг нь анх удаа гэрлэлтээ иргэний улсын бүртгэлд бүртгүүлсэн 35 хүртэл насны байхыг;

4.1.6.“асран хамгаалагч, харгалзан дэмжигч” гэж Гэр бүлийн тухай хуулийн 67.1.1-д заасан хүнийг;

4.1.7.“хүүхэд үрчлэн авах” гэж Гэр бүлийн тухай хуулийн 55, 57, 58 дугаар зүйлд заасны дагуу үрчлэн авсан эцэг, эх болон үрчлүүлсэн хүүхдийн хооронд төрсөн эцэг, эх, хүүхдийн адил эрх, үүрэг, хариуцлага үүсгэхээр иргэний улсын бүртгэлд бүртгүүлснийг;

4.1.8.“хүүхдээ асарч байгаа” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 139.1-д заасан хүүхэд асрах чөлөөтэй, эсхүл Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.3-т заасан ажилгүй эх, эцэг 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгааг;

4.1.9.“гэр бүлийн үйлчилгээний цахим мэдээллийн сан” гэж гэр бүлд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох, иргэний бие даан хөгжих, суралцах боломжийг бүрдүүлэх зорилго бүхий цахим платформыг;

5 дугаар зүйл.Гэр бүлийн хөгжлийг дэмжихэд баримтлах зарчим

5.1.Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах;

5.1.2.жендэрийн эрх тэгш байдлыг хангах, ялгаварлан гадуурхахгүй байх;

5.1.3.үндэсний өв соёл, уламжлал, ёс заншил, гэр бүлийн үнэт зүйлийг хүндэтгэх;

5.1.4.иргэний үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх журамт үүргийг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

5.1.5.хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг хадгалах;

5.1.6.гэр бүл, олон нийтийн оролцоог дэмжих;

5.1.7.орон нутаг, хувийн хэвшлийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлэх;

5.1.8.үйлчилгээг үл тулгах, сонголттой байх, сайн дурын үндсэн дээр хамруулах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6 дугаар зүйл.Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа

6.1.Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

6.1.1.орон сууцны дэмжлэг үзүүлэх;

6.1.2.ажил, амьдралын тэнцвэрийг хангах;

6.1.3.гэр бүлийн боловсролыг дэмжих;

6.1.4.эрүүл мэндийг дэмжих;

6.1.5.нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх;

6.1.6.гэр бүлийн өдрийг тэмдэглэх;

6.1.7.хууль тогтоомжид заасан бусад.

7 дугаар зүйл.Орон сууцны дэмжлэг үзүүлэх

7.1.Гэр бүл орон сууцтай болоход нь дараах дэмжлэгийг үзүүлнэ:

7.1.1.Анх удаа ипотекийн зээлээр орон сууц худалдан авах гэж байгаа эсвэл түрээсийн орон сууцанд хамрагдахаар бүртгүүлсэн хүүхэдтэй залуу гэр бүл болон 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг тэргүүн ээлжид хамруулах арга хэмжээг Засгийн газраас хэрэгжүүлнэ.

7.1.2.Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй байгаа гэр бүлд Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9.1.3-т заасны дагуу ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд зээлийн батлан даалт гаргах;

7.2.Иргэн гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчилж авсан болон эзэмших эрхтэй газар дээрээ эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барихад дэмжлэг үзүүлэх асуудлыг тухайн орон нутгийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан Орон нутгийн нэгжийн удирдлага хэрэгжүүлнэ.

7.3.Бүх шатны засаг дарга нь гэр бүлийн эрүүл амьдрах орчныг сайжруулах, иргэдийн цэвэр ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг жил бүр төлөвлөн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

8 дугаар зүйл.Ажил, амьдралын тэнцвэрийг хангах

8.1.Ажил олгогч нь хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан ажилтны хөдөлмөр эрхлэлтэд уян хатан нөхцөл хэрэглэх, ажил, амьдралын тэнцвэрийг хангахад

чиглэсэн дараах арга хэмжээг ажилтны төлөөлөлтэй зөвшилцөн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээндээ тусган хэрэгжүүлж болно:

8.1.1.сургуулийн өмнөх болон бага боловсролд хамрагдаж байгаа хүүхэдтэй өрхийн эцэг, эх, асран хамгаалагчийн аль нэгд хүүхэд харах үйлчилгээ, цэцэрлэг, сургуульд хүүхдээ хүргэж өгөх, авахад нь зориулж, ажилтны цалин хөлсийг нь бууруулахгүйгээр ажлын цагийг 2 хүртэлх цагаар богиносгох;

8.1.2.гэр бүлийн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаа ажилтныг жилд нэг удаа 3 хүртэлх сарын хугацаанд долоо хоногийн 1 өдөр гэрээсээ, зайнаас ажиллуулах;

8.1.3.ерөнхий боловсролын сургуульд суралцдаг хүүхэдтэй ажилтан хичээлийн жилийн өвлийн амралтын хугацаанд ээлжийн амралтаа эдлэхийг хүсвэл ээлжийн нэмэгдэл амралтын хугацааг ажлын 2 өдрөөр нэмэгдүүлж олгох;

8.1.4.ажилтны тоо, хүсэлтийг үндэслэн байгууллагын цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээ ажиллуулах, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хүүхдийн өрөө бий болгох;

8.2.Ажил олгогч нь ажилтны эрүүл мэндийг дэмжих, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

9 дүгээр зүйл.Гэр бүлийн боловсролыг дэмжих

9.1.Иргэн, гэр бүл, олон нийт рүү чиглэсэн гэр бүлийн боловсролыг дэмжих дараах сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 9.1.1.гэрлэлт, гэрлэгчдийн үүрэг, хариуцлага;
- 9.1.2.гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэнд;
- 9.1.3.гэр бүлийн үнэт зүйл, угийн бичиг хөтлөлт;
- 9.1.4.гэр бүлийн харилцаа, ёс зүй;
- 9.1.5.хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгаалал;
- 9.1.6.гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх;
- 9.1.7.гэр бүлийн гишүүдийн эрүүл мэнд;
- 9.1.8.гэр бүлийн төсөв, санхүү.

9.2.Гэр бүлийн боловсролыг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг аймаг, нийслэл, дүүргийн боловсролын, соёлын болон гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллага зохион байгуулна.

10 дугаар зүйл.Эрүүл мэндийг дэмжих

10.1.Гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

10.1.1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 13.2.2-д заасны дагуу гэр бүлд эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг бий болгох чиглэлээр үйлчилгээ үзүүлэх;

10.1.2.Өсвөр үе, оюутан, суралцагчдын дунд нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөв дадал, зан үйлийг хэвшүүлэх, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг үзүүлэх;

10.1.3. Бага насны хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй гэр бүлд эрүүл мэндийн шаардлагатай тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлэх;

10.1.4. Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүнд бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд байгаа сэтгэлзүйчдээр дамжуулан гэр бүлийн сэтгэлзүйн тусламж, үйлчилгээг тусгайлан үзүүлэх;

10.1.5.Архидан согтуурах, тамхидалт, мансуурах донтой болон дэлгэцийн хамааралтай хүүхэд, гэр бүлийн гишүүдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвүүд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа баривчлах төвүүдэд үзүүлэх;

10.1.6.Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүлд гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэн тэргүүнд хүргэх;

10.1.7.Үргүйдэлтэй гэр бүлд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ойртуулж, нийгэм, сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх.

10.2.Энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.4, 10.1.6, 10.1.7-д заасан үйл ажиллагааг аймаг, нийслэл, сум, дүүрэг, өрхийн эрүүл мэндийн байгууллага тус тус хэрэгжүүлнэ.

11 дүгээр зүйл. Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх

11.1.Нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээг дараах чиглэлээр үзүүлнэ:

11.1.1.гэрлэгчдийн харилцааг сайжруулах, гэрлэлт цуцлалт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

11.1.2.эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхэд хүмүүжлийн эерэг аргын ур чадвар олгох сургалт зохион байгуулах, арга зүйн зөвлөгөө өгөх;

11.1.3.эх, эцгээсээ тусдаа амьдарч байгаа хүүхдэд нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх;

11.1.4.гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээг стандартын дагуу үзүүлэх;

11.1.5.гэр бүлийн гишүүдийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан үйлчилгээг аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага зохион байгуулна.

12 дугаар зүйл. Гэр бүлийн өдрийг тэмдэглэх

12.1.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасан Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдөр, 4.1.3-т заасан Цагаан сарын баярын өдөр долоо хоногийн амралтын өдөр тохиовол дараагийн ажлын өдөрт шилжүүлж, нийтээр амарна.

12.2.Эрүүл, тогтвортой гэр бүлийг төлөвшүүлэхэд хувь хүн, гэр бүл, нийгэм нийтээрээ идэвхтэй оролцох, гэр бүлд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.1.5-д заасан “Гэр бүлийн өдөр” тохиосон долоо хоногийг нийтээр тэмдэглэнэ.

12.3.Энэ хуулийн 12.2-т заасан өдрийн хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны боловсролын, соёлын болон гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагатай хамтран дараах үйл ажиллагааг зохион байгуулна:

12.3.1.гэр бүлийн үнэ цэн, сайн сайхан байдал, соёл, өв уламжлалын талаар олон нийтийг соён гэгээрүүлэх;

12.3.2.угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх;

12.3.3. 25 ба түүнээс дээш жил хамт амьдарч, үр хүүхдээ зөв өсгөж хүмүүжүүлсэн гэр бүл болон гэр бүлд ээлтэй үйл ажиллагаа явуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, алдаршуулах;

12.3.4.аж ахуйн нэгж, байгууллага сайн дурын үндсэн дээр гэр бүлд зориулан бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ үнэ, тарифт хөнгөлөлт, тусламж үзүүлэхийг дэмжих;

12.3.5.орон нутгийн онцлогт тохирсон бусад арга хэмжээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХҮҮХЭД, ЭХ, ЭЦЭГТ ОЛГОХ МӨНГӨН ДЭМЖЛЭГ

13 дугаар зүйл.Хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг

13.1.Хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг /цаашид “мөнгөн дэмжлэг” гэх/ дараах төрөлтэй байна:

13.1.1.хүүхдийн мөнгөн дэмжлэг;

13.1.2.жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг;

13.1.3.хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг;

13.1.4.ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг;

13.1.5.олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн дэмжлэг.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан мөнгөн дэмжлэгийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

13.3.Энэ хуулийн 13.1-д заасан мөнгөн дэмжлэгийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

13.4.Засгийн газар мөнгөн дэмжлэгийн хэмжээг өөрчлөн тогтоохдоо хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтийн түвшинг харгалзан үзнэ.

13.5.Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөнгөн дэмжлэгийн үр нөлөөнд дөрвөн жил тутамд үнэлгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах бөгөөд Засгийн газар шаардлагатай гэж үзвэл мөнгөн дэмжлэгийг зогсоох, нэгтгэх, өөрчлөх эсэх асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ.

14 дүгээр зүйл.Хүүхдийн мөнгөн дэмжлэг

14.1.Хүүхдийн мөнгөн дэмжлэгийг хүүхдэд төрснөөс хойш 18 нас хүртэлх хугацаанд сар бүр олгоно.

14.2.Хүүхдийн мөнгөн дэмжлэгт хамрагдах хүсэлтийг хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхэд 16 насанд хүрсэн бол өөрөө сум, хорооны нийгмийн ажилтанд хандан биечлэн, эсхүл цахим хэлбэрээр гаргах бөгөөд хүсэлт гаргасан сараас нь тооцож олгоно.

14.3.Хүүхдийн мөнгөн дэмжлэгийг тухайн хүүхдийн нэр дээр нээлгэсэн арилжааны банкны дансаар дамжуулан олгох бөгөөд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд банканд данс нээлгэнэ.

14.4.Хүүхдийн мөнгөн дэмжлэгт хамрагдах эрх үүссэн боловч иргэнээс үл хамаарах шалтгаанаар тухайн төсвийн жилд дансанд нь ороогүй тохиолдолд нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага өглөг үүсгэж, дараагийн төсвийн жилд багтаан нөхөн олгоно.

14.5.Асрамжийн газарт амьдарч байгаа 14 хүртэлх насны хүүхдэд тухайн асрамжийн газар нь хадгаламжийн данс нээлгэж, хүүхдийн мөнгөн дэмжлэгийг банканд бүрэн хадгалуулна.

14.6.Асрамжийн газарт амьдарч байгаа 14 ба түүнээс дээш насны хүүхдийн мөнгөн дэмжлэгийн 80 хувийг банканд хадгалуулж, 20 хувийг хүүхэд өөрөө захиран зарцуулах зориулалт бүхий банкны харилцах дансыг нээлгэх бөгөөд энэ данс нь цахим карттай байна.

14.7.Энэ хуулийн 14.5, 14.6-д заасан хадгаламжийг харилцагч банктай байгуулсан гэрээний үндсэн дээр тухайн банк хариуцан хадгална.

14.8. Асрамжийн газар байрлах аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь хадгаламжийн бүртгэл, зарцуулалтад хяналт тавиж, хүүхдийг 16 нас хүрсний дараа тухайн банкны салбарт холбогдох бичиг баримтын хамт очиж өөрт нь хүлээлгэж өгнө.

14.9.Цагдан хоригдож байгаа, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа хүүхдийн нэр дээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын харьяа газар, хэлтэс банкинд хадгаламжийн данс нээлгэж, хүүхдийн хадгаламжийн дэвтрийг тухайн хорих анги байрлах аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага хадгалж, хүүхдийг суллагдсаны дараа өөрт нь хүлээлгэн өгнө.

14.10.Хүүхэд нас барсан тохиолдолд хадгаламжийн дэвтрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өв залгамжлагчид, хууль ёсны өв залгамжлагч байхгүй тохиолдолд Хүүхдийн төлөө санд хүлээлгэн өгнө.

14.11.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч эсхүл хүүхэд 16 насанд хүрсэн бол өөрөө Хүүхдийн төлөө санд хүүхдийн мөнгөн дэмжлэгээ шилжүүлэх хүсэлт гаргаж болно.

14.12.Энэ хуулийн 14.11-д заасан мөнгөн дэмжлэгээ шилжүүлэх хүсэлтийг сум, хорооны нийгмийн ажилтанд эсхүл цахим системээр дамжуулан гаргана.

14.13.Энэ хуулийн 14.11-д заасан шилжүүлэх хүсэлтээс татгалзаж хүүхдийн мөнгөн дэмжлэгээ дахин авахыг хүсвэл уг хүсэлтээ энэ хуулийн 14.2-т заасны дагуу гаргана.

15 дугаар зүйл.Жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг

15.1.Ниймийн даатгалын сангаас жирэмсний тэтгэмж авах эрх үүсэхгүй эх жирэмсний таван сартайгаас эхлэн хүүхэд төрүүлэх хүртэл буюу 5 хүртэлх сарын хугацаанд сар бүр мөнгөн дэмжлэг авах эрхтэй.

15.2.Эрүүл мэндийн байгууллага нь жирэмсэн эхийн эмнэлгийн хяналтад орсон тухай мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны цахим системээр дамжуулан нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

15.3.Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг авч байх хугацаандаа эхэд жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг авах эрх үүсвэл уг мөнгөн дэмжлэгийг олгоно.

16 дугаар зүйл.Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг

16.1.Төрүүлсэн болон үрчилж авсан 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцэг 36 хүртэлх сарын хугацаанд асарч байгаа хүүхдийн тооноос үл хамааран сар бүр хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг авах эрхтэй.

16.2.Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэгийг авч байсан эх, эцгийн аль нэг энэ хуулийн 16.1-т заасан тэтгэмж авах хугацаа дуусахаас өмнө ажилд орсон тохиолдолд мөнгөн дэмжлэгийг хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцэгт олгоно.

16.3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хугацаанд хүүхэд асарсны мөнгөн дэмжлэгийг давхардуулан олгохгүй.

16.4.Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг авч байх хугацаанд эх, эсхүл эцэгт түүний ажил олгогчоос урамшуулал, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, цагийн ажлын хөлс олгосон тохиолдолд тухайн орлогын талаарх ажил олгогчийн тодорхойлолтыг хянан үзэж, мөнгөн дэмжлэгийг нөхөж олгох эсэхийг шийдвэрлэнэ.

16.5.Энэ хуулийн 16.2-т заасан үндэслэлээр хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг нь зогссон эх, эсхүл эцэг хүүхдээ асрах шаардлагын улмаас ажлаасаа гарсан, урт хугацааны чөлөө авсан тохиолдолд хүсэлтээ дахин гаргаж хүүхэд асарсны мөнгөн дэмжлэгийг авах эрхтэй.

17 дугаар зүйл.Ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг

17.1.4 хүртэлх насны ихэр хүүхдэд нэг удаа мөнгөн дэмжлэг олгоно.

17.2.Ихэр хүүхдэд олгох мөнгөн дэмжлэгийг хүүхэд тус бүрээр тооцож олгоно.

17.3.3 болон түүнээс дээш ихэр хүүхдэд олгох мөнгөн дэмжлэгийн хэмжээг 2 ихэр хүүхдэд олгох мөнгөн дэмжлэгийн хэмжээнээс өндрөөр тогтоож болно.

18 дугаар зүйл.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн дэмжлэг

18.1.Дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн, бага хүүхэд нь 1 нас хүрсэн, “Эхийн алдар” одонгоор шагнагдсан эх бага хүүхдээ 18 нас хүртэлх хугацаанд жилд нэг удаа мөнгөн дэмжлэг авах эрхтэй.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасан "дөрөв болон түүнээс дээш хүүхэд төрүүлж өсгөсөн" гэдэгт бага хүүхэд нь нэг нас хүрэхэд дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй байсан бөгөөд үүнд тэр үед гурав хүртэлх насанд нь үрчлэн авсан хүүхэд, байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхэд хамаарах ба харин эхийн төрүүлж бусдад үрчлүүлсэн хүүхэд хамаарахгүй.

18.3.Энэ хуулийн 18.4.1-д заасан "зургаан хүүхэд төрүүлж өсгөсөн", 18.4.2-т заасан "дөрвөн хүүхэд төрүүлж өсгөсөн" гэдгийг энэ хуулийн 18.2-т заасан агуулгаар төсөөтэй хэрэглэж ойлгоно.

18.4.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг дараах одонгоор шагнана:

18.4.1.зургаан хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг "Эхийн алдар" нэгдүгээр зэргийн одонгоор;

18.4.2.дөрвөн хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг "Эхийн алдар" хоёрдугаар зэргийн одонгоор.

18.5.Энэ хуулийн 18.4.1, 18.4.2-т заасан одонгоор шагнах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

18.6.Энэ хуулийг хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө “Эхийн алдар” одонгоор шагнагдсан эх бага хүүхдийн нас харгалзахгүй жилд нэг удаа мөнгөн дэмжлэг авах эрхтэй.

19 дүгээр зүйл.Мөнгөн дэмжлэг олгохтой холбоотой харилцаа

19.1. Энэ хуулийн 13.1-д заасан мөнгөн дэмжлэг олгохтой холбоотой үйл ажиллагааг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн халамжийн ажилтан зохион байгуулна.

19.2.Мөнгөн дэмжлэгийг хүсэлт гаргасан өдрөөс эхлэн мөнгөн дэмжлэг авагчийн сонгосон арилжааны банк дахь дансаар дамжуулан олгоно.

19.3.Мөнгөн дэмжлэг авах эрх үүссэн боловч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тухайн онд мөнгөн дэмжлэгээ авч чадаагүй тохиолдолд дараа онд нь нөхөн олгоно. Нэг жилээс дээш хугацаагаар мөнгөн дэмжлэгээ аваагүй тохиолдолд нөхөн олгохгүй.

19.4.Хуурамч бичиг баримт бүрдүүлж мөнгөн дэмжлэг тогтоолгон авсан нь тогтоогдвол уг мөнгөн дэмжлэгийн олголтыг зогсооно.

19.5.Хуурамч бичиг баримт бүрдүүлсний улмаас илүү олгогдсон мөнгөн дэмжлэгийг нөхөн төлүүлэх тухай шүүхийн шийдвэр, эсхүл улсын байцаагчийн шийдвэр гарсан бол суутгал хийж болно.

19.6.Суутгалын хэмжээ нь сарын мөнгөн дэмжлэгийн 50 хувиас хэтрэхгүй.

19.7.Энэ хуулийн 19.5-д зааснаас бусад тохиолдолд мөнгөн дэмжлэгээс суутгал хийх, мөнгөн дэмжлэгийг барьцаалах, өр төлбөрт суутгахыг хориглоно.

20 дугаар зүйл.Хүүхдийн мөнгөн дэмжлэг олгохыг түдгэлзүүлэх, зогсоох.

20.1.Хүүхдийн мөнгөн дэмжлэгийг эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгохыг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ:

20.1.1.хүүхдийн эх, эцэг нь сураггүй алга болсон бөгөөд цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжилж байгаа;

20.1.2.хүүхдийг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.1-д заасан үндэслэлээр гэр бүлээс нь тусгаарласан;

20.1.3.эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй, хүүхдийн эрхийг зөрчсөн талаар хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт гарсан;

20.1.4.эх, эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоогдсон.

20.1.5.асрамжийн газарт тухайн сард шинээр ирсэн хүүхэд бүрийн мөнгөн дэмжлэгийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгохыг түр түдгэлзүүлэх талаар хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт гарсан.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, эсхүл хүүхдийн эрхийн улсын байцаагч нэн даруй нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

20.3.Хүүхдийн мөнгөн дэмжлэг олгохыг түдгэлзүүлсэн үндэслэл арилсан талаар хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүгнэлт, эсхүл шүүхийн шийдвэрийг үндэслэн түдгэлзүүлсэн хугацаа нь 6 сар хүртэл хугацаанд нөхөн олгоно.

20.4.Хүүхдийн мөнгөн дэмжлэг олгохыг энэ хуулийн 20.1-д заасны дагуу түдгэлзүүлсэн хугацаа нь 6 сараас дээш хугацаагаар үргэлжлэх бол Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.12-т заасан асралт гэр бүл, Гэр бүлийн тухай хуулийн 25.9-д заасан гэр бүлдээ авч асарч байгаа иргэн, 25.10-т заасан хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчид түдгэлзүүлсэн хугацаанаас тооцож нөхөн олгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТОГТОЛЦОО

22 дугаар зүйл.Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

22.1.Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

22.1.1.гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомж, төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

22.1.2.гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

22.1.3.гэр бүлийн хөгжлийг дэмжих, ээлтэй орчныг бий болгох чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааны зохицуулалтыг хангах;

22.1.4.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээг иргэн, гэр бүлд цахимаар, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлж, гэр бүлийн үйлчилгээний цахим системийг төрийн үйлчилгээний нэгдсэн системтэй уялдуулан ажиллуулах;

22.1.5.гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

22.1.6.хуульд заасан бусад чиг үүрэг.

23 дугаар зүйл.Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

23.1.Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.1.1.гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар гүйцэтгэсэн ажлын үр дүнг Засгийн газар, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өмнө хариуцан тайлагнах;

23.1.2.гэр бүлийн хөгжлийг дэмжих хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, статистик тоо мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний үндсэн дээр тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах;

23.1.3.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг төлөвлөн хэрэгжүүлэх, зарцуулалтад хяналт тавих;

23.1.4.аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

23.1.5.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх ажлыг холбогдох байгууллага, их, дээд сургуультай хамтран зохион байгуулах;

23.1.6.гэр бүлийг эвлэрүүлэн зуучлах эрх бүхий байгууллага, мэргэжилтэнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

23.1.7.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээд, гэр бүл, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжих, хамтран ажиллах.

23.1.8.хуульд заасан бусад чиг үүрэг.

23.2.Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гэр бүлийн үйлчилгээний цахим системийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.2.1.цахим системээр дамжуулан үзүүлэх үйлчилгээний хүрээ, нөхцөл, хэрэглэгчийн нэвтрэлт, танилт, мэдээлэл солилцох, зөвшөөрөл олгохтой холбоотой үйл ажиллагааны аргачлал, зааврыг батлах;

23.2.2.нийтэд нээлттэй мэдээллийн порталын контентыг мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллага, шинжээчдийн оролцоотойгоор боловсруулах, батлах, хөтөлж, удирдах;

23.2.3.цахим системийн үйл ажиллагаанд хувь хүний нууц, мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих;

23.2.4.цахим системийн программ хангамж, техникийн дэд бүтцийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах, аюулгүй байдлыг техникийн түвшинд хангах засвар үйлчилгээ, техникийн дэмжлэгийг үзүүлэх;

23.2.5.цахим системийн программ хангамжийг хөгжүүлэх, шинэчлэх, сайжруулах;

23.2.6.гэр бүлд дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх төрийн байгууллагын мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг хангах үүднээс холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах;

24 дүгээр зүйл.Аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын чиг үүрэг

24.1.Аймаг, дүүрэг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.1.1.гэр бүлийн талаарх бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, биелэлтийг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын өмнө тайлагнах;

24.1.2.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж ажиллах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, гэрээний биелэлтийг дүгнэх;

24.1.3.гэр бүл угийн бичгээ хөтлөхөд нь мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг аймаг, дүүргийн соёлын газар, сум, дүүргийн соёлын төвтэй хамтран хэрэгжүүлэх;

24.1.4.Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг удирдлагаар хангах;

24.1.5.гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамруулах, холбон зуучлах;

24.1.6.гэр бүлд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавих;

24.1.7.хүн, хуулийн этгээдтэй гэр бүлд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаа, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;

24.1.8.хуульд заасан бусад чиг үүрэг.

25 дугаар зүйл.Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны чиг үүрэг

25.1.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан сум, хорооны хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

25.1.1.гэр бүлийн боловсролыг дэмжих үйл ажиллагааг боловсролын сургалтын байгууллага, соёлын болон насан туршийн суралцахуйн төвтэй хамтран хэрэгжүүлэх;

25.1.2.гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвтэй хамтран хэрэгжүүлэх;

25.1.3.гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээг кейс менежментийн үе шатны дагуу үзүүлэх;

25.1.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

26 дугаар зүйл.Орон нутгийн чиг үүрэг

26.1.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

26.1.2.аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичиг, хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн шатны орон нутгийн төсвийн төсөлд гэр бүлийн хөгжил, сайн сайхан байдлыг дэмжих үйл ажиллагааг тусгах;

26.1.2.гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар энэ хуульд заасан орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгаж батлах;

26.1.3.орон нутгийн гэр бүл, хүн амын бүлгийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

26.1.4.хуульд заасан бусад чиг үүрэг.

26.2.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

26.2.1.гэр бүлийг дэмжих бодлого, хууль тогтоомж, Засгийн газар болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

26.2.2.тухайн нутаг дэвсгэрт байгаа соёл, спорт, хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв болон бусад боломжтой байгууламжийг түшиглэн гэр бүлд зөвлөгөө, мэдээлэл өгөх, гэр бүлийн боловсрол олгох, гэр бүл, түүний гишүүдийн хөгжлийг дэмжих бусад хөтөлбөр бүхий гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээг гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн байгууллагатай хамтран үзүүлэх;

26.2.3.барилга байгууламж, дэд бүтцийг гэр бүлд ээлтэй байдлаар төлөвлөх, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, зам, гудамж, талбайн гэрэлтүүлэг, хяналтын камер байрлуулалтыг сайжруулах, орчны аюулгүй байдлыг хангах;

26.2.4.холбогдох хүсэлтийг харгалзан иргэнийг орон байртай болгох, иргэнийг малжуулах, ажлын байртай болгох, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авах;

26.2.5.гэр бүлийн боловсрол, соёлыг түгээн дэлгэрүүлэх, гэр бүлийн гишүүдийн оролцоог хангасан, гэр бүлд ээлтэй үйл ажиллагаа зохион байгуулахад иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, санаачилгыг дэмжих;

26.2.6.гэр бүлд ээлтэй орчныг бий болгох, гэр бүлд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, үйлчилгээ, үйл ажиллагаа явуулсан хүн, хуулийн этгээдийг орон нутгийн хөгжлийн бодлогын дагуу дэмжих.

26.2.7.хуульд заасан бусад чиг үүрэг.

27 дугаар зүйл.Гэр бүл, хүн ам зүйн судалгаа хийх

27.1.Гэр бүл, хүн амын өсөлтийг дэмжих урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлт, стратегийг тодорхойлох зорилгоор гэр бүл, хүн ам зүйн суурь судалгааг Үндэсний статистикийн хороо, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний дэргэдэх сургалт, үнэлгээ, судалгааны байгууллагатай хамтран таван жил тутамд хийнэ.

28 дугаар зүйл.Гэр бүлийн үйлчилгээний цахим мэдээллийн систем

28.1.Гэр бүлийн үйлчилгээний цахим мэдээллийн систем /цаашид “цахим систем” гэх/-ийг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллуулна.

28.2.Цахим системд мэдээлэл бүртгэх, баяжуулах, баталгаажуулах чиг үүргийг хариуцсан албан хаагч мэдээллийн үнэн, бодит байдлыг хариуцаж ажиллана.

28.3.Цахим систем нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасан мэдээлэл хариуцагчтай байна.

28.4.Цахим системийг ашиглан дараах үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлнэ:

28.4.1.гэр бүлийн цахим бүртгэлд үндэслэн төрийн үйлчилгээг урьдчилан тодорхойлж, мэдэгдэх;

28.4.2.төрийн үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх;

28.4.3.гэр бүлд хэрэгцээтэй мэдээлэл, зөвлөгөөг хүртээмжтэйгээр хүргэх;

28.4.4.иргэн, гэр бүл, олон нийтэд чиглэсэн гэр бүлийн боловсрол олгох сургалт, нөлөөллийн зөвлөгөө, мэдээллээр хангах;

28.4.5.хууль тогтоомжид заасан бусад.

28.5.Цахим системийн үндсэн мэдээллээс бусад мэдээллийг хуваалцах, үйлдэл хийхэд Хүний хувийн мэдээлэл хамгаалах хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу иргэн, гэр бүлээс цахим зөвшөөрөл авсан байна.

28.6.Цахим системийн хэрэглэгч гэр бүлийн насанд хүрсэн бусад гишүүний өмнөөс үйлчилгээ авах хүсэлт гаргах тохиолдолд тухайн гэр бүлийн гишүүний цахим зөвшөөрлийг авна.

28.7.Цахим систем нь мэдээллийн нэгтгэл, боловсруулалт хийхэд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хуулийг дагаж мөрдөнө.

28.8.Мэдээллийн ашиглалт, хадгалалт, хуваалцах талаарх тодорхой мэдээллийг хэрэглэгчдэд өгнө.

28.9.Хувийн мэдээлэлд зөвшөөрөлгүй хандах, өөрчлөх, задруулах, устгахаас хамгаалж, техникийн болон зохион байгуулалтын найдвартай аюулгүй байдлыг хангана.

28.10.Энэ хуулийн 28.4-т заасан үйлчилгээг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24.2 дахь хэсэгт заасан төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан үзүүлнэ.

28.11.Гэр бүлийн үйлчилгээний цахим мэдээллийн системийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах, түүнийг хөгжүүлж шинэчлэх, кибер аюулгүй байдлыг хангах асуудлыг Төрийн цахим үйлчилгээний асуудал хариуцсан байгууллага хариуцна.

ТАВДУГААР БҮЛЭГ САНХҮҮЖИЛТ БА ХЯНАЛТ

29 дүгээр зүйл. Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт

29.1. Гэр бүлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг дараах байдлаар шийдвэрлэнэ:

29.1.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр;

29.1.2. төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн санхүүжилтээр;

29.1.3. Зээлийн батлан даалтын сангийн мөнгөн хөрөнгөөр;

29.1.4. дараа эргэн төлөгдөх нөхцөлөөр байгуулсан гэрээний үндсэн дээр банкны зээл болон хувийн хэвшлийн байгууллагаас гаргах хөрөнгөөр;

29.1.5. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан орон нутгийн сангийн хөрөнгөөр;

29.1.6. хүн, хуулийн этгээд, гадаад улс, олон улсын байгууллагын хандив тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр;

29.1.7. хуульд заасан бусад эх үүсвэр.

29.2. Энэ хуулийн 13.1, 23.1.5, 27.1, 28.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг Гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусгаж санхүүжүүлнэ.

29.3. Засгийн газрын гишүүд эрхлэх асуудлын хүрээнд энэ хуулийн 9, 10, 11 дүгээр зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажиллагааны зардлыг жил бүрийн төсөвт тусгуулах арга хэмжээг авна.

29.4. Энэ хуулийн 9, 11 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааны жишиг зардал, хэрэгжүүлэх заавар, аргачлалыг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

29.5. Орон нутаг энэ хуулийн 7.2, 12.3, 26 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

29.6. Хүн, хуулийн этгээд, гадаад улс, олон улсын байгууллага гэр бүлд ээлтэй орчин, үйлчилгээ, дэд бүтцийг бий болгох, гэр бүлийн хөгжлийг дэмжих

чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг санхүүжүүлэх, төр, орон нутгаас зохион байгуулах арга хэмжээнд хандив, тусламж үзүүлж болно.

30 дугаар зүйл. Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих

30.1. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу энэ хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийнэ.

30.2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль тогтоомжийн биелэлтийн үр дүнг жил бүр Засгийн газарт тайлагнана.

30.3. Холбогдох байгууллага, албан тушаалтан нь 30.2-т заасан тайлан, мэдээллийн ил тод байдлыг хангаж, үнэн зөв байдлыг хариуцна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

31 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

31.1. Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

31.2. Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

32 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

32.1. Энэ хуулийг 2028 оны 01 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АВТО ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Авто тээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 17^{1.4} дэх хэсэг нэмсүгэй:

“17^{1.4}.Энэ хуулийн 17^{1.3}-т заасан орлогыг Хүүхдийн төлөө санд төвлөрүүлнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.16 дахь хэсэг:

“13.16.0-18 хүртэлх насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг улирал бүр тэтгэмж авах эрхтэй бөгөөд хүүхдийн тоонд төрүүлсэн болон үрчлэн авсан, асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа хүүхдийг хамааруулна.”

2/13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт:

“13.1.7.гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж.”

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн “энэ хуулийн 13.5.9-д заасан иргэнд жилд нэг удаа” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.13, 13.14, 13.15 дахь хэсгийг, мөн зүйлийн 13.1.6, 13.5.9 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОЛОН ХҮҮХЭД ТӨРҮҮЛЖ ӨСГӨСӨН ЭХИЙГ УРАМШУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Орон сууцны тухай тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.4.4 дэх заалт нэмсүгэй:

“9.4.4.ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай зэрэг гэр бүлд ээлтэй орчныг хүртээмжтэйгээр төлөвлөх.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 97 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 97.2 дахь хэсэг нэмсүгэй:

“97.2.Энэ хуулийн 97.1.2, 97.1.6-д заасан нийтээр амрах баярын өдрүүд долоо хоногийн бямба, ням гарагийн аль нэг өдөр, эсхүл бямба, ням гарагт дараалан тохиосон тохиолдолд дараагийн ажлын эхний нэг, эсхүл хоёр өдөр нийтээр нөхөн амарна.”

2 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 144 дүгээр зүйлийн 144.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“144.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүний байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага эсхүл нийт ажилтны дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй аж ахуйн нэгж, байгууллагын эсхүл хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн; ажил үйлчилгээг гэрээгээр байнга худалдан авах зэргээр тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн ажил олгогчийг энэ хуулийн 144.3-т заасан төлбөрөөс чөлөөлж, хөнгөлж болно.”

3 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 88 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 88.1.10 дахь заалт нэмсүгэй:

“88.1.10.Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасны дагуу олгож байгаа мөнгөн дэмжлэг.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭХ, ЭЦЭГ, ОЛОН ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ, ЭЦЭГТ ТЭТГЭМЖ ОЛГОХ
ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдөр баталсан Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль батлагдсантай холбогдуулан Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөхөөс өмнө Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж авахаар тогтоолгосон тэтгэмжийг эх, эцэг, асран хамгаалагч эрх дуусах хүртэл хугацаанд сар бүр хэвээр олгох арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ**

**ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙГ
БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025 он**

АГУУЛГА

Удиртгал	3
НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ	3
1.1.Тодорхойлж шийдвэрлэх гэж буй асуудлын эрх зүйн зохицуулалт, мөн чанар, цар хүрээ	3
1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж байгууллага, бусад этгээд	7
1.3.Асуудал үүссэн шалтгаан нөхцөл	7
Асуудал 1.Гэр бүлийг дэмжих шаардлага	11
Асуудал 2.Эх, хүүхдэд дэмжлэг үзүүлэх шаардлага	12
Асуудал 3.Гэр бүлд цогц үйлчилгээ үзүүлэх	19
Асуудал 4.Гэр бүлд ээлтэй орчин	20
ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ	21
2.1.Гэр бүл, эх, хүүхдэд төрөөс үзүүлэх дэмжлэг	21
2.2.Гэр бүлд үзүүлэх нийгмийн үйлчилгээ	22
2.3.Гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх	22
2.4.Гэр бүлийг дэмжих тогтолцоо	23
ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛ ДЭЭР ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ	25
ДӨРӨВ.СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ	28
4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	28
4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	29
4.3.Нийгэмд үзүүлэх нөлөө	31
4.4.Байгаль орчинд үзүүлэх нөлөө	32
4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.	33
ТАВ.ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	35
ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ	51

Удиртгал

Гэр бүлийг дэмжих тухай хуулийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал” -ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид Аргачлал гэх/ 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт заасан хууль тогтоомжид урьдчилан тандан судлах ажиллагааг тус аргачлалын 2 дугаар зүйлийн 2.1-т заасан дараах үе шатаар хийсэн болно: Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг, сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан судлах;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

Дээрх дарааллын дагуу нэгдүгээрт одоогийн хууль тогтоомжийн хүрээнд үүсэж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Асуудлыг тодорхойлсны дараагаар асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгоо томъёолж, тухайн зорилгод хүрэх хувилбарыг тогтоосон. Тухайн үе шатанд асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан дүгнэж хамгийн оновчтой хувилбарыг сонгон авч үр нөлөөг судалсан.

Эцэст нь тухайн судалгааны хувилбаруудаас сонгон авсан хувилбарт үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

1.1.Тодорхойлж шийдвэрлэх гэж буй асуудлын эрх зүйн зохицуулалт, мөн чанар, цар хүрээ

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй”¹ гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй

¹ Хүний эрхийн түгээмэл тунхаглал.

тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”² гэж заасан нь төрийн гэр бүлийг хамгаалах уургийг тодотгосон байна.

Гэр бүл, гэр бүлийн гишүүдийн эрх ашгийг хамгаалах талаар Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Нийгмийн халамжийн тухай зэрэг хууль, холбогдох журам, дүрэм, стандарт, эрх зүйн баримт бичиг хэрэгжиж байна.

Монгол Улс нь Үндсэн хуульдаа тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бүрдүүлэх үүргийнхээ дагуу Гэр бүлийн тухай бие даасан хуулийг³ 1999 онд батлан хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хуулиар гэр бүлийн харилцаанд оролцогч иргэний хувийн эрх зүйн зохицуулалтыг шийдвэрлэж байна.

Гэр бүлийн тухай хууль нь 1999 онд батлагдсан бөгөөд хувийн эрх зүйн асуудлуудыг зохицуулж буй суурь хууль юм. Нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь гэр бүлийн харилцаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээс илүүтэй салбарын харилцааг зохицуулсан, бусад хуулийн шинэчлэлийг дагалдан тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон. *Тухайлбал*, 2002 онд Иргэний хууль, 2011 онд Нотариатын тухай, 2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай, 2016 онд Хүүхэд хамгааллын тухай, 2018 онд Иргэний улсын бүртгэлийн тухай, 2021 онд Соёлын тухай хууль батлагдсантай холбоотой Гэр бүлийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.⁴

Тус хуулиар гэрлэлтийн үндсэн нөхцөл, гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, түүний үр дагавар, эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа, тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа, хүүхдийг асран хамгаалах, үрчлэхэд холбогдох харилцааг зохицуулна.

Нийгмийн хөгжлийн чиг хандлага өөрчлөгдөж, гэрлэх, гэрлэлт цуцлах, хүүхдийн эрх, хууль ёсны эрх ашиг хөндөгдөх, зөрчигдөх, сэргээх зэрэг харилцаа ихсэж, үүнээс үүсэх үр дагаврыг Гэр бүлийн тухай хуулиар нарийвчлан зохицуулахгүй байна. Иймээс сүүлийн 10 гаруй жил гэр бүлийн хувийн эрх зүйн дор дурдсан харилцааг боловсронгуй болгохоос ажиллаж, гэр бүлийн дор дурдсан харилцааг Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулгаар шинээр зохицуулахаар тусгасан байна. Үүнд:

- гэр бүлийн гишүүдийн хөрөнгийн эрх буюу гэрлэгчдийн дундаа хэсгээр өмчлөх, эсхүл хамтран өмчлөх эд хөрөнгийн эрхийн зохицуулалтыг сайжруулах, энэ хүрээнд хүйс солиулах нь гэрлэлтэд ямар үр дагавар үүсгэх, тээгч эхээр хүүхэд тээлгэх, зохиомлоор үр суулгах нь гэр бүл, өв залгамжлалын эрх зүйгээр хэрхэн зохицуулагдах;
- гэрлэгчдийн эрх, үүргийн нарийвчлах, гэр бүлийн гишүүдийн өмнө хүлээн хариуцлагыг нэмэгдүүлэх;
- гэрлэлт цуцлахад гэр бүлийн гишүүдийн эрх ашиг хөндөгдөх, зөрчигдөх нөхцөл байдал үүсэж байгааг анхаарч, гэрлэлт цуцлах, дуусгавар болох,

² Монгол Улсын Үндсэн хууль 1992.

³ Гэр бүлийн тухай хууль 1999.

⁴ С.Сүхбаатар, Б.Энх-Амгалан, and Х.Санчир, *Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, Хувийн эрх зүйд холбогдох судалгааны тайлангийн эмхэтгэл XIII боть* (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2022), 127.

хүчингүй болгох, сэргээх зэрэг асуудалд үүсэх үр дагаврыг тооцоолж, гэр бүлийн гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг зөрчихгүй байх зохицуулалтыг хуульд тодорхой тусгах;

- Мөн Иргэний хуульд гэрлэгчдийн эд хөрөнгийн эрхийн асуудлыг тодорхойлсныг Гэр бүлийн тухай хуульд дэлгэрүүлж баталгаажуулаагүйг баталгаажуулж, гэрлэгчдийн болон гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгө, эрх ашгийг хамгаалах, гэрлэлтийн гэрээний зохицуулалтыг тусгах;
- Хүүхэд гэр бүлийн гишүүн болохын хувьд хамтран өмчлөх дундын өмчтэй байх, үл хөдлөх хөрөнгө, үнэт эдлэл эзэмших эрхийг хуулиар баталгаажуулан хүүхдийн өмч байхаар хуульчилж, түүнийг захиран зарцуулах харилцааг зохицуулах;
- гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтран амьдарч байгаа хүмүүсийн эрх, үүргийг тодорхойлох цаашлаад эд хөрөнгө хуваах, хүүхэд асрамжлахын маргаан үүсэх тохиолдолд үүсэх үр дагаврыг зохицуулах;
- Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор гэрлэхийг хүсэгчид хоорондоо садан төрлийн холбоотой эсэхээ мэдэх боломжийг хангах зохицуулалт бүрдүүлэх;
- хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд шаардах боломжийг хангах, эцэг, эхийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, мөн эцэг, эх тогтоолгох асуудлыг тодорхой болгож, хүүхдийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах асуудлыг оновчтой зохицуулах;
- эцэг, эх байх эрхийг хассан тохиолдолд түүнийг буцаан сэргээх, эсхүл эрхийг нь тодорхой хугацаагаар хязгаарлах зэрэг оновчтой зохицуулалт хийх;
- нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагын дагуу нөхөн үржихүйн тусгай аргыг хэрэглэж буюу тээгч эх, эсийн донор ашиглаж төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох харилцааг хуульчлах;
- хүүхдийн тэтгэлгийг тэтгэлэг авагчийн нөхцөл, тэтгэлэг төлөгчийн орлого зэрэгтэй уялдуулж, эрх бүхий байгууллагаас батлах аргачлалаар шүүх тогтоох шинэлэг зохицуулалт бий болгох;
- хүүхдийн аливаа эрх ашиг хөндөгдөж байгаа тохиолдолд зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор үрчлэх эсэх асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх;
- гадаадын иргэнтэй гэр бүл болох, гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж, тэтгэлэг, хөрөнгийн маргааныг шийдвэрлэхэд олон улсын чиг хандлага, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцсэн эрх зүйн зохицуулалт бий болгох.

Дээр дурдсанаас харахад Гэр бүлийн тухай хуулиар шийдэх гэр бүлийн харилцааны асуудлууд нь гэр бүлийн эрх зүйн харилцааны асуудал, гэрлэгч иргэдийн хувийн эрх зүйн хүрээний асуудлууд байгаа юм. **Гэтэл гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн хөгжил, сайн сайхан байдлыг дэмжих** талаарх эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Гэтэл нийгмийн анхан шатны нэгж болсон гэр бүлийг бэхжүүлэх, Гэр бүлийг төрөөс дэмжих шаардлага байна. Энэ талаар энэхүү тандан судалгааны “1.3 Асуудал үүссэн шалтгаан нөхцөл”-д тодорхой дурдах болно.

Монгол Улсад "Төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого 2003 он"⁵, "Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого 2016 он"⁶ хэрэгжиж байсан боловч Монгол Улсын Их Хурлын 2020 оны 45 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд⁷ нийцүүлэн 2021 онд хүчингүй болгосон.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" 52 дугаар тогтоолын⁸ 1 дүгээр хавсралтын Зорилтын 2.3-т "Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ." гэж заасан. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.1.2-д "Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, "Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.", 2.1.1.3-т "Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ.", 2.1.1.4-д "Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ." гэж тус тус заасан нь Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах хууль эрх зүйн үндэслэл болж байна.

Түүнчлэн Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлийн хүрээнд халамжийн хөтөлбөрүүдийг зорилтот хэсэгт чиглүүлж харин нийтлэг хэлбэрээр төрөөс эх, хүүхэд, гэр бүлд үзүүлж байгаа тэтгэмж, тусламж, урамшууллын бодлогыг нийгмийн халамжийн хууль тогтоомжоос салгаж тусдаа хуулиар зохицуулах шаардлага бий болсон. Эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төрөөс хамгаалахад чиглэсэн нийгмийн халамжийн 6 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

- ✓ Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай 2011 он;
- ✓ Нийгмийн халамжийн тухай 2012 он;
- ✓ Ахмад настны тухай 2017 он;
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 2016 он;
- ✓ Алдар цолтой ахмад настанд нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай 2017 он;
- ✓ Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай 2017 он.

Эдгээрээс Олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай⁹, Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай¹⁰ хуулийн хүрээнд жирэмсэн болон 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхчүүдэд сар бүр тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эхийг Эхийн алдар одонгоор урамшуулж жил бүр тэтгэмж олгох, Мөн Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд 0-18 хүртэлх насны хүүхдэд сар бүр мөнгөн тэтгэмж олгож байгаа нь хүн амын өсөлтийг дэмжих, эх, хүүхдийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ тул Гэр

⁵ Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого. УИХ-ын тогтоол.

⁶ Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай. Монгол Улсын Засгийн газрын тогтоол.

⁷ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль.

⁸ Монгол Улсын Их Хурлын тогтоол, «Алсын Хараа-2050" Монгол Улсын Урт Хугацааны Хөгжлийн Бодлого Батлах Тухай», accessed 16 Аравдугаар сар 2023 <https://legalinfo.mn>.

⁹ Олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай 2010.

¹⁰ Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай 2017.

бүлийг дэмжих тухай хуулийн төслийн хүрээнд боловсруулах хууль зүйн үндэслэлтэй гэж үзэж байна.


1.2.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж байгууллага, бусад этгээд

Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулан батлуулснаар нийгмийн аливаа бүлэг, иргэн, аж ахуйн нэгжийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхгүй бөгөөд гэр бүлийг дэмжих эрх зүйн орчин бүрдэж, санхүүгийн эх үүсвэр, нөөц, нөөцийн хуваарилалт тодорхойлогдоно. Гэр бүлээр дамжин Монгол Улсын нийт хүн амын эрх, хууль ёсны эрх ашиг сонирхол хөндөгдөнө.

1.3.Асуудал үүссэн шалтгаан нөхцөл

Манай улс хүн амаа өсгөх, төрөлтийг дэмжих зорилгоор олон хүүхэдтэй эхчүүдэд хүүхдийн тоог харгалзан тэтгэмж олгох арга хэмжээг хэрэгжүүлж байсан. Тухайлбал, БНМАУ-ын Ардын Их Хурлын 1962 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн чуулганаар “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдэд улсаас олгох Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хууль” батлагдаж уг хуулиар 3 ба түүнээс дээш хүүхэдтэй эхчүүдэд хүүхдийн тоог харгалзан 300-800 төгрөгийг жилд нэг удаа олгож байсан. Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1971 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 140 дүгээр зарлигаар Олон хүүхэдтэй эхчүүдэд улсын тэтгэвэр олгох журамд өөрчлөлт оруулж, төрүүлж өсгөсөн 4 ба түүнээс дээш тооны бага насны олон хүүхэдтэй эхэд 16 хүртэл насны хүүхдийн тоог харгалзан жилд 1 удаа тэтгэмж олгож байжээ. Энэхүү арга хэмжээ нь манай улсын хүн амыг өнгөрсөн зуунд эрчимтэй өсөхөд чухал нөлөө үзүүлсэн байна. Хүн амын өсөлтөд төрөлт чухал нөлөө үзүүлдгийг доорх хүснэгтээс харж болно. Хэдийгээр сүүлийн жилүүдэд эх хүүхдийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрүүдийг нэмэгдүүлж байгаа ч төрөлтийн түвшин буурч байна. Ялангуяа 2016 оноос хойш тогтмол буурч байна.

Зураг 1. Монгол Улсын төрөлтийн тоо мэдээлэл, 1963-2023 он



Эх сурвалж: УСК, Статистикийн амлалт, 1960-2022, 2023.12.12.2023


Эх сурвалж: Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, ХХҮЕГ

Төрөлттэй холбоотойгоор 2010 онд 1.6 хувь байсан хүн амын жилийн дундаж өсөлт 2015 онд 2.1 хувь хүртэл өссөн хэдий ч 2023 онд 1.4 хувь болж буурсан байна. Монгол Улсын хүн амын өсөлтийн хувь 2033 он хүртэл тогтмол аажмаар жилд дунджаар 0.1 нэгж хувиар буурсаар, 2036-2046 он хүртэл аажмаар өсөх боловч 2050 онд буурч 1.3 хувь болно гэж¹¹ тооцоолсон.

2023 оны байдлаар Монгол Улсын 3,504,741 хүн ам нь 983,485 мянган өрхөд бүртгэгдэн амьдарч байгаа бөгөөд нэг өрхөд 3.56 хүн ногдож байна. 2020-2023 онд жилд дунджаар 21,409 өрх айл шинээр, үүнээс 2023 онд хамгийн их буюу 41,938 өрх айл шинээр нэмэгдсэн байна. Нийт өрхөд 18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхийн тоо 6.1 хувийг, өрх толгойлсон ганц бие эцэг, эх 8.7 хувийг, үүнээс өрх толгойлсон эх 7.1 хувийг, өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настан 5 хувийг тус тус эзэлж байна.

Монгол Улсад 0-18 насны хүүхэдтэй өрхийн тоо 567,000 байгаа бөгөөд энэ нь нийт өрхийн 57.6 хувийг эзэлж байгаа бөгөөд хүүхэдтэй нэг өрх дунджаар 2.18 хүүхэд ногдож байна.

Зураг 2. Гэрлэлт, цуцлалтын байдал



Улсын хэмжээнд 2020-2023 онд жилд дунджаар 16,338 хос гэрлэлтээ бүртгүүлсэн бол 4009 хос гэрлэлтээ цуцлуулсан байна. 2023 онд гэрлэлтээ бүртгүүлсэн хосын тоо 17,408 байж, өмнөх оноос 116-аар буюу нэг орчим хувиар буурсан бол гэр бүл цуцлалт 4776 болж, өмнөх оноос 4,9 хувиар буюу 223-аар нэмэгджээ.

Хувь хүний төлөвшил, хүмүүжил, нийгэмшил, соёл, ёс суртахуун, зан ааш, дадал зуршил, үзэл хандлагын 70% нь төрөлх гэр бүлийн орчиндоо бүрэлдэн боловсордог бөгөөд энэ үүднээс хүний хөгжлийн анхдагч хамгийн чухал орчин бол гэр бүл юм.¹² Гэр бүлийн асуудлыг цогцоор нь онол, практикийн түвшинд судалж хариулт өгөх, төрийн бодлого үйл ажиллагаанд тусгах практик зөвлөмж гаргах, хүндрэл бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох хэрэгцээ, шаардлага гарч байна.

Гэр бүлийн харилцааны өнөөгийн хэв маяг, хөгжил, өөрчлөлт, цаашдын чиг хандлага, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох зорилготойгоор 2010, 2019 онд “Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал” суурь судалгааг тус тус хийсэн байдаг. Судалгаанаас үзэхэд ойрын 5-10 жилд манай оронд өрх гэр

¹¹ Монгол Улсын Хүн амын 2020-2050 оны шинэчилсэн хэтийн тооцоо, ҮСХ, 2021 он

¹² Монгол Гэр Бүлийн Бүтэц Хэв Маяг, Харилцааны Онцлог, Тулгамдаж Буй Асуудал, accessed 6 Аравдугаар сар 2024 www.gerbul.mn.

бүлийн харилцааны асуудал улам нарийсан төвөгтэй болж, шийдвэрлэх асуудлууд дэвшин гарч ирэх хандлага ажиглагдаж буйг дурджээ. Мөн архидалт, ядуурал, үнийн хөөргөдөл, мөнгөний ханшны уналт, шилжих хөдөлгөөн, гадаадад гарч ажиллах, даяаршил зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс гэр бүлийн зөрчилд нөлөөлдөг гэж үзсэн.¹³

Сүүлийн жилүүдэд Монголын өрх, гэр бүлийн хэв маягт өөрчлөлт орж нийлмэл, дан, өрөөсгөл, дахин гэрлэсэн, дагавар хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, улс дамнасан, олон соёлт, ижил хүйстэн, хамтран амьдрах, бүлгээр амьдрах зэрэг гэр бүлийн хэлбэрүүд бий болж байгаа бөгөөд үүний улмаас гэр бүлүүдэд санхүүгийн, сэтгэл зүйн, эрүүл мэндийн, боловсролын, харилцааны олон тулгамдсан асуудлууд бий болж, гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салалт нэмэгдэж, үүний хохирогч нь ихэвчлэн хүүхэд, эмэгтэйчүүд болж байгаа зэрэг сөрөг үр дагаврууд нэмэгдэж байна.¹⁴

Мөн судлаач Б.Оюун-Эрдэнийн үзэж байгаагаар “Монгол улсад явагдсан нийгмийн шилжилтийн үе болон дэлхий дахины даяарчлал, соёлын глобалчлал нь монгол гэр бүлийн бүтэц, хэв маягт ихээхэн өөрчлөлтийг авчирч байна.”¹⁵

Тэрээр, <<Монгол гэр бүл оршин тогтнож ирсэн түүхэн хугацаанд иргэншлийн өвөрмөц дүр төрхөөрөө ураг төрлийн холбоонд үндэслэн уламжлалт хүмүүжил ёс заншил, хуулийн хэм хэмжээгээр гэр бүлийн боловсролыг хойч үедээ олгож, тэднийг амьдралын ухаанд сургаж ирсэн. Харин орчин үед амьдралын хэв маяг өөрчлөгдөн гэр бүлийн асуудал олон талтай болсон нөхцөлд цөөн хүн амтай манай орны хувьд гэр бүлийн боловсролыг шинжлэх ухааны үндэслэлтэй, гэр бүлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байдлаар иргэдэд олгох нь улс орон хийгээд хүний хөгжлийн чухал хөшүүрэг болох юм.

Иргэдэд гэр бүлийг хэвийн харилцаатай тогтвортой авч явахад зайлшгүй шаардлагатай боловсролыг олгохын зэрэгцээ тэдний амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон өөрөөр хэлбэл хэрэгцээнд нь тулгуурласан гэр бүлийн боловсролыг олгох шаардлагатай байна.

Гэр бүлийн талаарх үзэл хандлага хэвшмэл байдлаас аажмаар өөрчлөгдөх байдал ажиглагдаж байна. Ингэхдээ гэр бүлийн эрхэм нандин чанар алдагдаж, үнэнч бус байдал, материаллаг сонирхолд тулгуурлах, гэр бүлийн хариуцлагаас зайлсхийх, бэлгийн харилцааны хувьд чөлөөт байдлыг эрхэмлэсэн, аминч үзэл давамгайлах хандлага бий болж байна.

Эцэг эхчүүд хүүхдээ анхаарах, тэднийг хайрлаж халамжлах болон эдийн засгийн нөхцөл бололцоог хангах тал дээр ихээхэн анхаарал тавьдаг боловч хүүхэдтэйгээ харилцах, хүмүүжүүлэх арга барилаа сонгох тал дээр нэлээд алдаж байна. Иймд эцэг эхийн хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлогийг харгалзан тэдэнтэй

¹³ ШУА-ийн ФСХ, УБИС Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, УБ (2010).

¹⁴ Ц.Норовдондог (Ph.D) and Д.Аюуш, Гэр бүл салалт, гэр бүлийн харилцааны зөрчил шийдвэрлэлтийн талаарх бусад орнуудын туршлага ба Монгол Улсын нөхцөл байдал (Харьцуулсан судалгаа), УБ, «Парламент» судалгааны эмхэтгэл., Боть 39 (УБ: Улсын Их Хурлын Тамгын газар Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн, 2022), 324.

¹⁵ Б.Оюун-Эрдэнэ, «Монгол гэр бүлийн бүтэц хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал», *Proceedings of the Mongolian Academy of Sciences* 52 (15 Наймдугаар сар 2017): 37.

зөв үлгэр дуурайл бүхий харилцаагаар хүүхдийг хөгжүүлж, төлөвшүүлэхэд туслах “сайн эцэг эх”-ийн сургалт, мэдээллийн үйл ажиллагааг цаашид тогтолцоот байдлаар хөгжүүлэх нь чухалчлагдаж байна.

Хөдөөгийн нийгмийн суурь үйлчилгээний хангамж, материаллаг баазыг сайжруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих, ингэхдээ засаг захиргааны олон нэгжид заавал тархаан суурьшуулах шаардлагатай эсэх талаарх сүүлийн үеийн судлаачдын саналыг харгалзан үзэх. Нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй ядуу болон захын хорооллын өрхийн иргэд, түүнчлэн шилжин ирсэн гэр бүлд эрүүл мэнд, боловсрол зэрэг төрөл бүрийн сургалт, ажил хөдөлмөр эрхлэх чиглэлээр үзүүлж буй төрийн үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх шаардлагатай байна.

Гэр бүлийн асуудлыг тусгайлан хариуцдаг төрийн тогтолцоог бий болгох нь гэр бүлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх салбар дундын зохицуулалтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болно>> гэж дүгнэсэн.

Гэр бүлийн хосуудын нас 30 хүрээгүй, хамтын амьдрал нь 5 жилээс хэтрээгүй, хосууд хоёулаа анхны удаа гэрлэсэн гэр бүлийг залуу гэр бүлд тооцож, 18-21 насандаа гэрлэсэн залуучуудыг түрүү залуу, 22-25 насандаа гэрлэсэн залуучуудыг дунд залуу, 26-30 насандаа гэрлэсэн залуучуудыг төгс залуу гэр бүл бологсад гэж үздэг.¹⁶ Өнөөдөр Монгол улсын хүн амын 67.5 хувийг 34 хүртэлх насны хүүхэд, залуучууд эзэлж байгаа нь хүн амын нөхөн үйлдвэрлэл, гэрлэлт, залуу гэр бүлийн өсөлтөд шууд нөлөөлж байна.¹⁷

Гэр бүлийн харилцааны зөрчил ихэвчлэн хэний хооронд үүсдэг талаарх асуултад хадам эцэг, эх – хүргэн, бэрүүдийн хооронд зөрчил (16,3%) гардаг гэж хариулсан нь залуу гэр бүлүүд хадам эцэг эх, төрөл төрөгсдөө танигдах байдал, гэр бүлийн амьдралын бэлтгэл дутмаг, амьдралын туршлага бага зэрэгтэй холбоотой юм. Өнөөгийн залуучуудын гэр бүлийн амьдралын бэлтгэл тийм ч сайнгүй дунд зэрэг (52,5%), муу (25,6%) байгаа нь ч энэ зөрчилд нөлөөлж байгаа ба оюутны гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй, бага орлоготой, орон байргүй, ажилгүй залуучуудын гэр бүлд энэ зөрчил илүү дарамт болж байна. Мөн судалгаагаар гэр бүл цуцлалтын 38 хувийг гэрлэснээс хойш 6-7 жилийн дотор салж байгаа залуу гэр бүл эзэлж байгаа нь гэр бүлийн амьдралын эхний үеүдийг залуучууд тэр бүр даван туулж чаддаггүйг харуулж байна.¹⁸

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2018 онд хийсэн “Монгол гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт” судалгаанд хамрагдсан иргэдийн 69.9 хувь нь гэрлэсэн бөгөөд гэрлэлтээ батлуулсан, 13.5 хувь нь гэрлэсэн боловч гэрлэлтээ батлуулаагүй, 12.4 хувь нь бэлэвсэн, 2.1 хувь нь тусгаарласан, 1.2 хувь нь цуцалсан, 0.9 хувь нь огт гэрлээгүй байна. 2004, 2010 онуудын судалгааны дүнтэй харьцуулахад 2004 онд 12.8 хувь байсан хамтран амьдарч буй гэр бүлийн тоо 14 жилийн хугацаанд хэвээр шахуу (0.7 хувиар өссөн), нийслэлд ялимгүй илүү (2018 онд 16.8 хувь) байв. Судалгаанд хамрагдсан огт гэрлээгүй иргэдийн тал нь 25-34 насныхан байхад 16.5 хувь нь 45 ба түүнээс дээш настай байна. Мөн огт гэрлээгүй иргэдийг боловсролын хувьд үзвэл 77.8 хувь буюу таван хүн тутмын дөрөв нь бүрэн дунд, түүнээс доош боловсролтой иргэд байна. 312 Ийнхүү гэр

¹⁶ Т.Бүрэнжаргал, *Гэр бүлийн социологи* (2005).

¹⁷ «Монгол гэр бүлийн бүтэц хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал».

¹⁸ Ibid.

бүлийн бүтэц, хэв маяг, гэрлэлтийн насжилтын байдалд өөрчлөлт орсноор шинэ асуудлууд урган гарсаар байна.¹⁹

Асуудал 1. Гэр бүлийг дэмжих шаардлага

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2018 онд хийсэн “Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт”²⁰ судалгаагаар гэр бүлийн тулгамдсан асуудлыг тодорхойлсон байдаг. Уг судалгаагаар гурван гэр бүл тутмын нэг нь санхүүгийн асуудалтай, таван гэр бүл тутмын нэг нь орон байрны асуудалтай гарсан байна. Гэр бүлийн уламжлалт угийн бичгийг гэр бүлийн 11.5 хувь нь хөтөлдөг байна. Гэр бүлийн зөрчил, маргааны шалтгааныг судлахад 55.3 хувь нь санхүү, өр зээлийн асуудлаас, 15.7 хувь нь согтууруулах ундааны хэрэглээнээс, 15.3 хувь хүүхэдтэй холбоотой асуудлаас, 11 хувь нь үзэл бодлын зөрчлөөс болж байна гэж үзжээ.

Төрөөс гэр бүлд ямар дэмжлэг хүсэж байгааг тодруулахад 57.57 хувь хөдөлмөр эрхлэх боломжийг өсгөж өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, 55.4 хувь өрхийн орлогоо нэмэгдүүлэхийг, 18.6 хувь гэр бүлийн боловсрол олгохыг, 17.7 хувь гэр бүлийн харилцаа, сэтгэл заслын зөвлөгөө хүссэн байна. Залуу гэр бүлийн 50.8 хувь нь ажлын байраар хангах дэмжлэг, 22.5 хувь орон сууц, 16.3 хувь орлого нэмэгдүүлэхийг хүсэж байсан бол дунд нас /35-49/-ны гэр бүлд санхүү, хүүхдийн боловсрол, хүмүүжлийн асуудлыг чухалчилсан байна.

Гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрүүдийн 76 хувь нь таарамжгүй харилцаа, 12 хувь нь архидалт, 8 хувь нь тусдаа амьдарч байгаа, 2 хувь нь гэр бүлээс гадуурх харилцаа, 2 хувь нь гэр бүлийн хүчирхийллээс тус тус шалтгаалсан байна.²¹

2019-2023 оны дунджаас харахад гэрлэлт цуцалсны дараа хүүхдийн тэтгэлгийн 60 гаруй хувь огт төлөгдөхгүй байгаа нь эцэг, эхийн ухамсар, үүргээ хэрэгжүүлэхгүй хариуцлагагүй байдал, ажилгүйдэл, ядуурал, төлбөрийн чадваргүй байдалтай холбоотой байна.²²

Дээрх байдлаас харахад гэр бүлд тэдний амьжиргааг дэмжих дэмжлэг үзүүлэх, орчныг сайжруулах, нийгэм – сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн боловсрол олгох, нийгмийн үйлчилгээ үзүүлэх зэргээр төрөл бүрийн дэмжлэг хэрэгтэй нь харагдаж байна.

Түүнчлэн, 2017 оноос Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлжээ. Туршилтын хөтөлбөрийн хүрээнд хийсэн “Монгол гэр бүлийн өнөөгийн байдал,

¹⁹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, *Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт*, (2018).

²⁰ Ibid.

²¹ «Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ», 134.

²² Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, «Монголын гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт».

тулгамдсан асуудал, үйлчилгээний хэрэгцээ” судалгаанд 42,970 орчим гэр бүлийг хамруулсан байна.²³

Энэхүү судалгаагаар манай улсад амьжиргааны түвшин, гэр бүлийн гишүүдийн харилцаа, нийгэмд эзэлж буй байр суурь, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэргээрээ ялгаатай 12-13 хэв шинжийн гэр бүл байна хэмээн дүгнэжээ.

Харин Гэр бүлийг дэмжихэд хэв шинж бүрд тохирсон нийгмийн ажлын үйлчилгээний нэр төрөл, практик арга зүйг бий болгож, хуульд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах хэрэгтэй гэж мэргэжилтнүүд үзэж байна.

Нийгэмд хэдийгээр гэр бүл гэсэн нэг ойлголтоор л нэрлэгдэж байгаа боловч үнэндээ 10 гаруй хэв шинжийн гэр бүл байгаа нь судалгаагаар нотлогдсон. Эдгээр хэв шинжийн 8,100 гэр бүлд бид 2017 оноос хойш туршилтын хөтөлбөрийг төсөл хэлбэрээр хэрэгжүүлж байна.

Хэв шинжээр нь аваад үзэхээр өрх тус бүрд өөр өөр төрлийн үйлчилгээ хэрэгтэй гэдэг нь ажиглагдсан. Мөн халамжийн олон янзын хөтөлбөрийн олон төрлийн өрх, гэр бүлд ирэх үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд төрийн үйлчилгээг гэр бүлүүдийн онцлогийг харгалзсан байдлаар хүргэх бодлогыг боловсруулах шаардлага байгаа юм.²⁴

Асуудал 2.Эх, хүүхдэд дэмжлэг үзүүлэх шаардлага

Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлийн хүрээнд халамжийн хөтөлбөрүүдийг зорилтот хэсэгт чиглүүлж харин нийтлэг хэлбэрээр төрөөс эх, эцэг, хүүхэд, гэр бүлд үзүүлж байгаа тэтгэмж, тусламж, урамшууллын бодлогыг нийгмийн халамжийн хууль тогтоомжоос салгаж тусдаа хуулиар зохицуулах шаардлага бий болсон. Энэ хүрээнд Нийгмийн халамжийн тухай болон Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай, Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулиар зохицуулж байгаа хүн амын өсөлтийг дэмжих бодлогыг нэгтгэн нэг хуулиар зохицуулах, олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжих нийгмийн бусад бодлогын арга хэмжээг нэмж тусгах зайлшгүй шаардлагатай байгаа болно.

Хүснэгт 1.Хуулийн дагуу эх, хүүхдэд олгож буй мөнгөн тэтгэлгийн төрөл, хэмжээ

№	Хууль эрх зүй	Он	Хүүхдийн тоо шалгуур	Мөнгөн дүн
1	“Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг нэмэгдүүлэх тухай”	1957	Эхийн алдар 1-р одон-8 ба түүнээс дээш хүүхэд Эхийн алдар 2-р одон-5-8 хүүхэд	300-800 төгрөг

²³ Г. Өлзийхутаг iKon.mn, «Гэр Бүлийг Дэмжих Үйлчилгээг ХУУЛЬЧЛАХ Хэрэгтэй Юу?», iKon.Mn, 14 Нэгдүгээр сар 2020, <https://ikon.mn>.

²⁴ Ibid. at Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн Л.Бадамцэцэг.

2	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль	2005	Алдарт эхийн I, II одонтой ахмад настан эхчүүдэд мөнгөн тусламж олгосон	50,000 10,000
3	Эх, хүүхдэд, тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай	2007	Алдарт эхийн I, II одонт бүх эхчүүдэд нас харгалзахгүйгээр мөнгөн тусламжийг олгох	50,000 10,000
4	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд	2010	Эхийн алдар 1-р одон-6 ба түүнээс дээш хүүхэд Эхийн алдар 2-р одон-4-6 хүүхэд	100,000 200,000
5	Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай	2017	Жирэмсэн эх Ихэр хүүхэд 0-3 насны хүүхэд асарсны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж Хүүхдийн мөнгө	40,000 1.0 сая- 3.0 сая 50,000 660,000 100,000

Зураг 3. Нийгмийн халамж болон нийтлэг мөнгөн тусламжийн зардал /2020-2023 он/



Нийгмийн халамжийн зардал жил бүр нэмэгдэж байгаа ч 75-80 орчим хувь нь амьжиргааны түвшин харгалзахгүй нийтлэг хэлбэрээр олгож байгаа хөтөлбөрт зарцуулж байна. Цалинтай ээж, одонтой эх, хүүхдийн мөнгө, насны хишиг, жирэмсэн эхийн тэтгэмж зэрэг амьжиргааны түвшин харгалзахгүй нийтлэг олгож байгаа хөтөлбөрт зарцуулж байна.

Зураг 4. Нийгмийн халамжийн зардлыг нэмэгдүүлсэн хөтөлбөрүүд /2020-2024 он/



Иймд халамжийг хэрэгцээ, шаардлагатай хэсэгт чиглүүлэх, амьжиргааны түвшин, өрхийн эмзэг байдалтай уялдуулахгүй олгодог хүн амын өсөлтийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөрийг халамжаас ялгаж, зааглах хэрэгцээ шаардлага тавигдаж байна.

2.1.Эхийн алдар одонтой эхчүүдэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламж

Нийгмийн халамжийн олон хөтөлбөрүүдээс амьжиргааны түвшин харгалзахгүй нийтлэг хэлбэрээр нас харгалзахгүй олгодог хөтөлбөрүүдийн нэг нь Эхийн алдар одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламж бөгөөд одон авсан үеэс эхлэн насан туршид нь олгодог.

Одоогоос 60 жилийн өмнө буюу 1957 онд “Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн эхчүүдийг одонгоор шагнах, улсын тэтгэврийг нэмэгдүүлэх тухай” хууль гарч Эхийн алдар 1-р зэргийн одон, Эхийн алдар 2-р зэргийн одонг анх бий болгосон байна. Энэ хуулийн дагуу 8 ба түүнээс дээш хүүхэд төрүүлэн өсгөсөн эхэд Эхийн алдар 1-р зэргийн одон, 5-8 хүртэл хүүхэд төрүүлсэн эхэд Эхийн алдар 2-р зэргийн одонг, шагнал /100-200 төгрөг/-ын хамт олгож байхаар тогтоож, жил бүр олон хүүхэдтэй /0-18 насны/ өрхөд тэтгэмж олгодог байсан.

Харин 2005 оны 12 сард батлагдсан Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд анх Эхийн алдар 1, 2 дугаар зэргийн одонтой **ахмад настан** эхчүүдэд жилд нэг удаа тусламж олгохоор заасны дагуу 2006 оны 7 дугаар сарын 01-ээс эхлэн 50000, 100000 төгрөгийн тусламж олгож эхэлсэн байна. Зөвхөн ахмад настан эхчүүдэд олгож байх энэ үед жилд 69696 эх хамрагдаж 4.9 тэрбум төгрөг зарцуулж байжээ.

Харин 2007 оноос Эх, хүүхдэд, тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулиар Эхийн алдар I, II зэргийн одонт **бүх эхчүүдэд нас харгалзахгүйгээр** тусламжийг олгох болсноор жилд 131.0 гаруй мянган эх хамрагдаж 8.5 тэрбум төгрөг зарцуулж өмнөх жилийн мөн үетэй харьцуулахад хүний тоо 2 дахин, хөрөнгийн хэмжээ 1.5 дахин нэмэгдсэн байна.

2010 онд Улсын Их Хурлаас батлагдаж, 2011 оноос хэрэгжиж эхэлсэн Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулиар одон авах болзолд тусгагдсан хүүхдийн тоо, шалгуурыг багасгаж 6 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд Эхийн алдар нэгдүгээр зэргийн одон, 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эхэд Эхийн алдар хоёрдугаар зэргийн одонг олгох болж, мөнгөн тусламжийн хэмжээг жилд нэг удаа 200.0 мянга болон 100.0 мянган төгрөг болгож тус тус нэмэгдүүлсэн байна.

Ийнхүү 2011 оноос эхлэн хамрах хүрээний шалгуурыг багасгаж, мөнгөн тусламжийн хэмжээг нэмэгдүүлснээр, 2007 онд бүх эхчүүдэд олгож эхэлсэн жилтэй харьцуулахад хамрагдах хүний тоо 55 хувиар, зарцуулах хөрөнгийн хэмжээ 252 хувиар нэмэгдсэн байна. 2016 оны нийгмийн халамжийн сангийн жилийн эцсийн дүнгээр **213505** хүн хамрагдаж **28.5** тэрбум төгрөг зарцуулж байна. Энэ нь нийгмийн халамжийн нийт зардлын 11 орчим хувийг эзэлж байсан байна.

Дэлхийн Банкны 2015 оны нийгмийн халамжийн үр шимийг хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээгээр ахмад настнууд нийгмийн халамжийн хэд хэдэн хөтөлбөрөөс үр шим хүртдэг. Тэдний хамгийн их үр шим хүртдэг хөтөлбөрүүд нь алдарт эхэд олгох тусламж байгаа бөгөөд "Эхийн алдар" одон авсан эхчүүдийн талаас илүү хувь нь 50-аас дээш насны хүмүүс байна гэжээ.²⁵

Хүснэгт 2. Эхийн алдар одонгийн мөнгөн тусламжид хамрагдсан хүний тоо, насаар


Төрөл	2022 онд хамрагдсан Хүний тоо	НАСНЫ АНГИЛАЛ						
		20-29	30-39	40-49	50-54	55-59	60-69	70-аас дээш
Эхийн алдар 1 дүгээр одон	64072	9	1411	4378	2777	4766	20804	29927
Эхийн алдар 2 дугаар одон	182614	1305	33873	50793	18548	21496	39987	16612
ДҮН	246686	1314	35284	55171	21325	26262	60791	46539

Эх сурвалж: ХХҮЕГ-ын Нийгмийн халамжийн сангийн 2022 оны тайлан

2022 оны халамжийн сангийн тайлангаар 247 мянган эхэд 31 тэрбум төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна. Нийт хамрагдсан эхчүүдийн 54.1 хувь буюу 133.6 мянга нь 55-аас дээш насны эхчүүд байна.

Зураг 5. 18-40 насны эмэгтэйчүүдийн тоо ба 1 өрхийн 0-17 насны хүүхдийн дундаж тоо

²⁵ Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, *Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн дизайн, үр шим хүртэгчдийн байдалд хийсэн дүн шинжилгээ*, УБ (2015), 16, <https://documents1.worldbank.org>.



Эх сурвалж: ӨМНС-д хийсэн судлаачийн тооцоолол

Монгол Улсын нийгмийн халамжийн системд хийсэн 2019 оны судалгаагаар хүүхдийн мөнгийг хэрэгжүүлж эхэлсэн 2005 оноос хойш төрөх идэвхтэй насны (18-40) эмэгтэйчүүдийн тоо хамгийн их байсан үе болон амьжиргааны түвшнээр эрэмбэлсэн өрхийн дундаж хүүхдийн тоог зурагт харууллаа. Нэгдүгээрт, Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээгээр Монгол Улсад төрөх идэвхтэй насны 18-40 насны эмэгтэйчүүдийн тоо 2013 он хүртэл өсөөд, дараа нь аажмаар буурсан байна. Хоёрдугаарт, Үндэсний статистикийн хорооноос гаргасан эмэгтэйчүүдийн тооны 76-80 хувь нь Өрхийн мэдээллийн санд бүртгэлтэй байсан ба тус мэдээллийн сангийн тооцоогоор 18-40 насны эмэгтэйчүүдийн тоо 2013 оныг хүртэл өсөж байгаад дараа нь тогтворжсон байна.²⁶

Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжих нь төрийн бодлого²⁷ боловч хүн амын тогтвортой өсөлтийг хангахдаа нийгэм, эдийн засгийн бүхий л давхаргын эмэгтэйчүүдийн төрөлтийг урамшуулах бодлого баримтлах нь зүйтэй. Монгол Улсад 2018 оны байдлаар хамгийн бага амьжиргаатай ядуу 20 хувьд багтах эмэгтэйчүүдэд ногдох хүүхдийн тоо хамгийн амьжиргаа сайтай өрхүүдэд ногдох хүүхдийн тооноос 50 гаруй хувиар их байна (Зураг).

2.2.Жирэмсэн эхийн болон 0-3 настай хүүхэдтэй эх/эцэгт олгодог тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж

1995- 2005 онд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас энэ төрлийн тэтгэмж авах эрх үүсээгүй эхэд төрөхийн өмнө болон төрсний дараа нийт 4 сарын хугацаанд олгодог байсан. Тэтгэмжийн хэмжээ нь тухай үеийн ХХДХ-тэй тэнцүү байсан. Хүүхэд асарсны тэтгэмж нь хүүхдийг 1

²⁶ Эрдэм партнерс ХХК, Монгол Улсын нийгмийн халамжийн систем: Зардлын хуваарилалт, халамж хүртээгчдийн төлөв байдал, УБ (2019).

²⁷ Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай. Монгол Улсын Засгийн газрын тогтоол.

нас хүртэл, ихэр бол 3 нас хүртэл нь жирэмсний болон амаржсаны тэтгэмж авсны дараа үргэлжлүүлэн олгодог байсан. Хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг тухайн үеийн АДТ-г харгалзан Засгийн газар тогтоодог. 2003 оны байдлаар 12,420 төгрөг байжээ.

Үүнээс гадна нэн ядуу өрхийн эх хүүхдээ төрүүлснээс хойш 3 сарын хугацаанд нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж олгодог байсан. Жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд эхэд 2005 оноос эхлэн тэтгэмж олгодог болсон. 2005-2017 он хүртэл жирэмсний 5 сартайгаас 12 сарын хугацаанд бүх эхчүүдэд (Нийгмийн даатгалаас жирэмсэн амаржсаны тэтгэмж авч буй давхар хамрагддаг).

Мөнгөн тэтгэмжийн хэмжээг 2012 онд 40,000 төгрөгөөр тогтоосноос хойш нэмэгдүүлээгүй байна.

Эх, эцэг, олон хүүхэдтэй өрхөд тэтгэмж олгох тухай хуулийг 2017 онд баталсан. Үүнтэй холбогдуулан жирэмсний 5 сартайгаас төрөх хүртэл жирэмсний тэтгэмж 2018 оноос эхлэн сард 40000 төгрөг, 0-3 настай хүүхэдтэй эх, эцэгт сар бүр 50000 төгрөгийн тэтгэмж олгож байна. Хэрэв эх/эцэг нь хөдөлмөр эрхэлбэл тэтгэмжийг зогсоодог. Жирэмсний тэтгэмжид 2022 оны халамжийн сангийн тайлангаар 77.6 мянган эхэд 10.8 тэрбум төгрөг, хүүхэд асарсны тэтгэмжид 196.6 мянган эхэд 84.5 тэрбум төгрөг тус тус зарцуулжээ.

0-3 насны хүүхэд асарсны тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас олгох амаржсаны тэтгэмжтэй давхцуулахгүй олгож байгаа ба харин жирэмсний тэтгэмж авч байгаа 5 сар нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсний тэтгэмжтэй давхцаж олгож байгааг өөрчлөх шаардлагатай юм.

2012 оноос өмнө 2 ба түүнээс дээш ихэр хүүхэдтэй эхэд жилд 1 удаа 120 мянган төгрөгийн тэтгэмж олгож байсан. 2012 оны Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлээр 2 ихэр хүүхэд тус бүрд 2 сая, 3 ба түүнээс ихэр хүүхэд бүрд 3 сая төгрөгийн тэтгэмжийг нэг удаа олгох болсон. 2022 оны халамжийн сангийн тайлангаар 743 эхэд 1.5 тэрбум төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон байна.

Энэ бодлогын хувьд жирэмсэн эх, ихэр хүүхэдтэй өрхийн амьжиргаанд томоохон дэмжлэг болдог бөгөөд харин тэтгэмжийн хэмжээг 2012 оноос хойш нэмэгдүүлээгүй байгааг эргэн харж төсвийн боломжид тулгуурлан нэмэх талаар анхаарах нь зүйтэй юм.

2.3.Хүүхдийн мөнгөн тэтгэмж

1995-2005 онд 4 хүүхэд төрүүлж өсгөж байгаа эх, эцэгт тухайн үеийн АДТ-г 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг нэг удаа олгодог байжээ. Мөн 16 хүртэлх насны 5 ба түүнээс дээш хүүхэдтэй эх/эцэг-т жилд нэг удаа хүүхэд тус бүрд 2000 төгрөгийн тэтгэмж олгодог байсан. 2005 оноос эхлэн хүүхдийн мөнгө хөтөлбөр хэрэгжиж тухай үеийн амьжиргааны түвшнээс доогуур орлоготой 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрхөд сар бүр 3000 төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж олгодог болсон.

-Хүүхэд нь сургуульд хамрагдсан байх,

-хугацаат вакцинд цаг хугацаандаа хамрагдсан байх,

-хүүхдээр хүнд хөдөлмөр эрхлүүлэхгүй байх гэсэн гурван нөхцөл тавьдаг байсан. 2006 оноос эхлэн амьжиргааны түвшин харгалзахгүйгээр сар бүр ямар нэг нөхцөл, шаардлага тавихгүйгээр бүх хүүхдэд олгодог болсон.

2005 оны Хүүхдийн тоо харгалзахгүйгээр, амьжиргааны түвшнээс доогуур өрхийн 0-18 хүртэлх насны бүх хүүхдийг 2005 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2006 оны 7 дугаар сарын 01-нийг хүртэл олгосон юм. Энэ арга хэмжээнд жилд 650 мянга орчим хүүхэд хамрагдсан юм.

2007 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж 0-18 насны бүх хүүхдэд сар бүр 3000 төгрөгийг олгохоос гадна улирал бүр 25000 төгрөгийг олгож байсан. Энэ арга хэмжээ 2010 оны 01 дүгээр сарын 01-ийг хүртэл үргэлжилсэн. Энэ арга хэмжээнд 932,2 мянга орчим хүүхэд хамрагдсан байна. Хүүхэд бүрд сар бүр олгож байсан 3000 төгрөгийн тэтгэмжид 2005 оноос 2010 оны 1 сарын 1-нийг хүртэл нийт 142,5 тэрбум төгрөг зарцуулсан.

2007 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийг шинээр баталж зарим бүтээгдэхүүний /алт, зэс зэрэг уул уурхайн орлого/ үнийн өсөлтийн албан татвар, улсын төсвийн ашиг, эрсдэлийн сангийн зарцуулагдаагүй хөрөнгө зэргээс тус санг бүрдүүлж хүүхэд гэр бүлийг дэмжих арга хэмжээнд тодорхой хувийг зарцуулах болсон. Энэ арга хэмжээтэй холбогдуулан 0-18 насны хүүхэд бүрд жилд нэг удаа 100,0 мянган төгрөгийг олгох болж, энэ мөнгийг 4 улиралд тэнцүү хуваан улирал бүр 25,0 мянган төгрөг олгодог болсон юм. 2007 оноос хойш энэ арга хэмжээнд нийт 270,6 тэрбум төгрөг зарцуулжээ. 2005 оноос хойш хүүхдийн мөнгөнд нийт 413,1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

2012 оноос Монгол Улсын 0-18 насны нийт хүүхдэд 20 мянган төгрөг олгож эхэлсэн бөгөөд 2016 онд нийт хүүхдийн 60 хувь, 2018 онд 60-80 хувь, 2019 онд 80-85 хувьд олгох гэх зэргээр зорилтот бүлэгт чиглүүлж олгож байсан.

2022 онд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг уул уурхайн баялгийн өгөөжид суурилсан “Хуримтлалтай Монгол хүүхэд” хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлсэн. Үүний дагуу Монгол Улсын иргэн 18 нас хүрснээр Хүүхдийн мөнгөн хуримтлалыг мөнгөн хэлбэрээр авах бөгөөд энэ хүртэлх хугацаанд хуримтлалыг Төрийн сан дахь “Хүүхдийн мөнгөн хуримтлал”-ын дансанд хуримтлуулах ба харин 2022 оны төсвийн жилд энэхүү хүүхдийн мөнгөн хуримтлалаас 100 мянган төгрөгийг мөнгөн хэлбэрээр олгосон.

2023 онд Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн дагуу хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшин харгалзан Монгол Улсын 0-18 хүртэлх насны нийт хүүхдийн 91 хувьд хамрагдсан хүүхдэд олгож байна.

Хүснэгт 3. Хүүхдийн мөнгө олгож ирсэн туршлага, оноор

Хугацаа	Хүүхдийн хамрагдах хувь	Хамрагдсан хүүхдийн тоо	Шалгуур	Хүүхдийн мөнгөний хэмжээ
2005 он 06.01-2006 он 07.01	34	650,000	Амьжиргааны түвшин доогуур орлоготой өрхийн 0-18 насны хүүхэд	3,000
2006 он 07.01-2010 он 01.01	100	932,000	-	3,000
2012-2016 он 1-6 сар	100	1,053,729	-	20,000
2016 он 7-12 сар	60	639,083	ООТА /судалгаа/	20,000
2017 он 1-12 сар	100	1,083,987	-	20,000

2018 он 1-3 сар	60	684,000	ООТА /судалгаа/	20,000
2018 он 4-12 сар	80	912,000	ООТА /судалгаа/	20,000
2019 он 1-3 сар	80	912,000	ООТА /судалгаа/	20,000
2019 он 4-12 сар, 2020 он 1-3 сар	85	1,000,000	ООТА /судалгаа/	20,000
2020 он 5-12 сар – 2022 он 1-12 сар	100	1,186,289–1,259,484	-	100,000
2023 ХБГ	91	1,167,972	ООТА /Захиргаа/	100,000

Асуудал 3.Гэр бүлд цогц үйлчилгээ үзүүлэх

3.1. Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

Манай улсад хүн амын бүлгүүдийн хөгжлийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээг хүн амын бүлгүүдэд зориулсан байдлаар зохион байгуулж, дараах ордон, төв, театр, зуслан үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

Хөгжлийн ордон: Хүүхдийн театр нийслэлд 2, аймагт 3, нийт 5, Ид шидийн орон нийслэлд 2, аймагт 4, нийт 6 байна. Эдгээр төв, ордон нь хүн амын тодорхой бүлэгт тухайлбал, хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэх зэргээр бүлэгт чиглэсэн хөтөлбөр, агуулга бүхий арга хэмжээ, үйлчилгээ хэрэгжүүлж байгаа боловч энэ нь дараах үр дагаврыг учруулж байна. *Тухайлбал:*

1.Нийт гэр бүлд буюу гэр бүлээрээ хамтдаа үйлчилгээ авах орчин, нөхцөл, үйлчилгээ дутмаг байна. Энэ нь гэр бүлээрээ хамтдаа цагийг үр бүтээлтэй, хөгжилтэй, дурсамжтай өнгөрүүлэх боломжийг хязгаарлаж, улмаар гэр бүлийн тогтвортой, бат бэх байдлыг дэмжих дэмжлэг хангалтгүй байдалд хүргэж байна.

2.Гэр бүлийн ямар ч насны аль ч гишүүн зорьж очиход үйлчилгээ үзүүлэх нөөц, боломж, арга хэмжээ бүхий төв, бүтэц дутмаг байна. Ингэснээр иргэний хувьд чирэгдэлтэй, төсөв, хүний болон бусад нөөц боломжийн хувьд зарлага өндөртэй, үр ашигтай байдал хангалтгүй байхад хүргэж байна.

3.Хүн амын бүлгүүд тус бүрд чиглэсэн арга хэмжээ, хөтөлбөрүүд нь ийнхүү тус тусдаа бүтцээр хүргэгдсэнээр тэдгээрийн агуулгын уялдаа алдагдах, гэр бүлийн гишүүд гэсэн нэгдсэн агуулгад зангидагдах, чиглүүлэгдэх байдал хангалтгүй байна.

4.Гэр бүлийн гишүүдийн хөгжил, хамгааллыг дэмжих сургалтын хөтөлбөр, үйлчилгээний агуулга гэр бүл гэсэн агуулгад нэгтгэгдээгүй тул гэр бүлийн хамтын амьдрал, бат бөх, тогтвортой харилцаанд бүрэн судлагдаагүй дараах асуудлууд тулгарч улмаар гэр бүлийн тогтвортой байдал алдагдах, хэврэгших, аливаа асуудлыг хамтдаа даван туулах чадвар хангалтгүй болоход хүргэж байна.

Тухайлбал:

- гэр бүлийн өмнө хүлээх ёс суртахууны хариуцлага, бусдын сөрөг нөлөө, хорт зуршил, хүчирхийллээс сэргийлэх, гэр бүлээс гадуурх харилцаанаас зайлсхийх, ажилдаа хэт анхаарах, ажил амьдралын тэнцвэрт байдал алдагдах, үүнийг зохицуулах чадвар хангалтгүй зэрэг хувь хүний хөгжил, зан үйлтэй холбоотой дутагдлуудтай тулгарах;

- эдгээр дутагдал, хангалтгүй байдлаас үүдэн гэр бүлийн зөрчил, маргаан гарах, үл ойлголцол даамжрах, улмаар гэр бүлийн бат бөх, тогтвортой

байдал алдагдах;

- гэр бүл тогтворгүй байснаар хүүхдийн хүмүүжил орхигдох, хараа хяналт алдагдах, улмаар цахим болон бусад хорт буруу зуршилд автах, донтох;
- гэр бүлийн гишүүд амьдралын нөхцөл, ажлын шаардлагаар урт богино хугацаагаар гэр бүлээсээ тусдаа амьдрах.

Иймээс эдгээр төвүүдийн үзүүлэх үйлчилгээг нэгтгэн зохион байгуулж, гэр бүлийн гишүүдэд **үйлчилгээг цогцоор үзүүлэх** шаардлага байна.

3.2. Гэр бүлийн боловсрол олгох, дээшлүүлэх шаардлага

Иргэдэд үзүүлэх нийгмийн үйлчилгээнээс хамгийн чухал нь гэр бүлийн боловсрол олгох болж байна. Иргэдэд гэр бүлийн боловсрол олгох сургалт, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн газар хэлтэс, гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүд хэрэгжүүлж, сургалт, урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ, холбон зуучлах болон хамгааллын үйлчилгээнд жилд дунджаар гэр бүлийн 25-40 хувийг хамруулж байна.

Тухайлбал, 2023 оны байдлаар 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн хэмжээнд Гэр бүлд зөвлөгөө өгөх 36 төв ажиллаж, нийт 418,139 хүнд урьдчилан сэргийлэх сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлсэн байна.

Цаашид гэр бүлийн боловсролыг иргэдэд бага наснаас олгох, гэр бүлд үзүүлэх нийгмийн үйлчилгээг улам бүр өргөжүүлж гэр бүлд цогц үйлчилгээ үзүүлэх, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн нийгмийн хөгжлийн чиг хандлага, иргэдийн завгүй амьдралын нөхцөлтэй уялдуулан бие даан суралцах, цахим боловсролыг олгох, онлайн боловсрол, зөвлөгөө үйлчилгээг хөгжүүлэх шаардлага байна.

Иймээс Гэр бүлийг дэмжих, тулгамдсан асуудлыг цогцоор шийдвэрлэх, шуурхай тусламж үзүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ бүхий Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг аймаг, нийслэл, дүүрэгт байгуулах шаардлагатай байна.

Асуудал 4. Гэр бүлд ээлтэй орчин

Түүнчлэн **нийгмийн орчныг гэр бүлд ээлтэй болгох**, орон нутгийн байгууллага, үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, орон сууц, нийгмийн орчинг гэр бүлд ээлтэй болгох, олон нийтийн чиг хандлагыг өөрчлөх шаардлага байна.

Иймд Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж, гэр бүлийн харилцааны хувийн эрх зүйн орчинг сайжруулахаар ажиллаж байгаатай зэрэгцүүлэн гэр бүлд нийгмийн үйлчилгээ үзүүлэх, хүүхэд, гэр бүлд ээлтэй Гэр бүлийг дэмжих тухай хуулийг шинээр боловсруулах практик шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Дээр дурдсан /1.3-т дурсан/ нөхцөл, байдлыг үндэслэн дараах асуудлыг шийдвэрлэх гол зорилгыг тодорхойлж байна. Үүнд:

1. гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжиж гэр бүл, эх, эцэг, хүүхдэд төрөөс дэмжлэг үзүүлэх /Асуудал 1, 2-ийг шийдэх/;
2. гэр бүлд үзүүлэх нийгмийн цогц үйлчилгээ хөгжүүлэх /асуудал 3-ыг шийдэх/;
3. гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх /асуудал 4-ийг шийдэх/
4. Гэр бүлийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх, гэр бүлд үзүүлэх дэмжлэг, нийгмийн үйлчилгээний санхүүжилт /нийтлэг зохицуулалт/-ыг шийдвэрлэхээр тодорхойлно.

2.1.Гэр бүл, эх, хүүхдэд төрөөс үзүүлэх дэмжлэг

Гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих нь салбар дундын шинжтэй тул Хүн амын өсөлт, гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн амьдралын үндсэн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн боловсролын, эрүүл мэндийн, орон сууц, нийгмийн хамгааллын бодлоготой уялдсан нөхцөлт хөтөлбөр/арга хэмжээнүүд хэрэгжүүлэх зорилтуудыг тусгана. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.2-д “Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, “Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.”, 2.1.1.3-т “Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ” гэсэн зорилтуудтай нийцүүлж, **“гэр бүл, эх, эцэг, хүүхдэд төрөөс үзүүлэх бодит дэмжлэг”**-ийг тодорхойлно.²⁸ Үүнд:

- Хүүхдийн мөнгө;
- Жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг;
- Ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг;
- Хүүхэд асарсны тэтгэмж /50,0 мянган төг/;
- Олон хүүхэдтэй эхийн урамшуулал, алдарт эхийн одон;
- Олон хүүхэдтэй гэр бүлд үзүүлэх дэмжлэг
 - Хүүхэд сурах, хөгжихтэй тай холбоотой зарим зардалд мөнгөн дэмжлэг үзүүлэх;
 - Оюутны сургалтын төлбөрийн хөнгөлөлт;
 - Татварын хөнгөлөлт;
 - Орон сууцны дэмжлэг (орон сууц шаардлагатай гэр бүлийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах, залуу гэр бүлд урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэх зэрэг хуримтлалын сангийн хөтөлбөрийн дагуу дэмжлэгийг тодорхойлно)

²⁸ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай § 2.1.1.2.Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, “Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.Гэр бүлд үзүүлэх нийгмийн үйлчилгээ

Иргэн, гэр бүлийн хэрэгцээнд суурилсан нийгмийн цогц үйлчилгээг гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэхийг зорино.

Энэ хүрээнд “гэр бүлд үзүүлэх нийгмийн үйлчилгээ”-г тодорхойлж, гэр бүлийн боловсролыг иргэдэд бага наснаас олгох, гэр бүлд үзүүлэх нийгмийн үйлчилгээг улам бүр өргөжүүлж гэр бүлд цогц үйлчилгээ үзүүлэх, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн нийгмийн хөгжлийн чиг хандлага, иргэдийн завгүй амьдралын нөхцөлтэй уялдуулан бие даан суралцах, цахим боловсролыг олгох, онлайн боловсрол, зөвлөгөө үйлчилгээг хөгжүүлнэ.

Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвөөр гэр бүлийн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээний дараах үйлчилгээг хүргэхээр төлөвлөж болох юм. Үүнд:

Гэр бүлийн хөгжлийн үйлчилгээ нь гэр бүлийн гишүүд, хүүхэд залуучуудыг амьдралд бэлтгэх, амьдралын мөчлөгт тохиолдож болзошгүй онцлог асуудлуудыг даван туулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон талт сургалт, нөлөөллийн арга хэмжээ байх;

Гэр бүлийн нийгмийн үйлчилгээ нь шуурхай тусламжийн үйлчилгээ; эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүлийн гишүүдийн зан үйлд нөлөөлөх, бие даан амьдрах ур чадвар, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалт, зөвлөгөөнд хамруулж, гэр бүлийг дэмжих шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилж ажиллах;

Цогц үйлчилгээний хүрээнд Сэтгэл зүйн зөвлөгөө, засал болон хууль эрх зүйн зөвлөгөө; гэр бүлийг дэмжих нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах; гэр бүлийн эдийн засаг, амьжиргааг дэмжих холбон зуучлах үйлчилгээ; гэрлэлт цуцлалт ба үрчлэлттэй холбоотой цогц үйлчилгээ; эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ зэрэг болно.

Иймд гэр бүлд шуурхай тусламж үзүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг аймаг, нийслэл, дүүрэгт байгуулан ажиллуулж болох юм.

2.3.Гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх

Орон нутгийн байгууллага, үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, орон сууц, нийгмийн орчин гэр бүлд ээлтэй байх, олон нийтийн чиг хандлагыг өөрчлөх, гэр бүлээрээ байх, амрах цагийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд хэрэгжүүлэх үүргийг өгөх зэрэг багтана. Үүнд:

- орон нутгийн байгууллагад гэр бүлийг дэмжих үйл ажиллагаа хэрэгжүүлэх үүрэг;
- нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагууд гэр бүлийг дэмжих үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, ажилтнуудын гэр бүлийг дэмжиж ажиллах;
- шилдэг аж ахуй нэгж байгууллагын шалгуурт гэр бүлд ээлтэй үйлчилгээний нөхцөлийг тусгах;

- ажилтны гэр бүлийг дэмжих;
- бизнес, хувийн хэвшлийн байгууллагууд гэр бүлийн багц үйлчилгээ үзүүлэхийг дэмжих;
- олон нийтийн чиг хандлагыг өөрчлөх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангах;
- гэр бүлийн өдөр, гэр бүлийг алдаршуулах талаар тусгах асуудлуудыг анхаарах.

2.4. Гэр бүлийг дэмжих тогтолцоо

Энэ хүрээнд Гэр бүлийг дэмжих төрийн байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, салбар дундын зохицуулалт, гэр бүлийн хөгжлийн цогц төвийн үйлчилгээ, гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн эрх үүрэг, үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагаар үзүүлэх, хүний нөөцийг бэлтгэх асуудлуудыг тодорхойлж байна. Үүнд:

Төрийн байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, салбар дундын зохицуулалт:

- **Эрүүл мэндийн яам** - эрүүл гэр бүлийг дэмжих хүрээнд цус ойртолтоос сэргийлэх, удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах /генетикийн оношилгоо хийх гэх мэт/. Энэ талаар юу хийх боломжтойг ЭМЯ-тай ярилцаж тодорхойлох;
- **Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам** - орон сууцны хороолол гэр бүл ээлтэй орчин бүрдүүлэх;
- **Боловсролын яам** - сурагчийн үнэлгээнд эцэг эхийн оролцоотой үйл ажиллагаа, хүүхдийн эрх хөгжил хамгааллын сургалт зэрэгт хамрагдсан байдлыг тусгах;
- **Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам** – гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжихэд чиглэсэн кино, контент; соён гэгээрүүлэх арга хэмжээ, залуучууд, залуу гэр бүлд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээ
- **Үндэсний статистикийн хороо** - Гэр бүлийн суурь судалгааг давтамжтайгаар хийх.

Гэр бүлийн хөгжлийн цогц төвийн үйлчилгээ:

- Төвийн бүтэц, чиг үүрэг;
- Нийгмийн ажилтан, Сэтгэл зүйч ажиллуулах;
- Төвийн үйлчилгээний төлөвлөгөө: заавал үзүүлэх үйлчилгээ;
- Төвийн үйл ажиллагааг төр, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллага хамтран үзүүлэх;
- Үйлчилгээг магадлан итгэмжлэлтэй байгууллагаар үзүүлэх:
 - Онлайн зөвлөгөө мэдээллийн нэгж;
 - Гэр бүлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн эрх, үүрэг;
 - Хүний нөөцийг бэхжүүлэх, сургах, мэргэшүүлэх;
 - Гэр бүлийн нийгмийн ажилтны үйлчилгээ үзүүлэх байгууллагын магадлан итгэмжлэл.

Гэр бүлийг дэмжих тухай хууль тогтоомж, хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгуулан, санхүүжилтийг дараах байдлаар төлөвлөж болох юм. Үүнд:

- Гэр бүлд үзүүлэх нийгмийн үйлчилгээний зардлыг жил бүрийн улс, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх. Үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг гэр бүлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлах;
- Хүүхэд, эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт үзүүлэх дэмжлэгт шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвөөс гаргах;
- Орон сууцны ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн дэмжлэгийн зардлыг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсөвт тусгах;
- Үдийн хоолны болон сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсөвт тусгах;
- Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг урамшуулах зардлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөвт тусгаж, зарцуулах хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлэх;
- Үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдийн үйлчилгээний зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлэн олгох;
- Гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийсэн, нийгмийн үйлчилгээ үзүүлсэн нийгмийн ажилтанд нэмэгдэл урамшуулал олгох, журмыг гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал хамтран батлах.

ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ЭЕРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛ ДЭЭР ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ

Аргачлалын 5-д зааснаар асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан үзэх ажлын хүрээнд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгыг биелүүлэхэд чиглэсэн хувилбаруудыг тогтооно. Аргачлалын дээрх зүйлд зааснаар асуудлыг шийдвэрлэх доор дурдсан хувилбарууд байна:

5.1.1.“тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;

5.1.2.хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;

5.1.3.зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;

5.1.4.төрөөс санхүүгийн интервенц хийх;

5.1.5.төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;

5.1.6.захиргааны шийдвэр гаргах;

5.1.7.хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Дээр дурдсан Аргачлалын 5.1.1–5.1.6-д заасан хувилбаруудын агуулгаас харахад эдгээр хувилбаруудын аль нь ч энэхүү тайлангийн Хоёр дахь хэсэгт заасан асуудлыг шийдвэрлэх зорилтод хүрэх хувилбар болохгүй байна. Учир нь энэхүү асуудал үүсэх болсон шалтгаан, нөхцөл нь одоогийн хууль тогтоомжид тухайн асуудлыг зохицуулсан хэм хэмжээ байхгүй байгаа болно. Тиймээс зөвхөн “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” буюу Аргачлалын 5.1.7-д заасан хувилбараар зорилтод хүрэх боломжтой гэж үзэж байна. Энэхүү дүгнэлтэд хүрэхдээ хувилбаруудыг сонгосноор зорилгод хүрэх байдал, хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үр өгөөжийн харьцаа зэрэг үзүүлэлтээр харьцуулан судалж дүгнэсэн болно.

Энэхүү дүгнэлтэд хүрэхдээ хувилбаруудыг сонгосноор зорилгод хүрэх байдал, хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үр өгөөжийн харьцаа зэрэг үзүүлэлтээр харьцуулан судалж дүгнэсэн болно.

Хүснэгт 4. Асуудал зохицуулах хувилбар ба харьцуулалт

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Гэр бүлийг дэмжих, гэр бүлд нийгмийн цогц үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчинг бий болгох асуудлыг гэр бүлийн эрх зүйн харилцаа, гэрлэгч иргэний хувийн эрх зүйн үр дагаврыг зохицуулдаг. Энэхүү харилцааг Гэр бүлийн тухай хуулиар зохицуулах боломжгүй тул гэр бүлийн тогтвортой байдал, гэр бүлийн хөгжил, сайн сайхан байдлыг дэмжих хуулийн практик	Үр дүн сөрөг

			шаардлага байгаа тул энэ хувилбар боломжгүй байна.	
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаад байгаа хүндрэл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Олон нийтийг соён гэгээрүүлснээр гэр бүлийн аж байдлыг сайжирч, дэмжих төсөв хөрөнгө шийдэгдэхгүй бөгөөд зорилтот гэр бүлийн гишүүдэд /хүүхэд, эхчүүд, өрх толгойлсон эх, эцэгт мөнгөн дэмжлэг үзүүлэх, төрөөс хөгжлийн цогц нийгмийн үйлчилгээ үзүүлэхэд төрөөс тодорхой зохицуулалтаар олгох шаардлагатай байгаа учир энэ хувилбарыг сонгох боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй.
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан зохицуулах замаар зорилгод хүрэх боломжгүй.	Эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай асуудал тул зах зээлийн механизмаар шийдэгдэхийг хүлээх боломжгүй учир энэ хувилбар тохиромжгүй. Зардал их гарна. Асуудлыг үүсгэж буй гол шалтгааныг арилгах боломжгүй.	Үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төсөв, татварын харилцааг зөвхөн Улсын Их Хурал хуулиар зохицуулдаг тул төрөөс санхүүгийн интервенц хийх замаар зорилгод хүрэх боломжгүй.	Аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн үндэслэл байж төсвөөс хөрөнгө гаргадаг тул шууд төрөөс санхүүжүүлэх хууль эрх зүйн үндэслэл байхгүй тул энэ хувилбар тохиромжгүй.	Үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Татвар, орон сууц, эрүүл мэнд, боловсрол зэрэг олон салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх олон арга хэмжээг хэрэгжүүлэхэд хууль зайлшгүй шаардлагатай.	Хуулийн төслийн хамрах зарим нэг үйлчилгээг бэхжүүлсэн эхлээд төрөөс бий болгож, дэмжиж хөгжүүлсний дараа төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлж болох боловч анхлан бий болгох, үйлчилгээг тодорхойлох, үйлчилгээний стандарт тогтооход энэ хувилбар тохиромжгүй.	Үр дүнд хүрэхгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Төсөв, татварын харилцааг зөвхөн Улсын Их Хурал хуулиар зохицуулдаг тул хуулиар эрх олгогдоогүй	Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд заасан захиргааны акт хэлбэрээр шийдвэрлэх нь тохиромжгүй тул сонгох боломжгүй..	Үр дүнд хүрэхгүй

		тохиолдолд захиргааны шийдвэр гаргах замаар зорилгод хүрэх боломжгүй.		
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Гэр бүлийг дэмжих дэмжлэг нь төсөв, татварын дэмжлэг байх тул уг дэмжлэгийг хэрэгжүүлэхийн тулд хуулийн төсөл боловсруулах замаар зорилгод хүрэх боломжтой.	Гэр бүлийг дэмжих бодит боломж нөхцөл хууль тогтоомжийн хүрээнд бий болно.	Үр дүнтэй

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах: Хүний эрхийн түгээмэл тунхаглалын Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй” гэж заасныг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан нь төрийн гэр бүлийг хамгаалах үүргийг тодотгосон бөгөөд үүнээс ялангуяа хүний эрх, эрх чөлөөг хангахуйц **эдийн засаг, нийгмийн баталгааг** бүрдүүлэхэд Гэр бүлийг дэмжих хууль боловсруулан хэрэгжүүлэх шаардлага байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын Зорилтын 2.3-т “Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ.”

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.2-д “Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, “Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.”, 2.1.1.3-т “Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ.”, 2.1.1.4-д “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан нь Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах хууль эрх зүйн үндэслэл болж байгаа тул хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг сонгосон болно.

ДӨРӨВ.СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 5. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
	1.1 Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм ✓	Үгүй	
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй ✓	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм ✓	Үгүй	Хүүхэд, жирэмсэн эх, өрх толгойлсон эх, эцэгт мөнгөн тэтгэмж олгоно.
	1.2 Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм ✓	Үгүй	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсвэл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм ✓	Үгүй	
	1.3 Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм ✓	Үгүй	
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-ээс өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм ✓	Үгүй	
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм ✓	Үгүй	
1. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарласан тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй ✓	хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээд зөрчсөн албан тушаалтны үйлдэлд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй ✓	
2. Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт	Тийм	Үгүй	Хуулийн дагуу

	хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	✓		үзүүлэх дэмжлэг, арга хэмжээ, үйлчилгээнд гэр бүлийг нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн тодорхой шалгуурын дагуу хамруулна.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй ✓	
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм ✓	Үгүй	
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгасан эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлагдахгүй)	Тийм ✓	Үгүй	Хүүхэд, жирэмсэн эх, өрх толгойлсон эх, эцэгт мөнгөн тэтгэмж олгоно.
3. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм ✓	Үгүй	Нэг бүрчлэн тодорхойлно.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм ✓	Үгүй	
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм ✓	Үгүй	Өрх толгойлсон эх, эцэг, хүүхдээ асарч байгаа эх, эцэг адил хамрагдана.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Хүснэгт 6. Эдийн засагт үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй ✓	
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй ✓	
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй ✓	
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй ✓	
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	
	2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	
3. Аж ахуйн	3.1. Зохицуулалтын хувилбарыг	Тийм	Үгүй	

нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		✓	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй ✓	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдаан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй ✓	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсвэл хориг тавих эсэх	Тийм	Үгүй ✓	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй ✓	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах гм) бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх, болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа, шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм ✓	Үгүй	Гэр бүлийн суурь судалгааг давтамжтай хийх
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм ✓	Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй ✓	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй ✓	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
	7.4.Хувь хүний /гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм ✓	Үгүй	Гэр бүлийн орлого нэмэгдэнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй ✓	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсвэл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй ✓	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм ✓	Үгүй	
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсвэл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй ✓	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм ✓	Үгүй	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг	Тийм	Үгүй	

	сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		✓	
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй ✓	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм ✓	Үгүй	

4.3.Нийгэмд үзүүлэх нөлөө

Хүснэгт 7. Нийгэмд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болгох эсэх	Тийм ✓	Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй ✓	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм ✓	Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм ✓	Үгүй	Эерэг нөлөөтэй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм ✓	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм ✓	Үгүй	Үйлчилгээний мэдээллийн сан
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй ✓	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэсний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй ✓	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм ✓	Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм ✓	Үгүй	Эрх, үүрэг, б чиг үүргийн хуваарилалт хийгдэнэ.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй ✓	
5.Нийтийн эрүүл мэнд аюулгүй байдал	5.1.Хувь хүн / нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм ✓	Үгүй	

	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ) –т нөлөөлөх эсэх	Тийм √	Үгүй	Эерэг
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм √	Үгүй	Эерэг
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм √	Үгүй	Эерэг
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм √	Үгүй	Гэр бүлийн хүчирхийлэл буурна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм √	Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсвэл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	
	8.3.Иргэдийн түүх соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм √	Үгүй	Эерэг

4.4.Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Хүснэгт 8. Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх / бууруулах эсэх	Тийм	Үгүй √	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
3.Ан амьтан, ургамал хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй √	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	

	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	
	4.2.Усны бохирдол нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй √	
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
	5.2.Хөрс эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй √	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй √	
	6.2.Газрын зохицуулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй √	
7.Нөхөн сэргээгдэх /нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зохицуулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй √	
	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй √	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй √	

4.5.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.

Гэр бүлийн харилцаа, түүний дотор гэрлэлт (гадаадын болон харьяалалгүй иргэнтэй гэр бүл болох), хүүхдийн эрх, хүүхдийн тэтгэлэгтэй холбоотой олон улсын гэрээ, түүнтэй адилтгах дараах баримт бичгүүд байна. Үүнд:

-Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт /1976/²⁹

Энэхүү фактын 23 дугаар зүйлд:

1.Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй.

2.Гэрлэх насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэйчүүд гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй.

3.Гэрлэгчид өөрсдөө чөлөөтэй бөгөөд харилцан бүрэн зөвшөөрөлцөөгүй аливаа гэрлэлт байж үл болно.

4.Энэхүү Фактад оролцогч улс нь гэрлэх үед, гэрлэсэн хугацааны туршид болон гэрлэлтийг цуцлах үед гэрлэгчдийн эдлэх эрх, хүлээх хариуцлагыг тэгш хангах зохистой арга хэмжээ авна. Гэрлэлтийг цуцлах тохиолдолд аливаа хүүхдийг хамгаалах талаар шаардлагатай заалт гаргана.

-Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай” олон улсын факт /1976/³⁰

Энэхүү фактын 10 дугаар зүйлд: *“Нийгмийн жам ёсны үндсэн нэгж болсон гэр бүлд, ялангуяа түүний үүсэх үед, бие дааж амжаагүй хүүхдийг халамжлах,*

²⁹ Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

³⁰ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A (XXI) дугаар тогтоолоор баталж, 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

хүмүүжүүлэх хариуцлага хүлээж байгаа үед, боломжийн хэрээр халамжлан хамгаалж тусална. Гэрлэгсэд чөлөөтэй, харилцан зөвшөөрөлцсөний үндсэн дээр гэрлэнэ”

-Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц /1981/³¹

-Хүүхдийн эрхийн тухай конвенц /1990/³²

-Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц /1995/³³

-Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенц /1964/³⁴

-Хүүхдийг асран хамгаалах үүрэгт хэрэглэгдэх эрх зүйн тухай конвенц /1973/³⁵

Эдгээр нь гэрлэлтийн нас, гэрлэлтийн эрх чөлөөт байдал, хүүхэд-эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, хүүхдийг асрах хамгаалах, тэтгэхтэй холбоотой олон улсын баримт бичгүүд юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”³⁶ гэж заасан.

Монгол Улс 1969 оны 5 дугаар сарын 10-ны өдөр нэгдэн орсон Эхчүүдийг хамгаалах тухай Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 103 дугаар конвенцын 4.1-д “Жирэмсний болон хүүхэд төрүүлсний чөлөөнд байгаа эмэгтэй мөнгөн болон эмнэлгийн үйлчилгээний тэтгэмж авах эрхтэй”, 4.2-т “Мөнгөн тэтгэмжийн хэмжээг үндэсний хууль тогтоомжоор тогтоох бөгөөд энэ нь эх, хүүхдийн амьдралын зохистой түвшинд эрүүл, хүүхдийн хөгжлийн суурь үзүүлэлтийг байдлыг хангахуйц байна.” гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 2.3.1-д “Хүн амын төрөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.3.1-д “Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр

³¹ Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 34/180 тоот тогтоолоор 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 1981 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

³² 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

³³ 1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталж, 1995 оны 5 дугаар сарын 1-нд хүчин төгөлдөр болсон.

³⁴ 1962 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр баталж, 1964 оны 12 дугаар сарын 9-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

³⁵ 1973 оны 10-р сарын 2-ны өдөр Гаага хотод Англи, Франц хэл дээр хийгдсэн бөгөөд хоёулаа ижил хүчинтэй. Convention of 24 October 1956 on the law applicable to maintenance obligations towards children.

³⁶ Монгол Улсын Үндсэн хууль 1992.

бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Иймд Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийг боловсруулах нь Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй болно.

ТАВ.ТУХАЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Олон улсын эдийн засаг хамтын ажиллагаа, хөдөлмөрийн байгууллагын /ОУЭЗХАХБ/-ын болон Европын холбооны гишүүн өндөр болон дунд орлоготой 41 орны гэр бүлд ээлтэй бодлогыг³⁷ авч үзэхэд хүүхдийн амьдралыг хамгийн сайхнаар эхлүүлэх ба эцэг, эхийн ажил, амьдралын тэнцвэрийг хангах гэр бүлд ээлтэй нийгэм байгуулахыг чухалчилж байна. Эдгээрт эцэг, эхэд цалинтай чөлөө олгох, хүүхдийн хөхөөр хооллолтыг дэмжих, хүүхэд харах үйлчилгээ, сургуулийн өмнөх боловсролыг өндөр түвшинд хүргэж хөгжүүлэх, чанаржуулах, хүүхдүүдийг бүрэн хамруулахад анхаарах зэрэг байна.

Зарим улс орнуудын гэр бүл, эх, хүүхдийг дэмжиж бодлого, хууль тогтоомжийн дагуу олгогдож буй мөнгөн дэмжлэгийг судалж үзээд, Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулахад илүү нарийвчлан арга хэмжээнүүдийг судлан үзээд санаа авч, тусган хэрэгжүүлж болохуйц гэж үзээд туршлагуудыг улс орноор нь түүвэрлэлээ. Хууль хийж буй хүмүүст гэр бүлийг дэмжих арга хэмжээнүүдийг нарийвчлан судлан харгалзах шаардлага байгаа тул улс улсаар нь арга хэмжээнүүдийг түүвэрлэв.

5.1.Швед Улс

1.Хүүхэдтэй гэр бүлийн тэтгэмж. Хүүхдийн тоогоор олон хүүхэдтэй гэр бүлд тэтгэмж өгдөг байна. Хүүхэд өсөж торниход шаардагдах амьжиргааны орчинг баталгаажуулах үүрэг зөвхөн эцэг эхэд төдийгүй нийгмийн зүгээс хүлээх үүрэг, мөн төрөлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хүн амын бодлоготой уялдаатай хэрэгжүүлдэг байна.

Швед Улсын хүүхдэд олгож буй тэтгэмж

Хүүхдийн тоо	Хүүхдийн тэтгэмжийн хэмжээ	Олон хүүхэдтэй гэр бүлийн тэтгэмжийн хэмжээ	Нийт
1	1050	-	1050
2	2100	100	2200
3	3150	454	3604
4	4200	1314	5514
5	5250	2364	7614

2.Өрх толгойлсон эцэг, эхчүүдэд олгох дэмжлэг. Швед улсын хувьд гэр бүл салсны улмаас эцэг, эхийн хэн нэг нь хүүхдээ өсгөж байгаа бол тухайн өсгөж буй талдаа хүүхэд өсгөх зардлыг албан журмаар гаргах ёстой байдаг.

³⁷ НҮБХАС-гийн тайлан илтгэл, 2019 он

Хэрэв доорх шалтгаан улмаас тухайн эцэг, эхэд оногдсон хүүхэд өсгөх зардлыг төлөх боломжгүй үед Нийгмийн даатгалын ерөнхий газраас хүүхдээ албан ёсоор тэжээн тэтгэж буй өрх толгойлсон эцэг эхчүүдэд дэмжлэг үзүүлдэг. Үүнд:

- Салсан эхнэр болон нөхөр нь хүүхэд өсгөх зардлыг олгоогүй;
- Тохиролцож олгохоор болсон зардал нь сард 1173 кронаас бага;
- Эцэг эсвэл эх болох нь хуулиар нотлогдож тогтоогдоогүй;
- Салсан эхнэр, нөхөр нь нас барсан, хүүхэд нь хүүхдийн тэтгэвэр авч чадахгүй байгаа;
- Өрх толгойлсон эцэг, эх хүүхдээ үрчлүүлсэн тохиолдолд болно.

Өрх толгойлсон эцэг, эхчүүдэд олгох тусламжийг хүүхэд 18 нас хүртэл авах боломжтой. Хүүхэд нь үргэлжлүүлэн сургуульд сурах, уртасгасан хүүхдийн тэтгэмж авдаг, боловсролын тэтгэмжид хамрагддаг бол 20 нас 6 сар хүртэл тусламж үргэлжилдэг.

3.Орон байрны тэтгэмж. Хүүхэдтэй болон хүүхэдгүй 28-аас доош насны залуу гэр бүлд орон байрны тэтгэмжийг олгодог. Орон байрны тэтгэмжийн хэмжээ нь орон сууцны хэмжээ, оршин суух зардал, орлого зэргээс хамааран ялгаатай тогтоох ба хүүхэдтэй гэр бүлийн хувьд тэтгэмжийн хэмжээ нь орлогын төвшнөөс шалтгаалж ялгаатай байдаг.

4.Эцэг эхчүүдийн даатгал. Эцэг эхчүүдэд зориулсан даатгалын үйлчилгээнд жирэмслэлт, төрөлт, хүүхэд асрамжийн үйл явцтай холбоотой эцэг эхчүүдийн эрх үүргийг нийгмийн зүгээс дэмжихэд чиглэдэг. 1974 оноос Эцэг эхчүүдийн даатгалын хуулийг хэрэгжүүлж өмнөх эхчүүдийн амралтыг эцэг эхчүүдийн амралт болгон өөрчилсөн байдаг.

5.2.Австрали Улс³⁸

1.Гэр бүлийн дэмжлэг. Австралийн Квинслэнд мужийн Хүүхдийн аюулгүй байдал, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан яамнаас хэрэгцээт гэр бүлүүдэд дэмжлэг болох хэд хэдэн цогц үйлчилгээг үзүүлдэг. Австралид гэр бүлийн мэргэжлийн үйлчилгээ маш сайн хөгжсөн бөгөөд гэр бүлийн харилцааны төрийн болон төрийн бус олон тусгай байгууллага ажилладаг байна. Тэдгээр байгууллагаас гэр бүлүүд хүүхэд хүмүүжлийн тухай, гэр бүлийн маргааны үед асуудлаа хэрхэн шийдвэрлэж, харилцаагаа сайжруулах талаар олон төрлийн зөвлөгөө авах боломжтой байдаг аж.³⁹

Гэр бүл, хүүхдийн асуудлаар зөвлөгөө өгөх. Энэхүү үйлчилгээ нь эмзэг гэр бүлүүдтэй утсаар болон цахимаар холбогдон мэдээлэл, зөвлөгөө өгөх анхан шатны дэмжлэг үзүүлэх үйлчилгээ. Энэхүү үйлчилгээгээр тухайн гэр бүлийн хэрэгцээ шаардлагыг үнэлж, тэдгээрийн хэрэгцээнд нийцсэн тусламжийн үйлчилгээг санал болгон, холбож өгдөг.

³⁸ Seniors and Disability Services Department of Child Safety, «Department of Child Safety, Seniors and Disability Services of the Queensland Government», *Department of Child Safety, Seniors and Disability Services*, 30 Тавдугаар сар 2024, www.dcssds.qld.gov.au.

³⁹ iKon.mn, «Гэр Бүлийг Дэмжих Үйлчилгээг ХУУЛЬЧЛАХ Хэрэгтэй Юу?», н. Хүүхэд, гэр бүл судлаач, гэр бүлийн маргаан шийдвэрлэх төслийн зохицуулагч С.Энхтуяа "Гэр бүлийн зөрчил шийдвэрлэх үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх нь" сэдэвт сургалтын үеэр хэлж байв.

2.Гэр бүлийн эрчимтэй дэмжлэг. Энэхүү дэмжлэгийн үйлчилгээнд хуулийн дагуух хүүхэд хамгааллын системд хамрагдах эрсдэлтэй хүүхэд, залуус (*хэвлийд бойжиж буйгаас эхлээд 18 нас хүртэлх насны*)-ын амьдарч буй эмзэг гэр бүлүүдийг хамруулдаг. Энэхүү үйлчилгээг тухайн гэр бүлийн зөвшөөрлийг үндэслэн үзүүлдэг. Эмзэг гэр бүлд хамаарах бүх гишүүд энэхүү үйлчилгээнд хамрагдах боломжтой бөгөөд хэргийн удирдлага (*case management*) хариуцсан менежерүүд хамтарч ажиллан тухайн гэр бүлийн хэрэгцээг тодорхойлж, эрчимт дэмжлэг үзүүлэх үйлчилгээнүүдэд хамруулдаг.

3.Хоёрдогч гэр бүлийн дэмжлэг. Хоёрдогч гэр бүлийн дэмжлэгийн үйлчилгээ нь хүүхдэд учирч болзошгүй аюулыг багасгах, гэр бүл доторх хямрал, асуудал үүсэх, даамжрахас сэргийлэх, гэр бүлийн сайн сайхныг хадгалах тогтворжуулах зорилготой.

Энэ үйлчилгээнд хамруулан дараах үр дүнг гаргахыг зорьдог:

- Хүүхэд, түүний гэр бүлийн аюулгүй байдал, сайн сайхныг сайжруулах;
- Гэр бүлийн хүүхдээ асран хамгаалах чадварыг сайжруулах;
- Гэр бүл өөрийгөө чадавхжуулах, асуудлаа шийдвэрлэх, эерэг сонголт өөрчлөлтийг хийхэд нь тус болох шаардлагатай эх үүсвэрүүдэд холбож өгөх, дэмжлэг туслалцаа үзүүлдэг байгууллага, хүмүүстэй холбож өгөх;
- Хуулийн дагуух хүүхэд хамгааллын системд хамрагдах, дахин хамрагдахаас урьдчилан сэргийлэх.

Ерөнхий кейс менежер энэхүү үйлчилгээг удирдан явуулдаг.

4.Зорилтот гэр бүлийн дэмжлэг. Зорилтот гэр бүлийн дэмжлэгийн зорилтот бүлэг нь хүүхэд хамгааллын арга хэмжээнд заавал хамрагдахааргүй хэдий ч эмзэг нөхцөлд байгаа хүүхэд, залуус болон тэдний гэр бүл байдаг. Энэхүү санаачилгын хүрээнд санхүүжиж буй үйлчилгээ нь эмзэг нөхцөл байдалд байгаа хүүхдийн эцэг, эх, гэр бүлд туслалцаа үзүүлнэ.

Түр хамгаалан байрлуулах байр. Энэхүү санаачилгыг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, хүчирхийлэлтэй гэр бүлд байгаа хүүхдийн аюулгүй байх нөхцөлийг хангах зорилгоор хэрэгжүүлдэг. Түр хамгаалан байрлуулах байрны үйлчилгээнд гэр бүлийн дэмжлэг, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, чадавхжуулах бусад үйлчилгээ багтдаг.

5.Гурав дахь шатны гэр бүлийн оролцооны үйлчилгээ. Энэ үйлчилгээг Хүүхэд хамгааллын үйлчилгээний төвд үйлчлүүлж буй этгээдийн гэр бүлд үзүүлдэг. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь Хүүхэд хамгааллын үйлчилгээний төвийн хяналтад өөрийн гэртээ амьдарч байгаа болон гэрээс гадуурх асрамжид байгаа хүүхдийг буцаад гэр бүлтэйгээ нийлэх, дасах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Үйлчилгээг үзүүлснээр эцэг, эх, хүүхдийг буцаан эзэнгшин дасгах, эцэг, эхийн хүүхдээ асран хүмүүжүүлэх чадварыг сайжруулах, хүүхдийг аюулгүй бөгөөд тогтвортой сэтгэл зүйтэй болгох үр дүнтэй гэж үздэг.

5.3.Франц Улс

1.Хүүхдэд олгох тэтгэмж. Франц Улсын бодлого нь дундаж зарчмыг авч хэрэгжүүлдэг. Төрсөн хүүхдэд 18 нас хүртэл заавал мөнгөн тэтгэмжийг сар бүрийн хэрэгцээнд өгнө. Хичээлийн шинэ жилийн тэтгэмжид 6-18 насны хүүхдийн боловсролтой холбоотой зардал дэмжлэг үзүүлдэг тогтолцоо юм. Сургууль

завсардалтыг шийдвэрлэх, сургуульд суралцахтай холбоотой зардал, эд материалын дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг. Тэтгэмжид хүүхдийн тоо, орлогын нөхцөлийг харгалздаг.

Франц Улсын хичээлийн шинэ жилийн тэтгэмжид хамрагдах өрхийн орлогын нөхцөл

Хүүхдийн тоо	Орлогын хэмжээ
1	17,299 евро
2	21,291 евро
3	25,283 евро
4-с дээш хүүхэд нэг бүрд	3.392 евро

5.4.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

1.Гэр бүл дэх татварын хөнгөлөлт. Эцэг, эх хоёрт 3,648 евро хүртэл , өрх толгойлсон эцэг, эхчүүдэд 1,824 евро хүртэл хөнгөлөлт авах боломжтой болсон байна. Ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг, эх, өрх толгойлсон эцэг, эхчүүдэд 14 наснаас доош хүүхэдтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй бол хүүхэд асран хамгаалахтай холбоотой зардлын татварыг хөнгөлдөг байна.

2.Хүүхэд асрах зардал. Ажил-Гэр гэсэн хосолсон бодлогыг дэмжихийн хажуугаар хүүхдээ өсгөхөөр ажлаасаа гарах тохиолдолд эдийн засаг, орлого, нийгмийн баталгаатай холбоотой эрсдэлийг багасгахад анхаарч, 2-оос дээш хүүхэдтэй бол хүүхэд асрах зардлыг олгохдоо жилийн орлогыг уян хатан байдлаар зохицуулж орлогын ялгааны ангилалгүй гэр бүлийн бодлого болон хүн амын бодлогын уялдаа холбоог сайжруулах зорилт дэвшүүлсэн байна.

5.5.Бүгд Найрамдах Солонгос Улс

1.Боловсролын дэмжлэг. Амьжиргааны баталгаажих доод төвшнөөс доогуур орлоготой өрх толгойлсон эх,эцэг бүхий гэр бүлийн ахлах ангийн хүүхдэд олгох боловсролтой холбогдох зардлын дэмжлэгийг /тэтгэлэг, тусламж/ олгодог.

2.Өрх толгойлсон эх,эцэгт дэмжлэг. Гэр бүлийг дэмжих хуулиас гадна Орон сууцны тухай хууль –д орон сууцгүй, бага орлоготой эх, эцэг бүхий гэр бүлийг улсын чанартай орон сууц хуваарилах болон түрээслэхэд давуу эрхээр харгалзан олгодог.⁴⁰

3.Хүүхдийн мөнгө. Дөнгөж төрсөн болон 0 настай хүүхдийн эцэг, эхэд сард 2024 онд 1 сая вон, Нэг настай хүүхдийн эцэг эхэд сард 500.000 вон, 2-8 насны хүүхэд 100.000 воны тэтгэмж авдаг байна. Мөн дөнгөж төрсөн хүүхдэд "Анх уулзсаны баяр" хэмээн 2 сая вон өгдөг.

4.Ганц бие эцэг, эхчүүд бүхий өрх гэр бүлийг дэмжих. 18-аас доош насны хүүхэдтэй орлого багатай ганц бие эцэг, эх бүхий өрхөд хүүхэд асрахад нь дэмжлэг болгож сард 200,000 вон өгдөг. Орлого багатай эмээ өвөө-ач зээ бүхий өрх, гэрлээгүй ганц бие 5-аас доош насны хүүхэдтэй эцэг-эхэд нэмж 50,000 вон, Дунд, ахлах сургуулийн хүүхэдтэй орлого багатай ганц бие эцэг, эхийн өрхөд хүүхдийн боловсролын тэтгэмж /жилийн бичиг хэргийн зардал /83,000 вон, Сургуулийн бүртгэл, ахлах сургуульд боловсрол олгох, эсхүл сургуулийн

⁴⁰ Гэр бүлийн хөгжлийн асуудал, 2016 он Т.Намжил, Ц.Энхтүвшин 4-р бүлэг

мэргэжлийн шалгалт боловсролын зардлыг дэмжих, болон өсвөр насны ганц бие эцэг, эхчүүдэд өөрийг нь дэмжиж санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Дараах дэмжлэгийг үзүүлж байна:

- Бага орлоготой орон гэргүй ганц бие эцэг, эх бүхий өрхөд зориулсан "ганц бие эцэг, эх бүхий өрхийн тусламж"-ийг үзүүлэх;
- Бага орлоготой өрх толгойлсон ганц бие эцэг эхэд гэр бүлд тодорхой хугацаагаар амьдрах газар /байр/ санал болгож, боловсролоор дамжуулан өөрийгөө дэмжихэд туслах;
- Уг амьдрах байрт орсон хүмүүсийн сэтгэл санааны тогтвортой байдлыг хангах үүднээс мэргэжлийн зөвлөгөө, сэтгэлзүйн эмчилгээг дэмжих;

5.Бага орлоготой гэр бүлийг дэмжих. Бага орлоготой гэр бүлүүдэд зориулсан орон сууцны дэмжлэг⁴¹, боловсролын дэмжлэг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зэрэг олон төрлийн халамжийн хөтөлбөрүүдийг санал болгодог. Орлогын татварын хөнгөлөлт (EITC) хөтөлбөр нь орлого багатай ажил эрхэлдэг өрхүүдэд татварын буцаан олголтыг олгох зарчмаар орлогоо нэмэгдүүлэх боломжийг олгодог.

6.Гэр бүлийн зөвлөгөө, боловсрол. Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвүүд: Гэр бүлийн зөрчилдөөн, эцэг эхийн асуудал, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал зэрэг асуудлуудыг шийдвэрлэхийн тулд төрөөс гэр бүлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлдэг. Эцэг эхийн боловсрол: Эцэг эхчүүдэд хүүхэд өсгөн хүмүүжүүлэх арга барилд сургах янз бүрийн хөтөлбөрүүд байдаг бөгөөд үүнд биечлэн оролцох болон онлайн үйлчилгээнүүд багтдаг.

7.Олон соёлт гэр бүлийг дэмжих. Интеграцийн хөтөлбөрүүд: Өмнөд Солонгос хэлний боловсрол, соёлын чиг баримжаа олгох, хууль эрх зүйн туслалцаа зэрэг олон соёлт гэр бүлийг дэмжих хөтөлбөрүүдийг санал болгодог. Санхүүгийн дэмжлэг: Олон соёлт гэр бүлийг Солонгосын нийгэмд нэгтгэхэд туслах санхүүгийн тусгай дэмжлэг, боловсролын хөтөлбөрүүд байдаг.

8.Гэр бүлд ээлтэй байгууллагад гэрчилгээ олгох систем. Хүүхэд төрүүлэх, асрахад дэмжлэг үзүүлдэг, ажлын уян хатан цагтай зэрэг гэр бүлд ээлтэй системийг хэрэгжүүлж буй корпорацууд, Аж ахуйн нэгж, байгууллагуудад үнэлгээ хийж гэрчилгээ олгох, гэрчилгээтэй байгууллагуудыг урамшуулах.

9.“Гэр бүлийн хайрын өдөр” аян. Долоо хоногийн 3 дахь өдөр болгон ажилтнууд ажлаасаа яг тарах цагтаа гарч, гэртээ эрт харин гэр бүлтэйгээ цагийг өнгөрөөх энэхүү аян нь ажлын завгүй долоо хоногийн дундуур цаг гаргаж гэр бүлтэйгээ цагийг өнгөрөөх нь жижиг боловч чухал гэсэн санаачилгын дор хэрэгжинэ.

10.Гэр бүлд ээлтэй нийгмийн орчинг бий болгохыг дэмжих тухай хууль. Энэхүү хуулийн зорилго нь гэр бүлд ээлтэй нийгмийн орчныг бүрдүүлэх замаар ард иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, төр, нийгмийн хөгжилд хувь нэмэр

⁴¹ Нийтийн орон сууц: Засгийн газраас бага, дунд орлоготой өрхүүдэд зориулсан нийтийн орон сууцны болон хямд төсөр орон сууцны хувилбаруудыг санал болгодог тусгайлсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Түрээсийн зардал: Түрээсийн татаас нь хувийн түрээсийн орон сууцанд амьдардаг гэр бүлүүдэд, ялангуяа орлого багатай хүмүүст дэмжлэг үзүүлнэ.

оруулахад оршино. Гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх үндсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөнд (1)Гэр бүлд ээлтэй нийгмийн орчныг бүрдүүлэх бодлогын үндсэн чиглэл, зорилт; (2)Гэр бүлд ээлтэй тогтолцоог нэвтрүүлэх, идэвхжүүлэх асуудал; (3)Гэр бүлд ээлтэй компаниудыг дэмжих асуудал; (4)Гэр бүлийг халамжлах олон нийтийн орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх асуудал; Гэр бүлд ээлтэй байгууламж барих асуудал; (5)Гэр бүлд ээлтэй соёлыг түгээн дэлгэрүүлэх асуудал; (6)Гэр бүлд ээлтэй нийгмийн орчныг бүрдүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг тусгаж, Жендерийн эрх тэгш байдал, гэр бүлийн сайд, холбогдох захиргааны төв байгууллагын дарга нар, нутгийн захиргааны байгууллагуудын дарга нар гэр бүлд ээлтэй нийгмийн орчныг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлэх төлөвлөгөө жил бүр боловсруулж, хэрэгжүүлнэ.

5.6.Америкийн Нэгдсэн Улс

1.Гэрлэсэн хосуудад олгох Холбооны Засгийн газрын тэтгэлэг. Энэ нь гэр бүлийн нийгмийн халамжийг сайжруулахдаа тэтгэлэг олгох хөтөлбөрөөр дамжуулдаг. Гэрлэсэн хосуудын тэтгэмж нь хоол хүнс, эрүүл мэнд, санхүүгийн туслалцаа үзүүлэх зэрэг бэлэн мөнгөөр төлөгдөх хэлбэрээр хийгддэг.Тэтгэмжийн үндсэн зорилго нь 1 Хүн ам ба хөгжил Олон улсын бага хурлын үйл ажиллагааны хөтөлбөр /1994 он 8 хуудас / эрүүл гэрлэлт болон гэр бүлийн харилцааг дэмждэг бөгөөд тэтгэлэг нь хэрэгжиж буй хөтөлбөрийн цар хүрээ болон шинж чанараас хамааран янз бүр байдаг

2.Оюутанд олгох холбооны зээл. Энэхүү хөтөлбөрийн үндсэн зорилго нь: Хуримтлалтай болох боломжийг олгох, гэрлэсэн хүүхэдтэй хосуудыг цаашид суралцах боломжоор хангах явдал юм. Гэрлэсэн хосууд нь хувийн байгууллагуудаас зээл хүсэж явахын оронд шууд засгийн газраас зээл авахыг санал болгож байгаа.Тэтгэлгийн хөтөлбөрт АНУ-ын иргэн болон түүнтэй ижил эрх бүхий хувь хүн хамрагдаж болно. Уг иргэн нь сургуулийн гэрчилгээгээ үндэслэн хөтөлбөрт хамрагдана. Боловсролын газар болон Оюутанд санхүүгийн туслалцаа үзүүлэх байгууллагад уг хөтөлбөр нь хэрэгжих бөгөөд 1965 оны Дээд боловсролын хуулиар зохицуулагдана.

3.Гэр бүлд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр⁴². Гэр бүлийн туслалцааны газар нь гэр бүлийн эдийн засгийн аюулгүй бөгөөд тогтвортой байдлыг хангахад чиглэсэн холбооны халамжийн хөтөлбөрүүдийг удирдан хэрэгжүүлдэг. Эдгээрт Хэрэгцээт гэр бүлүүдэд үзүүлэх түр хугацааны дэмжлэг (*Temporary Assistance for Needy Families (TANF)*), Уугуул овог, аймгуудын Хэрэгцээт гэр бүлүүдэд үзүүлэх түр хугацааны дэмжлэг (*Tribal Temporary Assistance for Needy Families (Tribal TANF)*), Гэр бүлийн эрүүл харилцаа ба Хариуцлагатай аавын халамж зэрэг хөтөлбөрүүд багтдаг.

Хөтөлбөрүүдийн хүрээнд хүүхэдтэй гэр бүлүүдийн орлого бага байх тохиолдолд эдийн засгийн бие даасан байдлыг бий болгоход нь туслалцаа үзүүлдэг. Хөтөлбөрүүд нь дараах үндсэн 4 зорилготой:

1.Хүүхэд өөрийн болон хамаатан садныхаа гэр бүлд асарч тэтгүүлэх боломжийг бүрдүүлэхийн тулд хэрэгцээт гэр бүлүүдэд туслалцаа үзүүлэх;

⁴² «About OFA», 15 Арван нэгдүгээр сар 2023, www.acf.hhs.gov.

2. Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт, гэрлэлтийг дэмжих замаар хэрэгцээт буюу орлого багатай эцэг, эхийг халамжаас хамааралтай байдлаас салгах;
3. Гэр бүлээс гадуурх жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, бууруулах;
4. "Эцэг, эх хамтдаа гэр бүлийг дэмжих.

Эдгээр хөтөлбөрүүдийн санхүүжилтийг Гэр бүлийн туслалцааны газраас мужууд болон овог, аймгуудад өгдөг бөгөөд тухайн муж, овог аймгуудын захиргаанаас өөрсдийн хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийн хүрээнд иргэдэд тусламж, дэмжлэгийг үзүүлдэг. Хөтөлбөрүүдийн санхүүжилтийг бага орлоготой бөгөөд хүүхэдтэй гэр бүлд мөнгөн туслалцаа үзүүлэх болон хөтөлбөрүүдийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээний бусад үйлчилгээнд зарцуулдаг.

4. Мужуудын хөтөлбөрүүд. Миннесота мужийн Гэр бүлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (Minnesota Family Investment Program (MFIP))⁴³

Хамрагдах нөхцөл: Хүүхэдтэй болон жирэмсэн эх бүхий гэр бүлд зориулагдсан. Бага насны хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчид ихэвчлэн нийт 60 сарын хугацаанд тус хөтөлбөрт хамрагдах боломжтой. Хамрагдахын тулд анхан шатны орлогын тестэд тэнцсэн, 10,000 ам.доллараас хэтрэхгүй хэмжээний хөрөнгөтэй байх.

Үзүүлэх тусламж, дэмжлэг: Мөнгөн тусламж, хүнсний талон, ажил олох, ажилтай байхад нь туслах хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах гэх мэт.

Мөнгөн тусламж, хүнсний талон болон хүүхэд асрах тусламжийн үйлчилгээ. Тусгай ЕВТ картаар дамжуулан мөнгөн тусламж, хүнсний эрхийг олгодог. Тухайн гэр бүлийн орлогын хэмжээнээс хамааран тусламжийн хэмжээг өөр тогтоодог. Мөнгөн тусламж авч байх хугацаандаа тусламж авч буй этгээдийг ажил хийхийг шаарддаг. Тусламжийн хэмжээг тооцох гэр бүлийн орлогыг нь тодорхойлохдоо орлогынх нь тодорхой хувийг хасаж тооцдог. Зарим тохиолдолд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийг ажил хайх, сургуульд суралцах, ажиллах хугацаанд хүүхэд асрах үйлчилгээг санал болгож болно.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ. Хөтөлбөрт хамрагдаж буй ихэнх асран хамгаалагчид (эцэг, эх болон бусад асран хамгаалагч) хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө гаргахын тулд ажлын зөвлөхтэй хамтран ажилладаг. 20-оос доош насны ахлах сургуулиа төгсөөгүй эсвэл түүнтэй адилтгах хөтөлбөрт хамрагдаагүй асран хамгаалагчид боловсролын хөтөлбөрөө бүрэн дуусгах шаардлагатай байж болно. Ажлын зөвлөх эсвэл нийгмийн ажилтан эдгээр асран хамгаалагчдад ахлах сургуулийн диплом авах эсвэл ажил эрхлэх төлөвлөгөө гаргахад нь тусалдаг.

Ажил хийвэл тусламж нэмэгдэнэ. Ганц бие, ажилгүй, 2 хүүхэдтэй асран хамгаалагч хөтөлбөрт хамрагдах нөхцөлийг хангаж байвал 1,189 ам.доллартой тэнцэх хэмжээний мөнгөн тусламж болон хүнсний эрх авах боломжтой. Хэрвээ тухайн асран хамгаалагч 1 цагийн 10.33 ам.долларын цалинтай бүтэн цагийн ажил хийж эхэлбэл түүнд 1 сарын 1,777 ам.долларын тусламж олгоно.

⁴³ «Minnesota Family Investment Program (MFIP) | Minnesota Department of Children, Youth, and Families», 16 Тавдугаар сар 2024, <https://dcyf.mn.gov>.

5.Хүүхдэд түр хугацаанд үзүүлэх дэмжлэг⁴⁴. TANF Мөнгөн тусламж хөтөлбөр нь хэрэгцээт гэр бүлүүдэд түр хугацааны санхүүгийн дэмжлэг үзүүлэх хөтөлбөр юм. Энэхүү мөнгөн тусламжийг 1 хүн нийт 60 сарын хугацаанд авах боломжтой. Дараах гэр бүлүүд болон хувь хүнд тусламж үзүүлнэ:

- 1.Бага насны хүүхэдтэй;
- 2.Хүүхдийг асран хамгаалж, гэртээ амьдруулж буй хамаатан садан;
- 3.Бага насны хүүхэдтэй хамт амьдарч байгаа, түүний төрсөн ах, эгч болон өргөж авсан айлын ах, эгчийн хамааралтай хүн;
- 4.Өөр хүүхэдгүй бөгөөд сүүлийн 3 сарын хугацаанд байгаа жирэмсэн эмэгтэй;
5. Насанд хүрээгүй хүүхэдтэй дүрвэгсэд.Гэр бүлийн гишүүдийн тоо, орлогын хэмжээ зэргээс хамааран тусламжийн хэмжээг тогтоодог.

5.7.Оросын Холбооны Улс

1.Гэр бүлд үзүүлэх татварын хөнгөлөлт. Оросын холбооны Улсад хүүхдийн тооноос хамааруулан татварын хөнгөлөлт үзүүлдэг бөгөөд эхний 2 хүүхдэд сард тус бүр 1400 рублийн, 3 дахь хүүхдээс 3000 рублийн татварын хөнгөлөлт үзүүлдэг байна.⁴⁵ 2023 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн ОХУ-д бага орлоготой өрхүүдэд зориулсан бүх нийтийн хүүхдийн мөнгө тэтгэмжийг шинээр бий болгосон. Гэр бүлийн орлого нь нэг хүнд ногдох амьжиргааны баталгаажих түвшнээс доош орлоготой байвал уг тэтгэмжийг олгоно. Мөн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн байдал, орлогын хэмжээ, орлогогүй болсон шалтгааныг харгалзан үзнэ. Тэтгэмжийн хэмжээ нь бүс нутгийн амьжиргааны доод түвшний 50%, 75% эсвэл 100% байна. ОХУ-ын хувьд дунджаар 2023 онд 7 мянга, 10.5 мянга, 14 мянган рубль болно.

2.Хүүхдийн тэтгэмж. Дараах тэтгэмжүүдийг хүүхдийн насны ангиллаар олгодог байна. Тэтгэмжийн хэмжээ нь орлогын төвшнөөс хамаарна. Төрийн үүрэг бол тогтмол төлбөрөөс татгалзаж, тодорхой өрх бүрд тохируулах явдал юм. Хэмжээг гэр бүлийн гишүүн бүрийн орлого амьжиргааны доод түвшинд хүрэхээр тооцно - орлого бага байх тусам тэтгэмж их байх болно.

- 0-3 насны хүүхдийн мөнгө: /2023 онд/: жирэмсний ба амаржсаны; 1.5 нас хүртэлх хүүхдэд сар бүр олгох тэтгэмж (8630 - 33282 рубль хүртэл); бага орлоготой гэр бүлд 3 нас хүртэл олгох тэтгэмж; жирэмсний капиталыг мөнгө болгох; бүсийн нэмэлт төлбөр; хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 3 нас хүртэлх сар бүр олгох тэтгэмж-6 мянган рубль.
- 3-7 нас хүртэлх хүүхдийн тэтгэмж /2023 онд/: Орлого багатай 3-7 насны хүүхэдтэй өрхүүд 2023 онд бүх нийтийн тэтгэмж буюу бүс нутгийн амьжиргааны доод түвшний 50, 75, 100 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэмж авах эрхтэй. Энэ бүхэн гэр бүлийн санхүүгийн байдал, өмч хөрөнгө, "тэг"

⁴⁴ «Temporary Assistance for Needy Children», accessed 6 Аравдугаар сар 2024 <https://dphhs.mt.gov>.

⁴⁵ Жишээ нь: 4 хүүхэдтэй Максимын цалин сард 100,000Р гэж бодъё. Тэрээр сар бүр 13,000 Р ($100,000 \times 13\%$) хэмжээтэй хувь хүний орлогын албан татвар төлдөг. Үүний дагуу тэрээр $1,400 + 1,400 + 3,000 + 3,000 = 8,800$ Р, эхний хоёр хүүхдэд 1,400 Р, гурав, дөрөв дэх хүүхдэд 3,000 төгрөгийн татварын хөнгөлөлт үзүүлэх эрхтэй. Тиймээс Максим олон хүүхэдтэй аавын хувьд цалингаасаа 13,000 Р биш, харин сард ердөө 4,200 Р төлөх эрхтэй.

орлогын дүрмээс хамаарна. Эхний ээлжид гэр бүлд амьжиргааны доод түвшний 50% -ийн хэмжээтэй мөнгө олгоно, хэрэв энэ төлбөр нь нэг хүнд ногдох дундаж орлого нь АДТ-ээс хэтрэхгүй бол төлбөрийг 75% хүртэл, дараа нь 100% хүртэл нэмэгдүүлэх боломжтой. 3-7 нас хүүхдийн тэтгэмж 2023 онд ОХУ-ын хэмжээнд дунджаар 13,944 рубль байна. Тэтгэмжийн доод хэмжээ 6972 рубль, дээд тал нь 13944 рубль байна.

- 8-аас 17 насны хүүхдэд зориулсан тэтгэмж /2023 онд/: Жирэмсэн эмэгтэй, 8-17 насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэмжийг 3-7 насны хүүхдийн тэтгэмжтэй адил зарчмын дагуу олгоно. Өмч хөрөнгө, орлогыг нь харгалзана. Тэтгэмж нь нэг хүүхдэд ногдох орон нутгийн амьжиргааны доод түвшний тал хувь байх болно. 8-17 насны хэд хэдэн хүүхэдтэй гэр бүлд хүүхэд бүрд тэтгэмж олгодог. ОХУ-ын 2023 оны 1-р сарын 12-ны байдлаар амьжиргааны доод хэмжээ 15094 рубль, хөдөлмөрийн чадвартай иргэдийнх - 16452 рубль, тэтгэвэр авагчид - 12,981 рубль, хүүхдүүдэд - 14641 рубль байна.

5.8.Унгар Улс

1. Гэр бүл, эцэг, эхэд үзүүлэх дэмжлэг:

- **Эцэг, эхийн цалинтай чөлөө тэтгэмж.** Эцэг эхчүүд 3 жилийн хугацаанд тэтгэмж авна. Хүүхэд төрөхөөс өмнө НД-д хамрагдсан бол нярай хүүхэд асарсны тэтгэмж 168 хоногийн турш нийт орлогын 70%-аар, 168 хоногийн дараагаас хүүхдийг 2 нас хүртэл хугацаанд хүүхэд асарсны хөлс /child care fee/ нийт цалингийн 70%-иар, гэхдээ цалингийн доод хэмжээний 140%-тай тэнцүү хэмжээнээс хэтрэхгүй байна гэж тогтоосон. Гэвч 2021 оны 7 дугаар сараас гэр бүлийн орлогыг бууруулахгүй байх үүднээс нярай хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг эхийн нийт цалингийн 70% байсныг 100% болгож нэмэгдүүлсэн.
- Эцэг эх хүсвэл 2-3 нас хүртэл хугацаанд хүүхдээ асарч болох бөгөөд **хүүхэд асарсны тэтгэмжийг** /allowance/ тогтоосон мөнгөн дүнгээр олгоно. Нэг хүүхдийн тэтгэмж 83 евро (HUF 28 500) хэмжээтэй, 10% нь тэтгэврийн санд ордог. Ихэр хүүхдэд 2 дахин олгоно.
- Нийгмийн даатгалгүй бол **хүүхэд асрах тэтгэмжийг** хүүхдийг 3 нас хүртэл хугацаанд олгоно.3 ба дээш түүнээс дээш хүүхэдтэй бол хамгийн бага хүүхдийг 8 нас хүртэл хугацаанд **хүүхэд өсгөхөд үзүүлэх дэмжлэг** нэрээр олгодог.
- **Хүүхэд харах тогтолцоо.** Гэр бүлийн бодлогын гол асуудлын нэгийг ажил, гэр бүлийн амьдралыг тэнцвэржүүлэх гэж үзэж, төр ажил- гэр бүлд суурилсан нийгмийг бий болгохыг зорьдог. Энэ зорилгыг биелүүлэх гол алхам нь хүүхэд харах үйлчилгээг бэхжүүлж, 3 хүртэл насны хүүхдийн өдрийн асрамжийн үйлчилгээг үр дүнтэй бий болгох явдал гэж үзэж уг үйлчилгээг хөгжүүлж байна. 2010 онд 32000 газарт 3 хүртэл насны хүүхдийн 10.1%-ийг хамруулж байсан бол 2020 онд 52000 газарт 18,2 хувь болж өссөн.
- **Хүүхэд хооллох үйлчилгээ.** Хүүхдэд үнэгүй хоол өгөх /эсвэл хоолны мөнгө олгох/ үйлчилгээг өргөн хөгжүүлж байна. 2020 онд хүүхдийн хооллолтын төсөв 2010 оны төсвөөс даруй 3 дахин өссөн. Одоо нийт хүүхдийн 60 гаруй хувь хамрагдаж байгаагаас бага насны хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн 66%, цэцэрлэгийн насны хүүхдийн 78%, бага сургуулийн хүүхдийн 51%, ЕБС-ийн хүүхдийн 46% хоолны үйлчилгээ үзүүлж байна.
- Түүнчлэн хүүхдэд хоол өгөх үйлчилгээг орон нутгийн төр захиргааны байгууллагууд хариуцаж, хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдэд сургуулийн өвөл, зуны амралтын хугацаанд ч хоол хүргэх үйлчилгээг хэрэгжүүлдэг.
- **Сурах бичиг үнэгүй олгох.** ЕБС-ийн сургуулийн бүх сурагчид, техник мэргэжлийн сургуульд суралцагчдад сурах бичгийг бүрэн үнэгүй олгодог.
- **Хүүхдээ өсгөнгөө хөдөлмөр эрхлэх.** Засгийн газраас нийт хөдөлмөр эрхлэлтийг, ялангуяа эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийг анхаарч байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд хүүхдээ харж байгаа эмэгтэйчүүдийг ажилдаа эргэж орохыг бүх талаар

дэмжиж байна. Эдгээр эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж хөдөлмөрийн хууль тогтоомжийг шинэчлэх, ажлын байрыг хамгаалах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, хүүхэд асарсны хөлс /fee/ олгох, хүүхэд харах үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авсан.

- **Гэр бүлд албан татварын хөнгөлөлт үзүүлэх.** 2011 он хүртэл 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд нэг хүүхдэд 13 еврогийн хөнгөлөлт, 2011-2018 онд 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд нэг хүүхдэд 30 euro (HUF 10 000), 2 хүүхэдтэй бол 60 евро (HUF 20 000), 3 ба түүнээс дээш хүүхэдтэй бол 99 евро (HUF 33 000)-гаар эцэг эхийн аль нэгэнд татварын хөнгөлөлт үзүүлдэг байсан бол 2018 оноос бүх хүүхэдтэй гэр бүлд үзүүлдэг болсон.
- **Анх гэр бүл болж байгаа шинэ хосод татварын хөнгөлөлт үзүүлэх.** Анх удаагаа гэрлэсэн залуу хосод гэрлэснээс хойш 2 жилийн хугацаанд сар бүр 15 евро (HUF 5 000) -ны татварын хөнгөлөлт үзүүлнэ. Эхнэр, нөхрийн аль нэг нь анх удаагаа гэрлэсэн байх шаардлага тавигдана.
- **Оюутны зээлийн хэмжээг багасгах.** Энэхүү арга хэмжээг 2018 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлсэн. Сургалтын зээлтэй эмэгтэй нь анхны хүүхдээ тээж байгаа жирэмсний 3 дахь сараас зээлийг 3 жилийн хугацаанд эргүүлэн төлж болно. 2 дахь хүүхдээ тээж байгаа бол жирэмсний 1 дэх сараас эхлэн төлбөрийг 3 жилийн хугацаанд төлөхөөр, хүүхэд төрсний дараа үлдсэн зээлийн хэмжээг 50%-иар багасгана. 3 дахь хүүхэд төрсний дараа, үлдсэн зээлээс бүрэн чөлөөлнө.
- **13 дахь сарын тэтгэвэр.** 2021 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа энэхүү 13 дахь сарын тэтгэвэр нь жилд 4 удаа олгогдоно. 2021 оны 1 дүгээр сарын тэтгэвэр дээр нэмж нэг 7 хоногийн тэтгэвэр олгохыг 2 дугаар сард хэрэгжүүлсэн. Энэхүү тэтгэвэр нь аажмаар нэмэгдсээр 2024 он гэхэд нэг сарын тэтгэврийн хэмжээтэй тэнцэх болно.

2.Гэр бүл орон сууцтай болох, орон сууц барихад үзүүлэх дэмжлэг:

- **Гэр бүлийн орон сууцны тэтгэмж** –хүүхэдтэй гэр бүл орон сууц худалдан авах, орон байраа томсгоход, эсхүл хуучин орон сууц худалдан авахад мөнгөн тусламж үзүүлдэг.
- **орон сууцны зээл олгох**- гэр бүл шинэ, хуучин орон сууц худалдан авахад дээд тал нь 3%-ийн хүүтэй зээл олгох. 2 хүүхэдтэй гэр бүл 30000 евро (HUF 10 million)-гийн, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл 45000 евро (HUF 15 million) – гийн зээл авахаар өргөдөл гаргаж болно. Хэрвээ гэр бүл хөдөөгийн гэр бүлд үзүүлэх орон сууцны тэтгэмжид хамрагдсан бол дээр дурдсан хэмжээний тал хувиар зээл авч болно.
- **хөдөөгийн гэр бүлд үзүүлэх орон сууцны тусламж**- энэхүү тэтгэмж нь Унгарын хөдөө хөтөлбөрийн хүрээнд 2019-2022 онд 5000 хүртэл хүн амтай суурин газрын хэцүү эмзэг нөхцөлд байгаа 2600 оршин суугчид үзүүлэх тусламж юм. Нэг хүүхэдтэй гэр бүлд 1740 евро (HUF 600 000)-гийн, 2 хүүхэдтэй бол 7500 евро (HUF 2,6 million)-гийн, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй бол 30000 евро (HUF 10 million) -гийн тэтгэмж үзүүлнэ.
- **зээлийн хүүг бууруулах**- 2 хүүхэдтэй гэр бүлийн орон сууцны зээлийг 3000 евро (HUF 1 million) -гаар, 3 хүүхэдтэй гэр бүлийнхийг 11600 евро (HUF 4

million)-гаар бууруулах. Нэмж төрүүлсэн хүүхдийн тоогоор /4, 5 гэх мэт/ гэр бүлийн зээлийн 3000 еврогоор нэмж бууруулна.

3. Гэр бүлийг хамгаалах 7 хөтөлбөр:

- Унгар нь улсын хүн ам зүйн өөрчлөлттэй уялдуулан **гэр бүлийг хамгаалах** талаар бас тодорхой арга хэмжээнүүдийг авсныг бид бас анхааран судлах нь зүйтэй юм. Унгар Улс нь хүн амын өсгөх бодлогыг баримталж байгаа бөгөөд 2019 онд хүн ам зүйн өөрчлөлттэй уялдуулан гэр бүлийг дэмжих, хүүхдийн төрөлтийг урамшуулах, залуу хүмүүст гэр бүлтэй болох боломжийг олгох зорилгоор гэр бүлийг хамгаалах дараах 7 арга хэмжээ нэвтрүүлсэн.
- **Хүүхэд хүлээх үеийн тэтгэмж:** Эхнэр нь 18-аас 41 насны гэрлэсэн хос 30000 еврогийн (HUF 10 million) хүүгүй зээл авахаар арилжааны банканд хандах боломжтой. Сард төлөх зээлийн хэмжээ нь 150 евро (HUF 50 thousand) -гоос ихгүй байх ба 20 жилийн хугацаанд төлөхөөр зээлийн графиктай байна. Хосууд гэрлэснээс хойших 5 жилийн хугацаанд нэг хүүхэд төрүүлсэн буюу өргөн авсан бол хүүгүй зээл төлөлтийн хуваарь хэвээр үлдэх ба төлөлтийг 3 жилээр хойшлуулж болно. 2 дахь хүүхэдтэй болсны дараа зээл дахиад 3 жилээр хойшлогдох ба үлдсэн төлбөрийн 30%-ийг хүчингүй болгоно. 3 дахь хүүхэдтэй болсны дараа үлдсэн зээлийг бүрмөсөн хүчингүй болгоно. Зээлийг Засгийн газар батлан даана. Энэхүү тэтгэмжийг 2019 оны 7-р сараас 2022 оны 12 дугаар сарын 31 хүртэл хугацаанд хэрэгжүүлэх юм.
- **Хуучин орон сууц худалдаж авах зээлийг сунгах:** 2019 оны 7 дугаар сараас өмнө орон сууцтай болохоор тэтгэмж авсан бол шинээр байр барих, худалдан авахад зориулан дээд тал нь 3%-ийн хүүтэй зээлийг олгоно. 2 хүүхэдтэй бол 30000 евро (HUF 10 million)-гийн, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй бол 45000 евро (HUF 15 million) -гийн зээл олгож байсан.
- 2019 оны 7-р сараас эдлэн уг зээлийг мөн хуучин орон сууц худалдан авахад зориулж өгдөг болгож өргөжүүлсэн. Орон сууцны тэтгэмж, зээл авах боломжтой хуучин орон сууцны 105000 евро (HUF 35 million)-гийн үнийн босгыг хүчингүй болгосон. Европын Эдийн засгийн бүсээс гадна амьдарч буй Унгарын иргэдийг нийгмийн даатгалд хамрагдсан байхыг нь харгалздаг. Түүнчлэн хэрвээ хуучин орон сууц нь тогтвортой амьдралын хэрэгцээг хангаж байвал түүнийг санхүүжилт олгодог. 2019 оны 7-р сараас эхлэн энэхүү зээлийг мөн хуучин суурин дээр шинэ орон сууц барихад авах боломжтой болсон. Энэхүү арга хэмжээ нь 2019 оны 7-р сараас эхлэн хэрэгжсэн.
- **Удаан хугацааны /ипотекийн/ зээлийн эргэн төлөлтөд үзүүлэх хөнгөлөлтийг сунгах:** 3 ба түүнээс дээш хүүхэдтэй болохоор төлөвлөж буй гэр бүлд үзүүлж байсан ипотекийн зээлийн 3000 евро (HUF 1 million)-гийн хөнгөлөлтийг өргөтгөж уг хөнгөлөлтөд 2 дахь хүүхдээ хүлээж буй гэр бүлийг хамруулах болсон. 12000 евро (HUF 4 million)-гийн хөнгөлөлтийг 3 дахь хүүхдээ хүлээж буй гэр бүлд үзүүлнэ. Цаашлаад дараагийн хүүхэд тутамд 3000 еврогийн хөнгөлөлт үзүүлнэ. Ипотекийн зээлийн хөнгөлөлтийг жирэмсний 12 дахь долоо хоногтойгоос нэхэмжилж болно. Энэхүү арга хэмжээ нь 2019 оны 7-р сараас эхлэн хэрэгжсэн.

- **Ам бүл олонтой гэр бүл машин худалдан авах хөтөлбөр:** 3-аас дээш хүүхэдтэй буюу 3 дахь хүүхдээ хүлээж буй гэр бүл доод тал нь 7 хүний суудалтай шинэ зорчигчийн машин худалдан авахад зориулан 7500 евро (HUF 2.5 million)-гийн /гэхдээ худалдан авах үнийн дүнгийн 50%-иас ихгүй байх/ тэтгэмж үзүүлнэ. Энэ талаар хүсэлтээ Унгарын төрийн санд гаргана. Энэ арга хэмжээ 2019 оны 7-р сараас 2022 оны 12 дугаар сарын 31-ний хооронд хэрэгжинэ.
- **4 ба түүнээс дээш хүүхэдтэй эмэгтэйн хувийн орлогоос авах албан татварыг бүрэн чөлөөлөх:** 2020 оны 1 дүгээр сараас эхлэн 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эмэгтэйн хувийн орлогоос авах албан татварыг бүрмөсөн чөлөөлсөн /татварын хувь 15/. Гэхдээ энэ нь зөвхөн эмэгтэйн хөдөлмөр эрхэлж олсон орлогод хамаарна. Энэхүү хөнгөлөлт нь хүүхдүүд нь насанд хүрсэн эмэгтэйд ч хамаарна. Энэ арга хэмжээ 2020 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжсэн.
- **Эмээ, өвөө нарт хүүхэд харсны төлбөр олгох:** Хүүхдийн эцэг эх хоёул /эсхүл ганц бие/ ажиллаж байгаа бол тэтгэвэртээ гараагүй эмээ, өвөө нарт энэ тэтгэмж олгогдоно. Энэ тохиолдолд хүүхдээ асарсны төлбөр эцэг, эхэд олгогдохгүй, эмээ өвөөд олгогдоно. Хөтөлбөрийн зорилго нь эмээ, өвөөг ач, зээгээ харахыг урамшуулах зорилготой. Өвөө эмээгийн зөвхөн нэг нь өргөдөл гаргах эрхтэй, өргөдлийг олон ач зээтэй болсны дараа /2 ач зээ харж байж авдаг бололтой/ гаргана. Энэ арга хэмжээ 2020 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжсэн.
- **Хүүхэд харах үйлчилгээ хөгжүүлэх хөтөлбөр:** Хүүхдээ харж буй ч ажилдаа орохыг хүсэж буй эцэг эхчүүдийг боломж олгох зорилгоор хүүхэд харах газар – цэцэрлэгийг олон болгож нэмэгдүүлэхийг зорьж байна. ЗГ одоо байгаа 52000 газрын 2022 онд 70000 болгохоор төлөвлөсөн. Хөтөлбөрт хувийн хэвшлийн хүүхэд харах үйлчилгээ үзүүлэгчдийг ихээр хамруулж байгаа. Энэхүү хөтөлбөрийг Гэр бүлийн сайдын зөвлөл хариуцан хэрэгжүүлж байна. Хөтөлбөр 2019 онд хэрэгжиж эхэлсэн ба 2022 онд дуусна.

4.Гэр бүлийг дэмжих орон сууцны хөтөлбөр:

Унгарын Засгийн газраас аль болох олон гэр бүлийг өөрийн гэсэн орон байртай болохыг дэмжиж байгаа бөгөөд энэ хүрээнд өмнө хэрэгжүүлж байгаагүй том орон сууцны хөтөлбөрийг энэ онд хэрэгжүүлж байна. Гэр бүлийн амьдралын үе шат, нөхцөл байдалд нийцүүлэн дараах 8 зүйл бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг зорьж байна:

- **Шинээр барьсан орон сууцны НӨАТ -5% болгосон.** 2021 оны 1-р сараас 2022 оны 12-р сарын хооронд шинээр барьсан байшинг худалдан авах болон гэрээлэн бариулахад 27% байсан НӨАТ-ыг 5% болгосон.
- **НӨАТ-аас чөлөөлөх.** 2021 оны 1-р сараас 2022 оны 12-р сарын хооронд шинээр барьсан байшинг худалдан авах болон гэрээлэн бариулж буй хүүхэдтэй гэр бүл “орон сууцны тэтгэмж” авахаар хүсэлт гаргасан бол НӨАТ-аас чөлөөлөгдөнө. НӨАТ-аас чөлөөлөгдөх хүсэлтийг тэтгэмж авах хүсэлтийг гаргахдаа банканд хамт өгнө.

- **Барилгын эзэнд НӨАТ-ын буцаан олголт өгөх.** Өөрийн хөрөнгөөр амьдрах сууцаа барьж буй хүмүүст НӨАТ-ын 27%-ийг эргүүлэн төлнө. 15000 евро (HUF 5 million) хүртэлх НӨАТ-ыг буцаан төлнө. НӨАТ-ын 5%-тай тэнцэх татаасыг буцаан авахаар банканд өргөдөл гаргана.
- **Байрны засварыг дэмжих.** 2021 оны 1-р сараас эхлэн хүүхэдтэй гэр бүлийн орон сууцны засварт шаардагдах зардлын талыг төр дааж байна. Төрөөс даах зардал нь 9000 еврогоос хэтрэхгүй байна. Энэхүү хөнгөлөлтөд нэг хүүхэдтэй, хүүхэд нь 25 хүртэл насны эцэг эхтэйгээ хамт амьдардаг бол, мөн хэрвээ хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй бол насны хязгаагүйгээр хамрагдана.
- **Байрны засварын зээл.** Байрны засварын дэмжлэгт хамрагдах боломжгүй гэр бүл 18000 евро хүртэлх зээлийг 10 жилийн хугацаатай, 3%-ийн хүүтэй авч болно. Засварыг бүрэн хийсний дараа үлдсэн зээлийг 9000 хүртэл еврогоор хөнгөлүүлэх /өмнөх зүйлд дурдсан/ байрны засварын дэмжлэг авахаар хүсэлтээ тавьж шийдвэрлүүлнэ. Түүнчлэн байрны засварын дэмжлэг дээр нэмж зээлийн хүүг багасгах боломжтой.
- **Үл хөдлөх хөрөнгийн шилжүүлгийн татвараас чөлөөлөх.** 2021 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн өрх гэр бүлүүд орон сууц худалдан авахдаа “Орон сууцны тэтгэмж” авахаар хүсэлт гаргасан бол үл хөдлөх хөрөнгийн шилжүүлгийн татвараас чөлөөлөгдөж байна. Хүүхэдтэй болохыг төлөвлөж буй хосууд, хүүхэдтэй гэр бүл шинэ, хуучин орон сууцыг “Орон сууцны тэтгэмж”-ийн дэмжлэгтэйгээр худалдан авах хүсэлт гаргасан бол үл хөдлөх хөрөнгийн шилжүүлгийн татвараас шууд чөлөөлөгдөнө. Өөрөөр тэд үл хөдлөх хөрөнгийн шилжүүлгийн 4%-ийн татварыг төлөхгүй.
- **Гэр бүл хамтаар олон үеэр хамт амьдарч буй байр сууцыг дэмжих.** Энэхүү арга хэмжээ нь гэр бүлийг нэгэн дээвэр дор /байшинд/ боловч тусдаа өрөө сууцанд өрх болон амьдарч буйг дэмжих зорилготой. Өөрийн байшинг 2 давхар болгож, эсвэл дээврээ тохижуулах зэргээр хүүхдүүдээ өөрийн эзэмшлийн нэгэн байшинг томсгож, засаж сэлбэж өрх тусгаарлах арга хэмжээ авах дэмжиж “Орон сууцны тэтгэмж”-ийг өгдөг.
- **Нотариатын төлбөрийг бууруулсан.** Орон сууцны хөнгөлөлт, зээлийн нотариатын төлбөрийг 55-65% бууруулах арга хэмжээ авсан.

5.9.Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант

Гэрлэсэн хосуудад татварын хөнгөлөлт. Гэрлэсэн хосуудад жилд төлөх татварын хэмжээгээ 304-791.5-н фаундаар бууруулах хөнгөлөлтийг олгодог. Энэ хөнгөлөлтөд заавал гэрлэсэн байх, нөхөр буюу эхнэртэйгээ хамт амьдарч байх шаардлагыг хангасан тохиолдолд хамрагдана. Хойд Европын орнууд нийтлэг хүртээмжтэй байдлыг чухалчилж байгаа бол Англид дунджаас дээш орлогын нөхцөлтэй тэтгэмжийн тогтолцоог баримталдаг.⁴⁶

⁴⁶ Д.Аюуш et al., Гэр бүлийн харилцааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал: Бусад орнуудын туршлага (Харьцуулсан судалгаа), УБ, «Парламент» судалгааны эмхэтгэл, Боть 32 (УБ: Улсын Их Хурлын Тамгын газар Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн, 2021), 402.

Хүүхдийн мөнгө. Гэр бүлийн орлого харгалзахгүйгээр 16 нас хүртэлх бүх хүүхдэд олгодог. Мөн хүүхдийн татварын кредит (child tax credit) ба ажлын татварын кредитийг (working tax credit) хүүхэд дэмжих зорилгоор нэмэлтээр олгоно. Хүүхдийн татварын кредитэд жилийн орлого нь €18,821-с хэтрэхгүй бол 7 хоногт €78.99 олгодог. Мөн жилийн орлого € 3,640-р нэмэгдсэн эхний жилд тэтгэлгийн кредитийг бууруулахгүй. Ингэснээр орлого багатай эцэг эхчүүдэд хөл дээрээ зогсох хугацааг бүрдүүлдэг байна.

16-18 настай хүүхдэд дор хаяж 12 цагийн боловсрол ба ур чадвар олгох сургалтад суувал **боловсрол дэмжих тэтгэлгийг** олгоно. Энэ тэтгэлгийн үндсэн зорилго нь бага орлоготой өрхийн хүүхэд боловсрол гүнзгийрүүлэн эзэмшиж, ажилд орох магадлалыг нь сайжруулах зорилготой.

5.10.Япон улс:

Хүүхэд өсгөж буй бүх өрхийн гурван нас хүртэлх хүүхдэд сар бүр 15,000 иен, дараа нь гурван наснаас ахлах сургуулийн насны хүүхдэд 10,000 иен төлнө. Олон хүүхэдтэй өрхөд санхүүгийн тусламж авах хэрэгцээ их байгаа учраас гурав дахь болон түүнээс дээш хүүхэд бүрд сар бүр 30,000 иен олгоно.

Дүгнэлт

Гэр бүлд үзүүлэх дэмжлэгийг тодорхойлохдоо чиглэл тус бүрээр харахад ашиглаж болох үүднээс улс орнуудын гэр бүлийг дэмжих талаар авч буй арга туршлагыг нэлээд дэлгэрэнгүй орууллаа. Гэр бүлд татварын хөнгөлөлт, үзүүлэх, орон сууцтай болоход үзүүлдэг дэмжлэг, хөтөлбөрүүд, түүнчлэн гэр бүлд үзүүлэх үйлчилгээг хэрхэн зохион байгуулж байгаа зэрэг олон талаас нь харж судаллаа. Улс орнууд гэр бүлийн эрхэм гишүүн-хүүхэд, эхчүүдэд илүү дэмжлэг үзүүлдэг нь харагдаж байна. Тухайлбал,

Хүүхдийн мөнгөний тэтгэмж нь дэлхий даяар ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүүхдийн мөнгөний тэтгэмж нь бүх хүүхдийг хамарсан, эсвэл зорилтот бүлэгт чиглэгдсэн байж болох бөгөөд заримдаа сургуульд хамрагдсан байх, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байх зэрэг тодорхой нөхцөл болзолтойгоор олгогддог. Ерөнхийдөө хүүхдийн мөнгөний тэтгэмж нь хүүхдийн сайн сайхан байдал, түүнчлэн эрүүл мэнд, боловсрол, хүнсний аюулгүй байдал зэрэг хүн капиталын хуримтлалд эергээр нөлөөлж, улмаар ядуурлыг бууруулахад тус дөхөм болдог нь нотлогдсон. Гэсэн хэдий ч энэ нь холбогдох нөхцөл байдлаас ихээхэн шалтгаалдаг.

Мөнгөн тэтгэмж нь хүн капиталын хуримтлалд эергээс нөлөөлөхийн тулд үйлчилгээний чанар маш сайн байх шаардлагатай байдаг. Тиймээс нөөц бололцоо хомс байгаа үед хүүхдийн мөнгөний тэтгэмжийг тэлэх нэрийдлээр үйлчилгээг хумьж болохгүйг НҮБ-ын хүүхдийн сангаас сануулсан.

Гэр бүлд хүүхдийн тоогоор мөнгөн дэмжлэг үзүүлэх: Франц, Бельги, Австри, Япон зэрэг өндөр хөгжилтэй орнууд хүүхдийн тоо, эцэг эхийн орлогоос хамаарч хүүхэдтэй өрхийг дэмжих бодлогыг хэрэгжүүлдэг байна⁴⁷. Франц Улс

⁴⁷ Нийгмийн халамжийн хуулийн төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээний тайлан, Дэлхийн банк, 2022 он

хүүхдийн мөнгийг 16 нас хүртэл олгодог бөгөөд хүүхдийн тооноос хамаарч тэтгэмжийн хэмжээ шатлалтай байдаг байна.

Австрали Улсын хувьд хүүхэд өсгөх зардлыг бууруулах зорилгоор хүүхэдтэй гэр бүлд тэтгэмж, урамшуулал олгох ба хэмжээ нь тухайн өрхийн орлогоос хамаардаг байна.. БНСУ-ын хувьд 0-6 насны бүх хүүхэд Эрүүлийг хамгаалах яам болон Нийгмийн хамгааллын газраас сард 100 мянган воны тэтгэмж олгодог. Харин хүн амын амьжиргааны түвшний үзүүлэлтээр өндөр байгаа 10 хувьд тэтгэмжийг олгодоггүй.

Хүүхэд өсгөж буй бүх өрхөд гурван нас хүртэлх хүүхдэд сар бүр 15,000 иен, дараа нь гурван наснаас ахлах сургуулийн насны хүүхдэд 10,000 иен төлөх болно. Тэгээд ч олон хүүхэдтэй өрхөд санхүүгийн тусламж авах хэрэгцээ их байгаа учраас гурав дахь хүүхэд, дараа нь хүүхэд бүрд сар бүр 30 мянган иен олгохоор болсон.

Казахстан Улсын хувьд олон хүүхэдтэй гэр бүлд зориулсан тэтгэмжийг дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлд өрхийн орлогыг үл хамааран тэтгэмж олгодог бөгөөд хүүхдийн тооноос хамаарч тэтгэмжийн хэмжээ ялгаатай байдаг байна.

Гэр бүлд орон сууцны дэмжлэг үзүүлэх нь Швед улс, БНСУ, Унгар Улсын туршлагаас харж суралцах боломжтой байна. Улс орны туршлагуудаас Унгар улс нь гэр бүлийг нэлээд тодорхой, олон чиглэлээр дэмжсэн сайн туршлагатай байна. Тухайн улсын гэр бүлийг дэмжсэн арга хэмжээнүүд нь гэр бүлийг дэмжих, хүн амын өсөлтийг дэмжих, эх хүүхдийг хамгаалах зэрэг олон ач холбогдлыг харгалзан тогтоосон нь харагдаж байгаа тул нэлээд дэлгэрэнгүй байдлаар судалгаанд орууллаа.

Татварын хөнгөлөлтөөр гэр бүлийг дэмжиж буй туршлагууд байна. Тухайлбал, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, ОХУ, Унгар улс гэр бүлд хүүхдийн тоогоор татварын хөнгөлөлт үзүүлж байна. Түүнчлэн Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант улс, Унгар улс нь гэрлэсэн хосуудад татварын хөнгөлөлт үзүүлж байна. Энэ нь нөгөө талаар залуу гэр бүлд дэмжлэг болж буй хэрэг юм.

Гэр бүлд боловсролын дэмжлэгийг хэрхэн үзүүлж байгаа талаар дурдахад Франц улс- хүүхдүүдэд хичээлийн шинэ жилийн тэтгэмж, БНСУ хүүхдэд олгох боловсролтой холбогдох зардлын дэмжлэгийг /тэтгэлэг, тусламж/ олгож, Унгар улс сурах бичиг үнэгүй олгож, оюутны зээл багасгах арга хэмжээ хэрэгжүүлдэг байна.

АНУ нь гэрлэсэн хосуудад Холбооны Засгийн газрын тэтгэлэг буюу оюутны холбооны зээл олгож байгаа нь гэрлэсэн хүүхэдтэй хосуудыг цаашид суралцах боломжоор хангасан явдал болж байна. Унгар улс ам бүл олонтой гэр бүл машин худалдан авах хөтөлбөр хэрэгжүүлдэг бол БНСУ олон соёлт гэр бүлийг онцгойлон дэмжиж байна.

Гэр бүлд нийгмийн цогц үйлчилгээ үзүүлэх, төвийн үйлчилгээ, ээлтэй орчин бий болгох дээр БНСУ-аас туршлага судлах шаардлагатай байна. Тухайлбал, байна. Түүнчлэн гэр бүлд ээлтэй системийг хэрэгжүүлж буй

корпорацууд, аж ахуйн нэгж, байгууллагуудад үнэлгээ хийж, гэр бүлд ээлтэй байгууллагад гэрчилгээ олгох гэрчилгээ олгож, гэрчилгээтэй байгууллагуудыг урамшуулж байна. Мөн долоо хоногийн 3 дахь өдөр болгон ажилтнууд ажлаасаа яг тарах цагтаа гарч, гэртээ эрт харин гэр бүлтэйгээ цагийг өнгөрөөх "Гэр бүлийн хайрын өдөр" аян хэрэгжүүлдэг байна.

Иймд хуулийн төсөлд гэр бүлийг үзүүлэх дэмжлэгийг тодорхойлохдоо гадаад орны сайн туршлага бүрийг анхааралтай гүнзгийрүүлэн судалж, санаа авч, өөрийн орны нөхцөлд тохирсон төрийн дэмжлэгийг тодорхойлох нь зүйтэй юм.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Одоо мөрдөгдөж буй Гэр бүлийн тухай хуулиар хувийн эрх зүйд хамаарах гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бусад тооцох нөхцөл, журам, эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа, тэжээн тэтгэх, үрчлэлт, хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлэх, асран хамгаалах, харгалзан дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Харин өнгөрсөн хугацаанд төрөөс гэр бүлийн ашиг сонирхлыг хамгаалах, хангах зорилтой гэр бүлийн онцлог, хэв шинжид тохирсон тусламж, дэмжлэг, нийгмийн ажил үйлчилгээ, үүнтэй холбогдуулан төрийн байгууллагуудын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлсон эрх зүйн орчин байхгүй байна.

Гэр бүлийн харилцааг хувь хуний асуудал гэхээс илүүтэйгээр улс орны нийгмийн суурь бүтэц болох гэр бүлийн тогтвортой байдлыг хадгалах, хамгаалахыг төрөөс анхаарч гэр бүлд тодорхой дэмжлэгүүдийг үзүүлэх, түүнчлэн гэр бүлийн гишүүдийн харилцаа тогтвортой байснаар тухайн улсын нийгмийн тогтвортой байдал хангагдах тул гэр бүлийн харилцаа, нийгэмшлийг тогтворжуулахад анхаарч гэр бүлд цогц нийгмийн үйлчилгээ үзүүлэх зэрэг арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлага байна.

Манай улсын Олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийг хэрэгжүүлж, уг хуулиар жирэмсэн болон 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхчүүдэд сар бүр тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, 4 ба түүнээс дээш хүүхэдтэй эхийг Эхийн алдар одонгоор урамшуулж жил бүр удаа тэтгэмж олгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байгаа нь амьжиргааны түвшин харгалздаггүй, хүн амын өсөлтийг дэмжих, гэр бүлд чиглэсэн бодлого юм. Түүнчлэн өрхийн гишүүн тус бүрд очиж байгаа өөр өөр төрлийн тэтгэмжийг хүүхдийн мөнгөн тэтгэмж дээр нэмж олгох, насан туршид нь олгож байгаа тусламжийн хэлбэрийг өөрчлөх гэх зэргээр сайжруулах шаардлагатай асуудлууд нэлээдгүй байгаа нь энэ тандан судалгаанаас харагдаж байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэх хамгийн зохистой шийдлийг олох зорилгоор урьдчилан тандах судалгааг хийж Аргачлалын 9-д заасны дагуу дараах зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

1. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, гэр бүлийн харилцааны хувийн эрх зүйн орчинг сайжруулахаар ажиллаж байгаатай зэрэгцүүлэн Гэр бүлийг дэмжих тухай хуулийг шинээр боловсруулж, хамтад нь Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн батлуулах;

2.Хүүхэд, гэр бүл, эхчүүдэд чиглэсэн тэтгэмж, хөнгөлөлт үзүүлэхтэй холбоотой хуулийн эрх зүйн орчинг нэгтгэн нэг хуулиар зохицуулах хүрээнд хуулийн төсөл боловсруулах;

3.Одоогийн Олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай, Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль тогтоомжийн хүрээнд олгож байгаа тэтгэмжийг Монгол Улсын хүн амын бодлого, цаашдын хэтийн төлөвтэй уялдуулан илүү сайжруулж, цаашид гэр бүлийн дэмжлэг болгох;

4.Хүүхдийн тоо, гэр бүлийн орлого, амьжиргааны түвшинд харгалзан өрх гэр бүлд чиглэсэн дэмжлэгийг уян хатан, хүртээмжтэй болгох;

5.Гэр бүлд бэлэн мөнгөн тэтгэлгээс гадна дэлхийн улс орнуудын жишгээр олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжих бусад салбарын бодлогоор дамжуулан үзүүлэх хөнгөлөлт урамшууллыг бий болгох;

6.Гэр бүлийг дэмжих хөгжлийн, нийгмийн үйлчилгээг хуулиар зохицуулж, хүн амын бүлэг тус бүрд бус гэр бүлийн гишүүд бүгдээр хүртэх цогц нийгмийн үйлчилгээг бий болгож хэрэгжүүлэх;

7.Гэр бүлд үзүүлэх нийгмийн үйлчилгээг тодорхойлох.

8.Нийгмийг гэр бүлд ээлтэй болгох, энэ талаар нийгмийг соён гэгээрүүлэх, төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг чиглүүлэх, оролцуулах.

---oOo---

**“ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ҮР
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР
2025 он

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, СОНГОХ ҮНДЭСЛЭЛ.....	2
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ.	3
2.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:	3
2.2."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:	4
2.3."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	4
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ.....	5
3.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	5
3.2."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	8
3.3."Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ.....	11
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	12
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	13

“ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад “энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх” гэж заасны дагуу Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн бичвэрийг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын² 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-г баримтлан доорх үе шаттайгаар хийв. Үүнд:

Нэг. Шалгуур үзүүлэлтийг сонгох

Хоёр. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох

Гурав. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох

Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж өгөх.

Үр нөлөөний үнэлгээ хийсэн хуулийн төслийн хувилбарыг энэхүү тайланд хавсаргав.

НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, СОНГОХ ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1.Зорилгод хүрэх байдал;

2.Харилцан уялдаа;

3.Практикт хэрэглэх боломж зэрэг болно.

¹ Төрийн мэдээлэл сэтгүүл. 2015 он №25

² Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдаж чадсан эсэх болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн бөгөөд түүнд хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзсэний дагуу хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн бөгөөд хуулийн зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ буюу зохицуулалтыг сонгож авсан болно.

“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь тооцдог тул энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээг уг тайлангаас тусдаа бие даасан үнэлгээгээр тооцох болно.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэх бөгөөд хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль холбогдох бусад хуультай болон хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр сонгов.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтууд дагаж мөрдөх болон хэрэгжүүлэхэд боломжтойгоор боловсруулагдаж чадсан эсэх, дагаж мөрдөх боломжтой эсэх, тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг үнэлнэ.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

2.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэхээр зарчмын шинжтэй өөрчлөлтийг үнэлэхээр дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн зорилгод хүрэх байдлыг сонгон үнэлэх

Зорилгод хүрэх байдал/ дагалдах зорилтууд	Сонгосон зүйл заалт
Гэр бүлд орон сууцны дэмжлэг үзүүлэх боломжтой эсэх	Хуулийн төслийн 7 дугаар зүйл.
Гэр бүлтэй ажилчдын хэрэгцээ, шаардалгад нийцсэн ажил, амьдралын тэнвцэрийг хангах арга хэмжээ авах боломжтой эсэх	Хуулийн төслийн 9 дүгээр зүйл.

2.2. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Хуулийн төсөл нь өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг "харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар тогтоох юм. Уг шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зохицуулалтыг үнэлэхдээ тодорхой стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах тул хуулийн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, зохицуулалтыг бус төслийг бүхэлд нь сонгон авч үнэлэх нь зүйтэй тул хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхээр сонгосон болно.

2.3. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1/ хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэгтэй холбоотой заалтуудыг сонгон авч "Практикт хэрэгжих боломж"-ын тооцсон болно. Сонгосон зүйл заалтуудыг дэлгэрэнгүйг хүснэгтээр үзүүлэв.

Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг сонгон үнэлэх

Д/д	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
1	Хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг	Хуулийн төслийн Гуравдугаар бүлэг

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлнэ.

Хүснэгт 3

д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод хүрэх байдлын дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
2	Харилцан уялдаа	Харилцан уялдааг шалгах: Хуулийн төслийн уялдаа холбоог аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.
3	Практикт хэрэгжих боломж	Практикт хэрэгжих боломжийг шалгах: Хуулийн төслийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэхэд дүн шинжилгээ хийнэ.

Дээрх урьдчилан сонгож авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

3.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгах ба хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн 7 дугаар зүйл. Орон сууцны дэмжлэг үзүүлэх талаарх заалтуудын зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

2013 онд Засгийн газраас хэрэгжүүлсэн Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд Монголбанк, Барилгын яам (тухайн үеийн нэрээр) хамтран “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг баталсан. Энэ дэд хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас иргэдэд 80 хүртэлх м.кв бүхий орон сууц худалдан авахад зориулсан жилийн $8 \pm$ хувийн хүүтэй, 20 хүртэлх жилийн (2017 оны 3 дугаар сараас эхлэн 30 жил болгож сунгасан) хугацаатай ипотекийн зээл олгох зорилгоор, тус хөтөлбөрт оролцогч арилжааны банкуудад богино хугацаат санхүүжилтийг олгож байна.

Засгийн газрын 2023 оны 483 дугаар тогтоолын “2.1-д “Үндэсний орон сууцны санхүүжилтийн корпорацийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, 2024 оны II улиралд багтаан байгуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т” даалгасан. Үүний хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг боловсруулж, олон нийтээс санал авч байна.³

Иймд гэр бүлд үзүүлэх орон сууцны дэмжлэгийн асуудлыг Үндэсний орон сууцжуулалтын тухай хууль (хэрэв батлагдвал) болон энэ хуулиар шийдвэрлэх, эдгээр хуулиудын уялдаа холбоо, системчлэлийг хангах шаардлагатай байна. Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөлд “орон сууц зайлшгүй хэрэгцээтэй иргэнийг зааж, түүнийг орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулах, бусад хэлбэрийн орон сууцжуулалтын хөтөлбөрт хамруулахад давуу эрх эдлүүлэх талаар, мөн ипотекийн зээлийн урьдчилгаа, барьцаа хөрөнгөд тооцох болох хөрөнгийн талаар хуулийн төсөлд тусгасан байна. Гэсэн хэдий ч нэгэнт Үндэсний орон сууцжуулалтын тухай хууль батлагдаагүй, энэ хоёр хуулийн төсөл нь багц хуулийн төсөл биш тул Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд батлагдаагүй байгаа хуулийн төслийн заалтыг эш татах боломжгүй.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгасан “орон сууцны дэмжлэг”-ийн зохицуулалт нь Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөлд тусгагдсан “орон сууцны дэмжлэг”-ийн зохицуулалтаас ялгаа нь Үндэсний баялагийн сангийн тухай хуульд заасан “Хуримтлалын сан”-аас орон сууцны дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгасан, ялангуяа хүүхэдтэй залуу гэр бүл, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийг дэмжихээр тусгасан байна. 2022 онд хийсэн “Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ, үйлчилгээ /Дундговь аймгийн жишээ дээр/ судалгаанд “Монгол улсад залуу гэр бүлийг хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд нь туслах, богино хугацааны тусламж үзүүлэх, тэтгэлэг олгох, байр орон сууцаар дэмжих, хөдөлмөрт бэлтгэх зэрэг залуу гэр бүлийг дэмжих тогтолцоо сул байна. ... залуу гэр бүлд байр орон сууц

³ <https://mcud.gov.mn/forum/42>

худалдан авах, орон сууцны нөхцөлөө сайжруулах зэрэг асуудал тулгамддаг” гэж дурджээ.⁴ Иймд хуулийн төслийн дээрх заалт нь хуулийн зорилготой нийцэж байна.

Хуулийн төслийн 7.1.2-т “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 4.1.6-д заасан хуримтлалын нэрийн дансны мөнгөн хөрөнгө орон сууцны төлбөрийн 5 хувьд хүрсэн тохиолдолд Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд заасны дагуу ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргах,” гэж тусгажээ.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйл. Ажил, амьдралын тэнцвэрийг хангах талаарх заалтуудын зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

2021 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-т “Ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ” хэмээн анх удаа “ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах” зохицуулалт тусгагдсан. Гэвч хэрхэн “ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах” нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй байна.

Ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах хүрээнд ажилчдын хэрэгцээ, шаардлага, нөхцөл байдал харилцан адилгүй тул харилцан адилгүй байдгыг харгалзан ажлын уян хатан зохицуулалтыг хийх нь зүйн хэрэг. Өөрөөр хэлбэл, байгууллага бүр ажилчдын санал, хүсэлтийг судалж, үнэлгээ хийж, өөрийн байгууллагад тохирсон зохицуулалтыг шаардлагатай байдаг. Ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангах нь ажил олгогч ба ажилтан хоёрын аль алиных нь хэрэгцээг хангах, харилцан үр ашигтай харилцааг бий болгох бий болгох зорилготой байдаг тул энэ нь талуудын сайн дурын оролцоо, зөвшилцөлд суурилах шаардлагатай байдаг. Иймд Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд гэр бүлтэй ажилчдын онцлогт тохирсон ажил, амьдралын тэнцвэрийг хангах арга хэмжээнүүдийг тусгасан байх ба эдгээрийг хэрэгжүүлэхийг ажил олгогчид заавал үүрэг хүлээлгээгүй, харин ажил олгогч, ажилтнуудтайгаа зөвшилцөн өөрийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээндээ тусган хэрэгжүүлэхээр тусгасан нь оновчтой болсон гэж дүгнэж байна. Өөрөө хэлбэл, эдгээр арга хэмжээ нь байгууллага гэр бүлтэй ажилчдынхаа хэрэгцээ, шаардлагад нийцсэн байдлаар тэдний ажил, амьдралын тэнцвэрийг хангахад гол чиг баримжаа болохоор байна.

⁴ Тус тайлангийн 64 дэх тал. Мөн судлаач Б.Оюун-Эрдэнэ “Монгол гэр бүлийн харилцааны хэв шинж, өөрчлөлт” (2018) судалгааныхаа хүрээнд залуу гэр бүлийн өмнө тулгамдаж буй зарим асуудлыг тодруулах мөн ямар төрлийн дэмжлэг илүү хэрэгцээтэй байгааг тодорхойлсон байгаа юм. Үүнд: Төрөөс ямар төрлийн дэмжлэг авахыг илүүтэй хүсдэгийг тодруулахад залуу гэр бүлүүдийн 53.3% нь ажлын байраар хангах, орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх гэж хариулсан байна.

3.2."Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар уялдаа холбоог тогтоохыг зорьлоо.

1.Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн зорилт нь төсөлд тусгаснаар "Энэ хуулийн зорилт нь гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хангах, гэр бүлийг дэмжих үйл ажиллагаа, хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг, гэр бүлийн хөгжлийг дэмжих тогтолцоог тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад" оршиж байгаа бөгөөд хуулийн төслийн зохицуулалт нь дээрх зорилттой нийцэж байна.

2.Хуулийн төслийн "Хууль тогтоомж" гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;

Төслийн 2.1-д "Гэр бүлийг дэмжих хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ" гэж заажээ. Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Гэр бүлийн тухай хуулийн дараа орох гэр бүлийг дэмжих суурь харилцааг зохицуулж буй хууль тул бусад хууль тогтоомж нь дээрх 2 хуульд нийцсэн байхаар тусгасан нь зохистой байна. Уг заалтад нэр заасан хоёр хууль нь тухайн харилцаанд хамаарах хууль мөн байна.

3.Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгасан 11 нэр томъёоны тодорхойлолт нь Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.1.3.3-т шинээр бий болсон ойлголт буюу тухайн нэр томъёо нийтэд ойлгомжгүй бол нэр томъёоны тодорхойлолт хийхээр заасантай нийцэж байна.

4.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;

1. Хуулийн төслийн 8.1-д "Гэр бүлд дараах албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг татварын хууль тогтоомжоор шийдвэрлэнэ" гээд 8.1.1-д "3 ба түүнээс дээш хүүхэдтэй гэрлэгчдийн аль нэгний, эсхүл 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг албан татвараас чөлөөлөх", 8.1.2-т "4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүл орон сууцныхаа талбайн хэмжээг ихэсгэх

зорилгоор анх удаа орон сууцаа худалдан борлуулж олсны орлогод ногдуулж төлсөн албан татварыг буцаан олгох” 8.1.3-т “гэр хороололд оршин суугч гэр бүл эрүүл, аюулгүй, таатай амьдрах орчин нөхцөл бүрдүүлэх зорилгоор байгальд ээлтэй эко жорлон барихад зарцуулсан хөрөнгөтэй тэнцэх хэмжээний орлогод ногдох 3 сая төгрөг хүртэл татварын хөнгөлөлт эдлүүлэх” гэж тусгасан байна.

Дагаж мөрдөж буй Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд хуулийн төсөлд тусгасан дээрх гурван үндэслэлээр татвараас чөлөөлөх, татварыг буцаан олгох, татварын хөнгөлөлт эдлүүлэх асуудлыг зохицуулаагүй байна. Иймд уг асуудлыг заавал Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны үндсэн дээр шийдвэрлэхээр байна.

Нөгөө талаас Татварын ерөнхий хуулийн 10.2-т “Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулах бөгөөд хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх үйл ажиллагааны журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасан байх тул энэ Хуулийн төсөлд гэр бүлийг дэмжсэн татвараас чөлөөлөх, татварыг буцаан олгох, татварын хөнгөлөлт эдлүүлэх үндэслэлийг заахгүйгээр Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар шийдвэрлэхийг эргэн харах шаардлагатай.

2. Хуулийн төслийн 13.1-д “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4.1.1-д заасан Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдөр, 4.1.2-т заасан Цагаан сарын баярын өдөр долоо хоногийн амралтын өдөр тохиовол дараагийн ажлын өдөрт шилжүүлж, нийтээр амарна.” гэж тусгажээ.

Хүчингүй болсон Хөдөлмөрийн тухай хууль /1999 оны/-ийн 77.3-т “Нийтээр амрах баярын өдөр, долоо хоног бүрийн амралтын өдөр ойрхон тохиосон тохиолдолд долоо хоногийн ажил, амралтын өдрийг Засгийн газрын шийдвэрээр зохицуулж болно” гэж заасан байсан. Харин дагаж мөрдөж буй, 2021 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуульд ийм зохицуулалтыг тусгаагүй. Мөн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нийтээр амрах баярын долоо хоногийн амралтын өдөр тохиосон тохиолдолд ажил, амралтын өдрийг зохицуулах, шилжүүлэх заалт тусгагдаагүй байна. Иймд эдгээр хуулиас давж, Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулиар нийтээр амрах зарим баярын өдөр долоо хоногийн амралтын өдөр тохиосон тохиолдолд ажлын өдөрт шилжүүлж, нийтээр амрах харилцааг зохицуулж болох эсэхийг нягтлах шаардлагатай.

5.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;

Давхардсан зохицуулалт тусгаагаагүй байна

6.Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;

Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг төсөлд тодорхой тусгасан байна.

7.Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;

Орхигдуулаагүй байна.

8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;

Хуулийн төсөл энэ шаардлагыг хангасан байна.

9.Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;

Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1.4-д гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага “гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг батлах”, 24 дүгээр зүйлийн 24.1.6-д “гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага “гэр бүлийг дэмжих үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах”, 25 дугаар зүйлийн 25.1.2-т аймаг, дүүрэг гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага “гэр бүлийн хөгжлийг дэмжих үйлчилгээ үзүүлэхээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж ажиллах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, гэрээний биелэлтийг дүгнэх”-ээр заажээ.

Бодит байдал дээр гэр бүлийг дэмжих боловсрол, эрүүл мэнд, соёл, нийгэм, сэтгэл зүйн зэрэг үйлчилгээг энэ чиглэлийн мэргэжлийн төрийн бус байгууллага, түүний мэргэжитэн хувь хүнээр гүйцэтгүүлэх шаардлага гарах бөгөөд энэ төрлийн үйлчилгээ, үйл ажиллагааг төр, орон нутгийн зүгээс дангаараа гүйцэтгэх боломжгүй юм.

10.Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;

Хуулийн төслөөр төлбөр, хураамж тогтоож байгаа зүйл заалт байхгүй. Энэ шаардлагыг хангасан.

11.Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;

Хуулийн төслөөр аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг зохицуулаагүй байна.

12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;

Хуулийн төсөлд хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр

хамгаална” гэж тус тус заасантай хуулийн төсөл нийцэж байна.

13.Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;

Хуулийн төсөл нь энэ шаардлагыг хангасан байна.

14.Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;

Хуулийн төсөл нь энэ шаардлагыг хангасан байна.

15.Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;

Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгосон зохицуулалт ороогүй байна.

16.Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Хуулийн төслийн 36 дугаар зүйлд хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг заажээ.

3.3.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ хэсэгт Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн зарим шинэ зохицуулалт нь дагаж мөрдөж, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг авч үзэх болно. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг шалгаж тооцов.

Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт тусгасан “хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг”-ийн талаарх зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

Хуулийн 13.1-д “Хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэгийн дараах төрлүүдийг заасан байна:

- хүүхдийн мөнгөн дэмжлэг;
- жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг;
- хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг;
- ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг;
- олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн урамшуулал.

Хүүхдийн мөнгөн дэмжлэгийн тухайд Нийгмийн халамжийн тухай хуульд “хүүхдийн мөнгөн тэтгэмж” нэрээр туссан бөгөөд Засгийн газрын 2023 оны 236 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам”-аар⁵ зохицуулагдаж байна.

Жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг, хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг, ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг зэрэг нь “Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль”-аар, олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн урамшуулал нь “Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль”-аар тус тус зохицуулагдаж байна.

Дээрхээс үзвэл, Хуулийн төсөлд тусгагдсан “хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг”-үүд нь одоо өөр өөр хуульд тусгагдаж олгогдож байгаа мөнгөн тэтгэмжүүд байх бөгөөд эдгээрийг нэгтгэж Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгасан нь байгаа эдгээр зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой байна.

Дээрх мөнгөн дэмжлэгийн хүрээнд зарчмын шинжтэй өөрчлөлтүүд гэвэл “хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг”-ийг 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцэгт олгож байгааг 2023 батлагдсан “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль”-ийн 4.2-т “Сургуулийн өмнөх боловсролд хоёроос таван насны хүүхэд хамрагдана” гэж заасантай уялдуулж 0-2 насны хүүхдээ асарч байгаа эх, эсхүл эцэгт олгохоор өөрчилжээ. Ингэснээр хүүхэд асарсны мөнгөн дэмжлэгийг хэмжээг нэмэгдүүлэх боломж бүрдэхээр байна. Мөн Хуулийн 16.1-д жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэгийг “өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийн амьжиргааны түвшингээр эрэмбэлсэн босго шугамаас доогуур амьжиргаатай эх”-д олгох зарчмын өөрчлөлттэйгөөр тусгасан байна.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн урамшууллын тухайд Хуулийн төслийн 18.1-д “олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн урамшууллыг бага хүүхэд нь 18 хүрсэн бол” уг мөнгөн урамшууллыг зогсоохоор зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгажээ.

Хуулийн төслийн 19.1-д мөнгөн дэмжлэг олгохтой холбоотой үйл ажиллагааг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн зохион байгуулна” гэж хуулийг хэрэгжүүлэх субъектийг тодорхой зааж өгсөн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны

⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759738288411>

хөгжлийн бодлого”, 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” зэрэг бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан байх бөгөөд хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлага, зорилтыг зарчмын хувьд хангасан байна гэж дүгнэв.

Зорилгод хүрэх байдал. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хуулийн төслөөр тавьсан зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн зохицуулалтыг харьцуулан судалсан бөгөөд хуулийн төслийн зохицуулалт нь ерөнхий байдлаар зарчмын хувьд зорилгодоо хүрэх байдлыг хангасан байна. Харин Хуулийн төслийн 7 дугаар зүйлд заасан орон сууцны дэмжлэгийн зохицуулалт үндсэн агуулга, зарчмын хувьд зорилгодоо нийцсэн ч уг зохицуулалтыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас боловсруулж байгаа Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийн зохицуулалттай уялдуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Харилцан уялдаа. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгагдсан асуултанд хариулах замаар хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэг. Хуулийн төслийн зарим зохицуулалтыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагатай байна. Тодруулбал, Хуулийн төслийн 8 дугаар зүйлийг Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуультай уялдуулах шаардлагатай, энэ хүрээнд дагалдах хуулийн төслийн хүрээнд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. Хуулийн төслийн 13.1 дэх хэсгийг Хөдөлмөрийн тухай хуультай нийцүүлэх нь зүйтэй.

Практикт хэрэгжих боломж. Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт тусгасан зохицуулалт хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэгийн төрлүүд нь практикт хэрэгжих боломжтой байна.

---ooOOoo---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он;
2. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он;
3. Гэр бүлийн тухай хууль, 1999 он;
4. Үндэсний баялгийн сангий тухай хууль, 2024 он;
5. Татварын ерөнхий хууль, 2019 он;
6. Хувь хүнийн орлогын албан татварын тухай хууль, 2019 он;
7. Хөдөлмөрийн тухай хууль, 2021 он;
8. Нийгмийн халамжийн тухай хууль, 2012 он;
9. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль, 2010 он;
10. Эх, эцэг, олон хүүхэдтэй өр толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль, 2017 он
11. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал", 3 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал";
12. Засгийн газрын 2023 оны 236 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журам";
13. Засгийн газрын 2019 оны 128 тогтоолоор батлагдсан "Түрээсийн орон сууцыг өмчлүүлэх журам";
14. Засгийн газрын 2024 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журам";
15. Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан "Зорилтод бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам";
16. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийн зорилтод бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам";
17. Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтод бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам";
18. НҮБ-ын Хүүхдийн сан "Гэр бүлд ээлтэй бодлого: Бизнес эрхлэгчдэд зориулсан гарлын авлага", 2020 он;
19. Б.Оюу-Эрдэнэ. "Монгол гэр бүлийн бүтэц хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал", 2012 он;
20. Б.Бүжинлхам. "Залуу гэр бүлд тулгамдаж буй асуудал, хэрэгцээ, үйлчилгээ /Дундговь аймгийн жишээ дээр/, судалгааны тайлан, 2022 он;
21. "Монгол гэр бүлийн асуудал, хэрэгцээ үйлчилгээний хувилбар" судалгааны тайлан, 2018 он.

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцов.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг дараах төрөл тус бүрээр тооцлоо:

- Улсын төсөвт үүсэх зардал;
- Төрийн байгууллагад үүсэх зардал;
- Хуулийн этгээдэд үүсэх зардал;
- Иргэнд үүсэх зардал.

А/Улсын төсөвт үүсэх зардал:

1.Мөнгөн дэмжлэгийн хөрөнгийн тооцоо

Хүүхэд, эх, эцэгт нийгмийн халамжийн хууль тогтоомжийн хүрээнд дараах тэтгэмжүүд олгогдож байна:

Хүснэгт 1. Хүүхэд, эх, эцэгт олгогдож буй тэтгэмжүүд (2022-2024 он)

Үйлчилгээний төрөл	2022 он		2023 он		2024 он		2025 оны 12 сар	
	Хүний тоо	Зардлын дүн	Хүний тоо	Зардлын дүн	Хүний тоо	Зардлын дүн	Хүний тоо	Зардлын дүн
		(мян. төг)		(мян. төг)		(мян. төг)		(мян. төг)
Эхчүүд, хүүхдүүдэд олгох тэтгэмж	521,563	127,867,863.1	1,817,302	1,641,124,257.8	1,840,713	1,655,670,255.8	1,853,735	1,715,227,048.6
Жирэмсэн эхийн тэтгэмж /жирэмсний 5 сартайгаас эхлэн олгох/	77,575	10,792,489.7	73,811	10,139,645.1	67,205	8,974,842.6	61,370	8,125,092.3
0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж	196,559	84,513,173.4	184,754	77,892,203.9	172,109	73,199,682.7	158,687	67,047,088.8
Хоёр ба түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэн	734	1,472,000.0	732	1,464,000.0	676	1,352,000.0	646	1,292,000.0
Гурав болон түүнээс дээш ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэн	9	81,000.0	5	45,000.0	6	54,000.0	Зардлыг үндэслэн үнэмлэхүйгээр олгох	
Эхийн алдар одонтой эхчүүдэд жилд 1 удаа олгох мөнгөн тусламж	246,686	31,009,200.0	252,678	31,486,172.28	259,746	32,063,400.0	270,260	66,023,370.0
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	Ирээдүйн өв сангаас		1,305,322	1,520,097,236.5	1,340,971	1,540,026,330.5	1,53,720	1,549,749,211.0

Одоогийн нийгмийн халамжийн хууль тогтоомжийн хүрээнд хүүхэд, эх, эцэгт олгогддог тэтгэмжүүдийг хүн амын өсөлтийг дэмжих бодлогын нэгэн хэсэг гэж үзэж, халамжийн хөтөлбөрүүдээс салгаж, Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд тусгасан:

- 1.хүүхдийн мөнгөн дэмжлэг;
- 2.жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг;
- 3.хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг;

4. ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг;
5. олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн тусламж.

1. Хүүхдийн мөнгөн тэтгэмж:

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн одоогийн зохицуулалтыг өөрчлөөгүй тул хөрөнгө нэмж шаардагдахгүй. Иймээс зардлын тооцоонд оруулах шаардлагагүй гэж үзлээ.

2. Жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг:

Хуулийн төсөлд Нийгмийн даатгалын сангаас жирэмсний тэтгэмж авах эрх үүссэн эхчүүдийг “Жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг”-т хамруулахгүйгээр тусгасан. Одоо мөрдөж байгаа Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу жирэмсэн эхэд жирэмсний 5 сартайгаас төрөх хүртэл хугацаанд тэтгэмжийг олгож байгаа бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар 61.4 мянган эх хамрагдаж 8.1 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Харин 2024 онд нийгмийн даатгалын сангаас өссөн дүнгээр /1 иргэн төрөхийн өмнө болон төрсний дараа нийт 2 удаа/ 55.3 мянган эх жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авсан байна.

Хуулийн төсөлд нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсэхгүй эхчүүдэд нийгмийн халамжийн сангаас жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэгийг олговол одоогийн зардал 45 орчим хувиар буурна.

Жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг	Зардлын тооцоо	
	Хүний тоо	Мөнгөн дүн /тэрбум.төг/
НИЙТ	61.4	
Нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эх	27.7	
Шинэ хуулиар нийгмийн халамжийн сангаас жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэгт хамрагдах эх	33.7	4.5

3. Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг:

Одоо мөрдөгдөж байгаа Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн дагуу 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа Хөдөлмөрийн тухай хуулийн 139.1-д заасан хүүхэд асрах чөлөөтэй болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.3-т заасан ажилгүй эх, эцэг, асран хамгаалагч мөнгөн дэмжлэгийг 36 хүртэлх сарын хугацаанд сар бүр авахаар заасан.

Хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгасан:

“16.2. Энэ хуулийн 16.1-д заасан мөнгөн дэмжлэгт хамрагдах иргэн энэ хуулийн 13.3-т заасан хэмжээг баримтлан дараах хугацааны төрлөөс аль нэгийг сонгон хүсэлт гаргана:

16.2.1. 36 хүртэлх сарын хугацаанд сар бүр;

16.2.2. 24 сарын хугацаанд сар бүр;”.

Одоогийн хуулийн хүрээнд 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид эх, эцэг сард 50,000 төгрөгийг нийт 36 сарын хугацаанд авахад нэг хүн нийтдээ 1,800,000 төг авч байгаа гэсэн үг юм.

Хувилбарууд	хүний тоо /2025.12 сар/	Сард олгох тэтгэмжийн хэмжээ	Эхний жилд жилд шаардагдах төсөв, тэрбум.төг	Эхний жилд урьдчилан олгох магадлал тэрбум.төг
Хувилбар 1: хүүхдээ төрүүлсэн болон үрчилж авсны дараа 36 хүртэлх сарын хугацаанд сар бүр /нийт хүний 50%/	79344	50000	33.6	-
Хувилбар 2: хүүхдээ төрүүлсэн болон үрчилж авсны дараа 24 сарын хугацаанд сар бүр /нийт хүний 50%/	79344	75000	50.3	16.8
НИЙТ ДҮН	158688		83.9	16.8

Тэтгэмжид 2025 оны 12 сарын байдлаар 158687 иргэн хамрагдаж 67.1 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангаас зарцуулсан.

Хуулийн төслөөр нэг хүнд 36 сарын хугацаанд ногдох 1,800,000 төгрөгийн хэмжээг бууруулахгүйгээр, тэтгэмжийг сонголтоор олгох зохицуулалтыг бий болгосон. Тэтгэмжийг 36 сарын хугацаанд сар бүр 50.0 мянган төгрөгөөр тооцон олгох, 24 сарын хугацаанд одоо байгаа дүнг 50 хувиар нэмэгдүүлэн сар бүр 75.0 мянган төгрөгөөр тооцон олгох гэсэн 2 хувилбар гаргаж, иргэн сонголтоо хийхээр тооцоолсон. Хувилбаруудын иргэнд олгох нийт мөнгөн дүнгийн хэмжээнд өөрчлөлт орохгүй.

4.Ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг: Одоогийн зохицуулалтыг өөрчлөөгүй тул зардлын тооцоонд оруулах шаардлагагүй гэж үзлээ.

5.Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн тусламж:

Нийгмийн халамжийн олон хөтөлбөрүүдээс амьжиргааны түвшин болон нийтлэг хэлбэрээр нас харгалзахгүй олгодог хөтөлбөрүүдийн нэг нь эхийн алдар одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламж бөгөөд одон авсан үеэс эхлэн насан туршид нь олгодог.

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн дэмжлэгт хамрагдагчдын 2024-2025 оны мэдээ

Эхийн алдар одонгийн мөнгөн тусламж	2024 оны гүйцэтгэл		2025 оны 12 сар	
	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/
НИЙТ	259,746	32,063,400.0	270,260	66,023,370.0
Эхийн алдар I зэргийн одонгийн мөнгөн тусламж	61,614	12,240,200.0	61,631	24,286,570.0
Эхийн алдар II зэргийн одонгийн мөнгөн тусламж	198,132	19,823,200.0	208,629	41,736,800.0

2025 онд 270.2 мянган эх хамрагдаж, 66.0 тэрбум төгрөгийг зарцуулсан.

2024 онд нийт 11.3 мянган эх шинээр одон авч байсан бол Олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуульд 2024 онд нэмэлт, өөрчлөлт орж, одонгийн хүүхдийн тоонд байгалийн аюулт үзэгдэл, осол, өвчин, гэмт хэргийн улмаас нас барсан 1 ба түүнээс дээш настай хүүхэд хамаарахаар тусгасантай холбоотойгоор 2025 онд **14.5 мянган эх шинээр** одон авсан.

Хуулийн төсөлд шинээр Эхийн алдар одон авсан эхэд олгох мөнгөн дэмжлэгийг бага хүүхдийг 18 нас хүртэлх хугацаанд олгохоор тусгасан тул эхний жилүүдэд зардалд ямар нэгэн өөрчлөлт орохгүй. Харин хууль хэрэгжиж эхэлснээс хойш шинээр Эхийн алдар одон авсан эхийн бага хүүхэд 18 нас хүрэхэд мөнгөн дэмжлэг зогсох тул 18 жилийн дараагаас эхлэн мөнгөн дэмжлэгийн зардал аажмаар буурна.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр улсын төсөвт үүсэх зардлын нэгдсэн тооцоо /сая төг/

Төрөл /Одоогийн/	Хүний тоо /2025.12 сар/	Гүйцэтгэл 2025.12 сар/ тэрбум.төг	Төрөл /Хуулийн төсөлд/	Нэг хүнд олгох хэмжээ, давтамж	Нийт шаардагдах зардал тэрбум.төг	Нэмж шаардагдах хөрөнгө
Жирэмсэн эхийн тэтгэмж	61,370	8.1	Жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг	Хэвээр /40,000₮ 5 сард/	4.5	-(3.6)
Ихэр хүүхдийн тэтгэмж	649	1.3	Ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг	Хэвээр. 2 ихэр 2000,000₮ 3 ихэр 3000,000₮	1.3	-
Эхийн алдар одон	270,260	66.0	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн дэмжлэг	Хэвээр. I одон 400,000₮ II одон 200,000₮	66.0	-
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	1,353,720	1,549.8	Хүүхдийн мөнгөн дэмжлэг	Хэвээр /сард 10,000₮/	1,549.8	-
Хүүхэд асарсны тэтгэмж	158,687	67.1	Хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг	Иргэнд 2 төрлийн сонголттой боловч иргэнд олгох нийт тэтгэмжийн хэмжээ хэвээр	67.0	0
Нийт зардал	1,853,735	1,692.3			1,688.6	-(3.6)

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр жирэмсэн эхийн тэтгэмжээс 3.6 тэрбум төгрөг хэмнэгдэх бөгөөд нэмэлт зардал шаардахгүй, төсөвт ачаалал үүсгэхгүй юм.

Б/Төрийн байгууллагад үүсэх зардал

1. Төрийн байгууллагад шинээр үүссэн үүрэгтэй холбоотой гарах зардал:

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд заасан хүүхэд, эх, эцэгт олгох дэмжлэгийг хэрэгжүүлэхэд одоогийн тогтолцоо - нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагын бүтцээр хэрэгжүүлэх бүрэн боломжтой тул хуулийн төслөөр төрийн байгууллагад шинээр чиг үүрэг өгөх шаардлагагүй учраас төрийн байгууллагад зардал гарахгүй гэж тооцсон.

Түүнчлэн гэр бүлийг дэмжих үйл ажиллагаа, үйлчилгээг төлөвлөн зохион байгуулах, хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээсэн хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу ажиллах эрх зүй нь бүрдсэн тул нэмэлт зардал шаардагдахгүй.

Хуулийн төсөлд гэр бүлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үйлчилгээнүүд /гэр бүлийн боловсролыг дэмжих; эрүүл мэндийг дэмжих; нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх; хүн амын бүлэгт чиглэсэн хөтөлбөрт үйлчилгээ үзүүлэх; гэр бүлийн өдрийг тэмдэглэх/-ийг хуулийн төсөлд гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлүүдийг нэг хуульд оруулж тусгасан болохоос бус холбогдох төрийн байгууллагууд одоо ч хэрэгжүүлж буй чиг үүрэг тул нэмэлт зардал шаардагдахгүй гэж үзсэн болно. Гэр бүлийг дэмжих үйл ажиллагаа, үйлчилгээний санхүүжилт нь аль эх үүсвэрээс гарахыг тодорхой болгосон.

Төрийн байгууллагад үүсэх зардал байхгүй, үйл ажиллагааны зардлаар шийдвэрлэх боломжтой.

В/ Хуулийн этгээдэд үүсэх зардал

Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төслийн 14.4-т “Гэр бүлийн өдөр аж ахуйн нэгж, байгууллага сайн дурын үндсэн дээр гэр бүлд зориулан бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ үнэ, тарифт хөнгөлөлт, тусламж үзүүлж болно.” гэж хуулийн этгээдийн хүлээх үүргийг тусгасан.

Гэвч тус заалт нь хуулийн этгээдийн нийгмийн хариуцлагыг сайжруулах зорилготой бөгөөд “сайн дурын үндсэн дээр” хэрэгжүүлэх тул үүсэх зардлыг тооцох боломжгүй юм.

Г/ Иргэнд үүсэх зардал

Энэхүү хуулийн төсөл нь иргэн, гэр бүлийг бүх талаар дэмжиж байгаа тул иргэнд ямар нэгэн санхүүгийн нэмэлт ачаалал үүсгэхгүй, иргэнд үүсэх зардал байхгүй.

ДҮГНЭЛТ

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг батлуулан хэрэгжүүлснээр нэмэлт зардал улс төсөв, төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд үүсэхгүй болно.

	Зардлын төрөл	Зардлын хэмжээ /тэрбум.төг/
1	Улсын төсөвт үүсэх зардал	0
2	Төрийн байгууллагад үүсэх зардал	0
3	Хуулийн этгээдэд үүсэх зардал	0
4	Иргэнд үүсэх зардал	0
	НИЙТ	0

---oOo---



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**

“ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ” АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН ТАЙЛАН

**Улаанбаатар хот
2026 он**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 2.3-т “Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ” гэж, 2.3.1-д “Хүн амын төрөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2.3.1-д “Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.2-д “Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, “Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.”, 2.1.1.3-т “Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ.”, 2.1.1.4-д “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүх аймаг, дүүрэгт төр, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус тус заасан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20 өдрийн 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 102-т “Гэр бүлийн дэмжих тухай (Анхдагч хууль) гэж туссан зэрэг нь Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах үндэслэл болсон.

Эдгээр бодлогын зорилттой уялдуулан ГБХНХСайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн А/37 тоот тушаалаар Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул ахлан гэр бүл судлаач, эрдэмтэн, багш нарын төлөөллийг оролцуулан, хуулийн төслийг боловсруулах Ажлын дэд хэсгийг яамны ахлах шинжээчдийн бүрэлдэхүүнтэй тус тус байгуулсан. Уг ажлын хэсэг Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг эцэслэн боловсруулж, дараах байдлаар хэлэлцүүлээ. Үүнд:

- ✓ 2025.02.24-ний өдөр Хуулийн төслийн эхний хувилбарыг ажлын хэсгийн гишүүдэд (25 хүн) танилцуулан хэлэлцүүлэв.
- ✓ 2025.03.07-ны өдөр “Гэр бүл хамгаалал-шийдэл” хэлэлцүүлгийн үеэр Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг УИХ-ын гишүүд, төр ТББ, иргэдийн төлөөллөөр (250) хэлэлцүүлэв.
- ✓ 2025.03.19-ний өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын анхан шатны нэгжийн удирдах албан тушаалтан, мэргэжилтнүүдийг (25 хүн) оролцуулж хуулийн төслийг хэлэлцүүлэв.
- ✓ 2025.03.20-ны өдөр олон улсын болон төрийн бус байгууллагын төлөөллөөр (25 хүн) хэлэлцүүлэв.
- ✓ 2025.03.25-ны өдөр ХГБХХЕГ болон эрдэмтэн, судлаач нарын төлөөллийг (7 хүн) оролцуулж хуулийн төслийг хэлэлцүүлэв.
- ✓ 2025.05.20-ны өдөр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг бүх


яамдын төлөөлөл, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан, Эрүүл мэндийн даатгалын газар, Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн мэргэжилтэн албан хаагчдын төлөөллийг (35 хүн) оролцуулан хэлэлцүүлэв.

- ✓ 2025.06.03-ны өдөр ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн холбоодын төлөөллийг (30 хүн) оролцуулан хэлэлцүүлэв.
- ✓ 2026.03.26-ны өдөр олон нийтэд нээлттэй хэлэлцүүлгийг хийлээ.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг эрх ашиг нь хөндөгдөх бүх оролцогч талуудын оролцоог ханган нийт 20-оод удаа 5-200 хүн хүртэл оролцсон том, жижиг хэлэлцүүлгүүдийг 2025 оны 02 сараас 2026 оны 03 сар хүртэлх хугацаанд зохион байгуулсан.

/Холбогдох зургийг хавсаргав./

1. Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг 2025.02.24



2. “Гэр бүл хамгаалал-шийдэл” хэлэлцүүлгийн үеэр Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг УИХ-ын гишүүд, төр ТББ, иргэдийн төлөөлөл



2025.03.07



3. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын анхан шатны нэгжийн удирдах албан тушаалтан, мэргэжилтнүүд 2025.03.19



2025 оны 03 дугаар сарын 19-ны өдөр Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтнуудад зориулан танилцуулах хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Хэлэлцүүлэг ГБХНХЯ-ны 10 давхарын хурлын танхимд болсон бөгөөд хэлэлцүүлэгт салбарын дараах байгууллагын төлөөлөл оролцлоо:

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөлөл
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
- Нийгмийн даатгалын газар
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
- Нийслэлийн дүүргүүдийн ХГБХХГ
- Өнөр бүл төв

Уг хуулийн хэрэгжилтийг хангах гол төрийн байгууллагын болон мэргэжлийн хүмүүс нь гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын ажилтнууд учраас энэхүү хэлэлцүүлгийг зохион байгуулж, төсөлд тэдний саналыг авах зорилготой хэлэлцүүлэг байв.


Гэр бүлийн тухай хуулимйн төслийг ГБХНХЯ-ны Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтсийн дарга М.Цогтбаатар танилцууллаа.

Гэр бүлийг хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд дараах саналуудыг өгсөн болно:

- нэгэнт халамжийн хуулийн дагуу зохицуулагдаж буй асуудлуудыг уг хуульд нь байлгах
- нийгмийн үйлчилгээг сайжруулах
- гэр бүлийг дэмжих, урамшуулах
- иргэдийг орлоготой болгоход анхаарах, хөдөлмөр эрхлэлтээр хангах,
- татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх
- гэр бүлийн орлого, хөдөлмөр эрхлэлийг дэмжих, өрхийн үйлдвэрлэл, бизнесийг дэмжих
- Хүн амын бүлэгт чиглүүлж, хөтөлбөрт үйлчилгээ хэрэгжүүлэх
- гэр бүлд гэр бүлийн хэв шинжээр ямар үйлчилгээ үзүүлэхийг тодорхой болгох
- Бэлэн мөнгөний бус үйлчилгээг нэмэгдүүлж, зорилтот өрх, иргэнийг хөгжүүлэх, чадавхжуулах, зан хандлагыг өөрчлөх, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, үйлчилгээг нэвтрүүлэх,
- гэр бүлд үзүүлэх ямар үйлчилгээг хэн хэрхэн үзүүлэх, санхүүжилтийг хаанаас гаргахыг тодорхой заах
- гэр бүлд үзүүлэх үйлчилгээг Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга шиг тодорхой тусгамаар байна.

Энэхүү хуулийн төсөл нь гэр бүлийн хуулийн эрх зүйг харилцааг зохицуулдаг Гэр бүлийн тухай хуулиас өөр хууль боловч иргэд гэр бүл цуцлалт, гэрлэлтийн гэрээ, тэжээн тэтгэх харилцааг боловсронгуй болгох талаар нилээд санал гаргаж байлаа.

4. Олон улсын болон төрийн бус байгууллагын төлөөлөл 2025.03.20



2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Гэр бүлийг хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг Эрдэмтэн судлаач, ТББ, Олон улсын байгууллагын болон төрийн бус байгууллагын төлөөллөөр хэлэлцүүлэх хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Хэлэлцүүлэгт байгууллагын төлөөлөл оролцлоо:

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төлөөлөл
- НҮБ-ын Хүүхдийн сан
- НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр
- НҮБ-ийн хүн амын сан
- Дэлхийн зөн
- Японы хүүхдийг ивээх сан
- one sky
- ШУТИС
- ХТЭТ
- ХЭҮТ
- Нуг тат сэтгэл зүйн сургалтын төв
- Монголын урлагийн сэтгэл заслын холбоо зэрэг олон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцлоо.

Гэр бүлийн тухай хуулийн төслийг ГБХНХЯ-ны Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтсийн дарга М.Цогтбаатар танилцууллаа.

Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл нь гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, ажил, амьдралын тэнцвэрийг хангах, гэр бүлийг дэмжих үйл ажиллагаа, хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг, гэр бүлийн хөгжлийг дэмжих тогтолцоог тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах юм.

Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл нь:

- Гэр бүлд ээлтэй орчныг үндэсний хэмжээнд, орон нутаг, аж ахуйн нэгж байгууллагууд бүрдүүлэх,
- Ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангаж гэр бүлийг дэмжих,
- Гэр бүлийн хөгжлийг цогц байдлаар дэмжиж гэр бүлд болон гэр бүлийн гишүүдэд боловсролын, эрүүл мэндийн, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх
- Хүүхэд, эх, эцэгт мөнгөн дэмжлэг олгох
- Гэр бүлийг хөгжлийг дэмжих чиглэлийг тодорхойлж, тогтолцоог бий болгох зэрэг асуудлыг тусгасан.

Олон улсын байгуулланы төлөөллийн ихэнх нь ийнхүү хуулийн төслөө боловсруулж байх явцад танилцуулж байгаад талархал илэрхийлээд төсөлд дараа саналаа албан ёсоор өгөхөө илэрхийлж, хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлэв.

Төрийн бус байгууллагын төлөөллийн тухайд Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй нарийвчлан танилцах боломжоор хангах, боловсруулах явцад одоогийн байдлаар дараах саналыг анхаарахыг хүсэв:

- төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх
- төрийн бус байгууллагын чадавхжуулахад анхаарах
- үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын магадлан итгэмжлэл хийх
- гэр бүлийг дэмжих хууль, бодлого, хөтөлбөр аль нь байхыг анхаарах
- иргэд, гэр бүлийн аж амьдралыг дээшлүүлэхэд анхаарах
- гэр бүлийн орон сууцны хангамжийг анхаарах
- хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, ахмад настантай гэр бүлийг хэрхэн дэмжих
- залуу гэр бүл, өрх толгойлсон гэр бүлийг дэмжих
- ТББ-уудыг дэмжих, хамтран ажиллах

хуулийн төслийг хэрэгжүүлэх механизмын тодорхой болгох зэрэг болно.

5.ХГБХХЕГ болон эрдэмтэн, судлаач нарын төлөөлөл 2025.03.25



6.Бүх яамдын төлөөлөл, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан, Эрүүл мэндийн даатгалын газар, Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн мэргэжилтэн албан хаагчдын төлөөлөл 2025.05.20

2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл, Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг яамд, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан, Эрүүл мэндийн даатгалын газар, Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүдэд танилцууллаа.

Хэлэлцүүлэг ГБХНХЯ-ны 10 давхарын хурлын танхимд боллоо.

Энэхүү хэлэлцүүлэг нь дараах аач холбогдолтой байлаа.

1. Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөлд Нийгмийн халамжийн хуулийн дагуу зохицуулдаг олон асуудал тусч байгаатай уялдуулан олон төлөөллөөр хэлэлцүүлэх
2. Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй уялдсан Халамжийн тухай хуулийн төслийг хэлэлцэж, 2 хуулийн уялдаа холбоо холбоо, давхцал, хийдлийг хэлэлцэх
3. Түүнчлэн эдгээр яамдад хуулийн төслийг хүргэсэн үед танилцуулж санал авах ач холбогдолтой.

Дараах яамдын төлөөллийг урьж оролцууллаа. Ихэвчлэн ирж оролцсон бөгөөд 5 хүн цахимаар оролцсон болно. /Оролцогчдын жагсаалт хавсаргав/.

- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

- Сангийн яам
- Сангийн яамны зөвлөх баг
- Эдийн засаг, хөгжлийн яам
- Байгаль орчин, уур амьсгал өөрчлөлтийн яам
- Батлан хамгаалах яам
- Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яам
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- Эрүүл мэндийн яам
- Азийн хөгжлийн банк
- НҮБ-ийн хүүхдийн сан
- Эрүүл мэндийн даатгалын газар
- Сэтгэцийн эрүүл мэндийн төв
- Бусад

Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл нь гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, ажил, амьдралын тэнцвэрийг хангах, гэр бүлийг дэмжих үйл ажиллагаа, хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг, гэр бүлийн хөгжлийг дэмжих тогтолцоог тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилготой.

Халамжийг бэлэн мөнгөөр тараах биш нийгмийн үйлчилгээг нь сайжруулах зорилготой нийгмийн хагамжийн хуулийн төслийг боловсруулж байна.

Гэр бүлийн тухай хуулимйн төслийг ГБХНХЯ-ны Гэр бүл, хүн амын хөгжлийн хэлтсийн дарга М.Цогтбаатар танилцууллаа.

Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөлд дараах саналыг өглөө.

Хуулийг төслийг танилцуулсны дараа оролцогчдын зүгээс хуулийн төсөлтэй танилцаад дараах асуудлуудыг онцлон анхаарч, төсөлд тусгахыг санал болголоо. Үүнд:


- гэр бүлийн боловсролыг их дээд, сургуулийн хөтөлбөрт оруулж хэрэгжүүлэх,
- гэр бүлийг дэмжих, урамшуулах
- иргэдийг орлоготой болгоход анхаарах, хөдөлмөр эрхлэлтээр хангах,
- татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх
- гэр бүлийн бизнесийг дэмжих зэрэг саналуудыг гаргалаа.

Энэхүү хуулийн төсөл нь гэр бүлийн хуулийн эрх зүйг харилцааг зохицуулдаг Гэр бүлийн тухай хуулиас өөр хууль боловч иргэд гэр бүл цуцлалт, гэрлэлтийн гэрээ, тэжээн тэтгэх харилцааг боловсронгуй болгох талаар нилээд санал гаргаж байлаа.



7. Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийг олон нийтэд нээлттэй хэлэлцүүлээ. 2026.03.26

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хуулийн төслийг 2025 оны 11 дүгээр сард ХЗДХЯ-наас УИХ-д өргөн мэдүүлж, УИХ-ын чуулганаар хэлэлцэхийг дэмжсэн. ГБХНХЯ-наас Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төсөл боловсруулснаа энэ өдөр олон нийтэд нээлттэй хэлэлцүүллээ. Энэ удаагийн хэлэлцүүлэгт 200 орчим хүн оролцсоны дунд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл, эрдэмтэн, хуульч, судлаачид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл, оюутан, залуучууд, ахмад настан зэрэг хүн амын төлөөлөл оролцож, санал хүсэлтээ илэрхийлсэн.





Олон нийтийн хэлэлцүүлгээс иргэд, ТББ-ын төлөөлөл дараах асуудлыг хуульд тусгуулах саналтай байгаагаа илэрхийлсэн. Үүнд:

- Гэр бүлийг дэмжсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг тусгах;
- Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүлд очих үйлчилгээг сайжруулах, нэмэгдүүлэх;
- Зорилтот, орлого багатай гэр бүлд бодит дэмжлэг үзүүлэх зэрэг байлаа.

8. Олон нийтээс санал авах зорилгоор тус яамны цахим хуудсанд 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл, дагалдах хуулийн төслийг байршуулсан.



Санал авч байна 2025-04-04

ГЭР БҮЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.1.2-д "Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, "Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.", 2.1.1.3-т "Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ.", 2.1.1.4-д "Гэр бүлийн

Олон нийтээр хэлэлцүүлэг хийж, холбогдох байгууллагуудын саналыг тусгасны дараа яамны цахим хуудсанд төслийг шинэчлэн дахин байрлуулж санал авсан.



Түүнчлэн цахимаар, утсаар, биечлэн ирүүлсэн саналуудыг судлан үзэж хуулийн төсөлд тусгалаа.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЖАГСААЛТ, ХУГАЦААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Гэр бүлийн хөгжлийг дэмжих хуулийн төсөлд дараах захиргааны хэм хэмжээний актыг батлахаар тусгасан. Үүнд:

1. “Эхийн алдар” одонгоор шагнах журам

Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтын талаарх мэдээлэл:

Гэр бүлийн хөгжлийг дэмжих хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 18.4.1, 18.4.2-т заасан одонгоор шагнах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална” гэж тусгасан.

Хуулийн төсөлд тусгасан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1} дэх хэсгийн хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, тухайн хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээнд нийцсэн байх, захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх, зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх, захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд заасан чиг үүрэгт хамааралтай байх, хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх зэрэг шаардлагыг хангасан болно.

2. Хуулийн төсөлд тусгасан “Эхийн алдар” одонгоор шагнах журам нь хуулийн төслийг дагаж хүчингүй болгохоор боловсруулсан Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд одоо мөрдөгдөж байгаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Журам батлах тухай 2025 оны 13 дугаар зарлигын хавсралтаар баталсан “Эхийн алдар” одонгоор шагнах журамыг өөрчлөн батлах юм.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлсэн өдрөөс энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэгт заасан журмыг боловсруулан батална.

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНД ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭД ОРОЛЦОХ
АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛТНУУДЫН НЭРС

2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр

№	НЭР	АЛБАН ТУШААЛ	ХОЛБОО БАРИХ УТАС
1	А.Даваажаргал	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга	99113482
2	Ц.Мөнхзул	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга	88110936
3	М.Цогтбаатар	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын Хүн ам, гэр бүлийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч	99011359
4	Б.Номин-Эрдэнэ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын Гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	99816339

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЖАГСААЛТ, ХУГАЦААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд дараах захиргааны хэм хэмжээний актыг батлахаар тусгасан. Үүнд:

1. Мөнгөн дэмжлэгийн хэмжээ, олгох журам

Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтын талаарх мэдээлэл:

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 13.1-д заасан мөнгөн дэмжлэгийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.” гэж тусгасан. Энэ нь хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан Хүүхэд, эх, эцэгт олгох мөнгөн дэмжлэг бөгөөд дараах төрөлтэй байна:

- 13.1.1.хүүхдийн мөнгөн дэмжлэг;
- 13.1.2.жирэмсэн эхийн мөнгөн дэмжлэг;
- 13.1.3.хүүхэд асарсны мөнгөн дэмжлэг;
- 13.1.4.ихэр хүүхдийн мөнгөн дэмжлэг;
- 13.1.5.олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд олгох мөнгөн дэмжлэг.

Хуулийн төсөлд тусгасан захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1} дэх хэсгийн хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, тухайн хуулийн зорилго, зорилт, үйлчлэх хүрээнд нийцсэн байх, захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх, зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх, захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд заасан чиг үүрэгт хамааралтай байх, хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх зэрэг шаардлагыг хангасан болно.

2. Хуулийн төсөлд тусгасан Мөнгөн дэмжлэгийн хэмжээ, олгох журам нь хуулийн төслийг дагаж хүчингүй болгохоор боловсруулсан Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн өнөөгийн зохицуулалт болон Засгийн газрын Журам шинэчлэн батлах тухай 2023 оны 236 дугаар тогтоолыг нэгтгэн, өөрчлөн батлахад чиглэгдсэн.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлсэн өдрөөс энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт заасан журмыг боловсруулан батална.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулсан тухай

Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төслийг бусад бичиг баримтын хамт 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн www.legalinfo.mn цахим хуудсанд https://legalinfo.mn/mn/discussiondetail/17437264962202?type=LIS_LAW&page=1 холбоостойгоор байршуулсан.

ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

Харилцагч байгууллага
Хууль зүйн үндэсний хүрээлэн

Нийтэлсэн огноо
2026-06-04 20:12:54

Төслийн төлөв
Идэвхтэй

Нийт ирүүлсэн санал
0

Дагасан тоо
0

Үзсэн тоо
68

СОНИРХЛЫН БҮЛЭГ

- ИРГЭЭНИЙ БОЛОН АРИЛЖААНЫ ХАРИЛЦАА
- УЛСЫН АРБУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

САНАЛ АВЧ ДУУСАХ ХҮТАЦАА: 2026-08-03

ТАНИЛЦУУЛГА:

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хот

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1 Энэ хуулийн зорилт нь гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, ажил, амьдралын тэнцвэрийг хангах, гэр бүлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх хуульд эх зүгт мөнгөн дэмжлэг олгох, гэр бүлийн хөгжлийг дэмжих тогтолцоог тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

САНАЛ АСУУЛГА

Та дэмжихэ байна уу?

- ДЭМЖИНЭ
- ДЭМЖИХГҮЙ

Санал өгөх

БУСАД ТӨСЛҮҮД

ОРОН СУУЦЖУУЛАЛТЫР
БАНКНЫ ТУХАЙ

Дагасан: 0 Үзсэн

ОРОН СУУЦЖУУЛАЛТЫР
Датасан: 0 Үзсэн

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ
Датасан: 0 Үзсэн

Төслийн дэлгэрэнгүй

 Хариуцагч байгууллага
Хууль зүйн үндэсний хүрээлэн

 Нийтэлсэн огноо
2026-06-04 20:12:54

 Төслийн төлөв
Идэвхтэй

Нийт ирүүлсэн санал : 0

Дагасан тоо : 0

Үзсэн тоо : 68

СОНИРХЛЫН БҮЛЭГ

 ИРГЭНИЙ БОЛОН АРИЛЖААНЫ
ХАРИЛЦАА
 УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН
ХАМГААЛАХ

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

САНАЛ АВЧ ДУУСАХ ХУТАЦАА: 2026-08-03

ТАНИЛЦУУЛГА:

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны ... дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хот

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, ажил, амьдралын тэнцвэрийг хангах, гэр бүлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хүүхд, эх, эцэгт мөнгөн дэмжлэг олгох, гэр бүлийн хөгжлийг дэмжих тогтолцоог тодорхойлохтой холбогдсон харицгааг зохицуулахад оршино.

Хэллэх

САНАЛ АСУУЛГА

Та дэмжиж байна уу?

☐ ДЭМЖИНЭ
☐ ДЭМЖИХГҮЙ

Санал өгнө

БҮСАД ТӨСЛҮҮД

ОРОН СУУЦНЫ САХИУУЖИЛТЫН ТӨРӨЛЖСӨН
БАНКНЫ ТУХАЙ
 Дагасан:  Үзсэн: 70  Санал: 0

ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ТУХАЙ
 Дагасан:  Үзсэн: 74  Санал: 0

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ
 Дагасан:  Үзсэн: 67  Санал: 0

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁОГ

№	ХЭЛЭЛЦҮҮЛЭГ/ ОГНОО	ИРҮҮЛСЭН САНАЛ	ТУСГАСАН БАЙДАЛ, ТАЙЛБАР
1	2025.03.19-ний өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын анхан шатны нэгжийн удирдах албан тушаалтан, мэргэжилтнүүд	нийгмийн үйлчилгээг сайжруулах	Хуулийн төсөлд тусгасан.
2		гэр бүлийг дэмжих, урамшуулах	Хуулийн төсөлд тусгасан.
3		иргэдийг орлоготой болгоход анхаарах, хөдөлмөр эрхлэлтээр хангах,	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгийн төсөлд тусгана.
4		татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх	Хуулийн төсөлд тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
5		гэр бүлийн орлого, хөдөлмөр эрхлэлийг дэмжих, өрхийн үйлдвэрлэл, бизнесийг дэмжих	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгийн төсөлд тусгах боломжтой.
6		Хүн амын бүлэгт чиглүүлж, хөтөлбөрт үйлчилгээ хэрэгжүүлэх	Хуулийн төсөлд тусгасан.
8		Бэлэн мөнгөний бус үйлчилгээг нэмэгдүүлж, зорилтот өрх, иргэнийг хөгжүүлэх, чадавхжуулах, эзэн хандлагыг өөрчлөх, бус даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, үйлчилгээг нэвтрүүлэх,	Хуулийн төсөлд тусгасан. Мөн Нийгмийн халамжийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд тусгагдсан.
9		гэр бүлд үзүүлэх ямар үйлчилгээг хэн хэрхэн үзүүлэх, санхүүжилтийг хаанаас гаргахыг тодорхой заах	Хуулийн төсөлд тодорхой тусгасан.
10	2025.03.20-ны өдөр Олон улсын болон бус төрийн байгууллагын төлөөлөл	төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх	Хуулийн төсөлд тусгасан. Төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, гэр бүлийн үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлэхээр тусгасан.
12		үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын магадлан итгэмжлэл хийх	Хуулийн төсөлд тусгасан боловч ХЗДХЯ-ны саналаар төслөөс хасагдсан.
14		иргэд, гэр бүлийн аж амьдралыг дээшлүүлэхэд анхаарах	Хуулийн төсөлд тодорхой тусгасан.
15		гэр бүлийн орон сууцны хангамжийг анхаарах	Хуулийн төсөлд тодорхой тусгасан. Орон сууцаар дэмжих дэмжлэг гэж заасан.
16		хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй, ахмад настантай гэр бүлийг хэрхэн дэмжих	Хуулийн төсөлд тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
17		залуу гэр бүл, өрх толгойлсон гэр бүлийг дэмжих	Хуулийн төсөлд тусгасан. Өрх толгойлсон гэр бүлд Нийгмийн халамжийн хуулиар тодорхой дэмжлэг үзүүлдэг.

18		ТББ-уудыг дэмжих, хамтран ажиллах хуулийн төслийг хэрэгжүүлэх механизмын тодорхой болгох	Хуулийн төсөлд тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
19		нэгэнт халамжийн хуулийн дагуу зохицуулагдаж буй асуудлуудыг уг хуульд нь байлгах	Хуулийн төсөлд тусгах боломжгүй. Хүн амыг дэмжих бодлогод чиглэсэн тэтгэмж дэмжлэгийг хуулийн төсөлд салгаж тусгасан.
20		нийгмийн үйлчилгээг сайжруулах	Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд тодорхой тусгасан.
21		гэр бүлийг дэмжих, урамшуулах	Хуулийн төслийн 11, 13 дугаар зүйлд тодорхой тусгасан.
22		иргэдийг орлоготой болгоход анхаарах, хөдөлмөр эрхлэлтээр хангах,	Хуулийн төсөлд тусгах боломжгүй. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгийн төсөлд тусгана.
23	2025.03.25-ны өдөр ХТБХХЕГ болон эрдэмтэн, судлаач нарын төлөөлөл	татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх	Хуулийн төсөлд тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
24		гэр бүлийн орлого, хөдөлмөр эрхлэлийг дэмжих, ерхийн үйлдвэрлэл, бизнесийг дэмжих	Хуулийн төсөлд тусгах боломжгүй. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгийн төсөлд тусгана.
27		Бэлэн мөнгөний бус үйлчилгээг нэмэгдүүлж, зорилтот өрх, иргэнийг хөгжүүлэх, чадавхжуулах, зан хандлагыг өөрчлөх, бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хөтөлбөр, үйлчилгээг нэвтрүүлэх,	Хуулийн төслийн 11, 13 дугаар зүйлд тодорхой тусгасан
28		Гэр бүлд үзүүлэх ямар үйлчилгээг хэн хэрхэн үзүүлэх, санхүүжилтийг хаанаас гаргахыг тодорхой заах	Хуулийн төслийн 9, 10, 11, 13 дугаар зүйлд тодорхой тусгасан
29		Гэр бүлд үзүүлэх үйлчилгээг Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга шиг тодорхой тусгамаар байна.	Хуулийн төслийн 9, 10, 11, 13 дугаар зүйлд тодорхой тусгасан
30	2025.04.16-ны өдөр Эрдэмтэн, судлаач, багш нар	Хүн ам зүйн асуудлыг голлон анхаарч, гэр бүлийг дэмжих нь зүйтэй гэж үзсэн.	Саналыг тусгав. Судалгааг тогтмол хийхээр заасан.
31	2025.05.20-ны өдөр Бүх яамдын төлөөлөл, Азийн хөгжлийн банк,	гэр бүлийн боловсролыг их дээд, сургуулийн хөтөлбөрт оруулж хэрэгжүүлэх,	Боловсролын ерөнхий хуулинд энэ харилцааг нарийвчлан заасан тул хуулийн төсөлд оруулах боломжгүй.

32	НҮБ-ын Хүүхдийн сан, Эрүүл мэндийн даатгалын газар, Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн албан хаагчдын төлөөлөл	гэр бүлийг дэмжих, урамшуулах	Хуулийн төслийн 9, 10, 11, 13 дугаар зүйлд тодорхой тусгасан.
33		иргэдийг орлоготой болгоход анхаарах	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгийн төсөлд тусгах боломжтой.
34		хөдөлмөр эрхлэлтээр хангах,	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгийн төсөлд тусгах боломжтой.
35		татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх	Хуулийн төсөлд тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
36		гэр бүлийн бизнесийг дэмжих	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгийн төсөлд тусгах боломжтой.
37		гэр бүлийг орон сууцтай болохыг дэмжих,	Хуулийн төслийн 7 дугаар зүйлд тодорхой тусгасан.
38		ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэний гэр бүлийг орон сууцтай болгоход анхаарах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах,	Хуулийн төсөлд тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
39	2025.06.03-ны өдөр Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөл, Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан зэрэг хуулиар эрх ашиг нь хөндөгдөх нийгмийн бүлгийн төлөөлөл, төрийн байгууллагын төлөөлөл	гэр бүлийг дэмжихдээ хүүхдийн хөгжлийг анхаарах, ялангуяа балчир насны хүүхдийг дэмжих,	Хуулийн төслийн 9, 10, 11, 13 дугаар зүйлд тодорхой тусгасан.
40		жирэмсэн эхийг дэмжих, ургийг хамгаалах,	Хуулийн төслийн 10 дугаар зүйлд тодорхой тусгасан.
41		гэр бүлийн боловсролыг их дээд, сургуулийн хөтөлбөрт оруулж хэрэгжүүлэх,	Боловсролын ерөнхий хуулинд энэ харилцааг нарийвчлан заасан тул хуулийн төсөлд оруулах боломжгүй.
42		олон хэл амьдарч байгаа түвшин сайхан, төлгөвтөртэй амьдралтай гэр бүлийг дэмжих, олон хэлбэрээр /мөнгө өгөх, алдаршуулах/ урамшуулах	Хуулийн төслийн 12 дугаар зүйлд тодорхой тусгасан.
44		гэр бүлийн хөгжлийн цогц төв нь иргэд очиж үйлчлүүлэхэд тав тухтай, таатай орчинтой байх,	Хуулийн төсөлд гэр бүлийн хөгжлийн цогц төвийг тусгасан боловч Сангийн яамны саналаар хасагдсан.
45		орон нутгийн / аймаг, хом/ гэр бүлийн талаар хүлээх чиг үүргийг тодорхой болгох	Хуулийн төслийн 24 дүгээр зүйлд аймаг, дүүргийн гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагын чиг үүрэг гэж тодорхой тусгасан.

46		алслагдсан, уулын оройд байдаг гэр бүлд дэмжлэг үзүүлэх,	Нийгмийн халамжийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд тусгагдсан учраас давхардуулан оруулах боломжгүй.
47		хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийг дэмжих	Нийгмийн халамжийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд тусгагдсан учраас давхардуулан оруулах боломжгүй.
48		гэр бүлийн бизнесийг дэмжих	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгийн төсөлд тусгах боломжтой
49		Хуулийн төсөлд хүүхэд, гэр бүл, эх, эцгийн асуудлыг тусгаж байгаа нь сайшаалтай ч халамжийн чиглэлийн арга хэмжээнүүд ихээхэн туссан байна. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн үйлчилгээг тусгахыг анхаарах	Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд тодорхой тусгасан.
50		Бага насны хүүхдийн хөгжлийн асуудлын анхаарах	Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд тодорхой тусгасан.
51	2025.06.18-ны өдөр Гэр бүл, хүүхдийн салбарын стандартын ТХ-ны таниуулдаг	Гэр бүл, хүүхэд ээлтэй орчинд бүрдүүлэх, ингэдээ стандартыг хэрэгжүүлж мөрдүүлэх асуудлыг анхаарч тусгах	Хуулийн төслийн хяналт үнэлгээний хэсэгт тусгасан болно.
52		Гэр бүл тогтвортой байх, хүүхдийг хамгаалах, гэр бүлийн бодлогын асуудлуудыг анхаарах, хүүхэд хамгааллын одоогийн тогтолцоо болон нийгэмд үзүүлэх үйлчилгээтэй уялдуулах.	Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд тодорхой тусгасан.
53		Гэр бүл, иргэдэд үзүүлэх шаардлагатай үйлчилгээг тодорхой заах, холбогдох стандарт журмыг боловсруулахыг тодорхой заах,	Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд тодорхой тусгасан.
55		Хүүхдийг төрөхөд хүүхдийн цахим нийгмийн хамгааллын бүртгэлтэй байх. Энэхүү бүртгэл нь хүүхдийн мэргэ, хамгаалалт тохмол байна. Хорсооны нийгмийн ажилтан, цагдаа, өрхийн НА зэрэгт мэдээлэл очдог байна. Тус хүүхэд ямар нэгэн эрсдэлд өртөхөд цагдаа, өрх зэрэгт мэдээлэл нь очдог байна. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүд гэр бүлийн хүчирхийллийн мэдээлэл сургууль, 108 зэрэгт очиход хаягаа өөрчлөөд нүүдэг. Энэхүү асуудлаас болж хүүхдийн эрсдэлийг бууруулах боломж багаардаг. Нийт хүүхдийн 36% нь халамж, хамгааллын үйлчилгээ авч байна.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн дагуу энэхүү хэргийг зохихуулагдсан тул давхардуулан тусгах боломжгүй.
56	2025.06.20-ны өдөр Төрийн бус байгууллага, олон нийтийн төлөөлөл	Хуулийн төсөлд хүүхдийн мөнгөний асуудал тусч байгаа юм байна. Хүүхдийн мөнгөний журамд өөрчлөлт оруулах.	Хуулийн төслийн 13.1-д заасан мөнгөн дэмжлэгийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар баталхаар заасан.

57	Хүүхдийн мөнгө 100,000 болсноос хойш асрамжаас хүүхдээ авдаг. Өмнө нь хуримтлагдсан хүүхдийн мөнгийг авахгүй байх	Хүүхдийн төсөлд бүрэн тусгасан: Хуулийн төслийн 14.6.Асрамжийн газарт амьдарч байгаа 14 ба түүнээс дээш насны хүүхдийн мөнгөн дэмжлэгийн 80 хувийг банканд хадгалуулж, 20 хувийг хүүхэд өөрөө захиран зарцуулах зориулалт бүхий банкны харилцах дансыг нээлгэх бөгөөд энэ данс нь цахим карттай байна.
58	18 нас хүрсэн асрамжаас гарч байгаа хүүхэд мөнгөтэй харьцаж сураагүй байдаг. Иймд захирах эрхийг нь 20%-тай байлгах саналтай байна.	Хуулийн төсөлд хэсэгчлэн тусгав. Үүнд: 14.2-т "хүүхэд 16 насанд хүрсэн бол өөрөө сум, хорооны нийгмийн ажилтанд хандан биечлэн, эсхүл цахим хэлбэрээр гаргах бөгөөд хүсэлт гаргасан сараас нь тооцож олгоно" гэж заасан.
59	18 нас хүрсэн хүүхдэд хуримтлагдсан бүх мөнгийг нь өгөхгүй байх. Зарим гаднын оронд 23 нас хүрсэн үед нь өгдөг. Зарим хүүхэд нь 18 нас хүрэхээсээ өмнө хүнд өр тавиад мөнгөө дуусгадаг. Иймд 18 нас хүрсэн үед нь хуримтлагдсан мөнгөний 30%-ийг өгдөг байх саналтай байна.	Хуулийн төслийн 14 дүгээр зүйлд тодорхой тусгасан.
60	Гэр бүл бүлүүдэд хуримтлагдсан хүүхдийн эрх зүйн зорилгыг зохицуулах, нөгөө талаас ГБ төлөвлөх, тогтвортой байх, хүүхдийг хамгаалах, гэр бүлийн бодлогын асуудлууд анхаарах, хүүхэд хамгааллын тогтолцоо болон нийгэмд үзүүлэх үйлчилгээтэй уялдуулах.	Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.
61	Гэрлэлт бүртгэл, дуусгавар болох, эд хөрөнгийн эрх, амны эрхтэй холбоотой асуудал, эцэг эхийн хамгаалах боломжгүй болсон тохиолдолд хаана хандах вэ,	Хөдөлгөөн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон Нийгмийн халамжийн тухай хуулиар зохицуулсан байдаг тул энэ хуулийн төсөлд тусгах боломжгүй.
62	Хөдөлгөөн бэрхшээлтэй гэр бүлийн хүүхдийн асуудал анхаарах	Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.
63	Гэр бүл цуцлалтын явцад хүүхдийн эрх зөрчигдөж байна. Цаашдын зорилго гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, гэрлэгчдийн эрх үүргийн асуудлыг оруулсан.	Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд энэ харилцааг

		оролцуулах, шүүгчид өөрсдөө мэргэшэх шаардлагатайг ярилцсан.	зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.
66		Илүү хамгаалах шаардлагатай гэр бүл, иргэдийг тэргүүн эгнээнд хамгаалах	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд тодорхой заасан учраас энэ хуулийн төсөлд тусгах боломжгүй.
67		Хүүхэд гэр бүлийн орчинд өсөх	Хүүхэд хамгааллын тухай хууль болон Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.
68		Гэрлэлтэд гэр бүлийн амьдралд адил тэнцүү үүрэгтэй оролцох, тэгш эрхтэй байх.	Хуулийн төслийн зарчим нь энэ харилцаанд үндэслэсэн тул тодорхой тусгасан.
69		Гэр бүл хүчирхийлэлгүй амар тайван аж төрөхийг анхаарах	Хуулийн төслийн зарчим нь энэ харилцаанд үндэслэсэн тул тодорхой тусгасан.
71		Гэртээгүй ч хүүхдийн өмнө хамтын хариуцлага хүлээдэг байхыг энэ хуульд бас анхаарах, хамтран амьдрагч гэр бүлийг дэмжих.	Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.
72		Угсийн бичиг хөтлөх их чухал асуудал, уг асуудлыг өр дурдахгүй байна. Энэ талаар хуулийн төсөлд тодорхой зохицуулалт оруулах.	Соёлын тухай хуульд тодорхой зааж өгсөн тул энэ хуулийн 12 дугаар зүйлд тусгаж, саналыг хэсэгчлэн тусгав.
73		Эцэг төлсөх болох, ургийн шинэчилгээг хурдан шуурхай хийдэг байх	Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.
74		Гэр бүлийн асуудлаарх ТББ-ыг чадавхжуулах.	Хуулийн төсөлд тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
75		Эхнэр жирэмсэн, хүүхэд 3 нас хүрээгүй хүүхэдтэй гэр бүлийг дэмжих	Хуулийн төсөлд хүүхэдтэй залуу гэр бүл болон 3-аас дээш хүүхэдтэй гэр бүлийг дэмжихээр заасан.
76		Эцэг эхийн үүрэг, хариуцлага, хамтын үүрэг анхаарах, хүүхдийн тэтгэлгээ гэр бүлийн хүүхдийн нөхцөл байдлаас шалтгаалаад тухайн гэр бүлд дэмжлэг үзүүлэх, тухай бүс нутгийн эмэгжиргааны дээд түвшин, зөвхөн цалингийн орлоготой бол 50%-аар гэх мэт төрөөс дэмжлэг үзүүлэх	Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.

77	Хуулийн хэрэгжилтийг хангах асуудлыг цаашид анхаарах, иргэдэд оурталчлах, иргэд өөрсдөө мэдлэгтэй байх, цаашдаа гэр бүлтэй холбоотой гэрээ конвенциудад нэгдэж орох	Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.
78	Хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, насаараа ял эдэлж байгаа, ор сураггүй алга болсон иргэд хүүхдийн тэтгэлгээ төлөх ямар ч боломжгүй. Иймээс МУУХ-ийн 16 зүйлд байгаа “Эх нялхас, хүүхэд төрийн хамгаалалтад байна” гэсэн заалтын хүрээнд “Тэтгэлгийн асуудлыг төр шийддэг байхаар тусгавал эрх зүйн хувьд дэвшилттэй болно. Энэ асуудлыг анхааралдаа авах	Гэр бүлийн тухай Соёлын тухай хуульд тодорхой зааж өгсөн тул энэ хуулийн 12 дугаар зүйлд тусгаж, саналыг хэсэгчлэн тусгав.
79	Угийн бичиг бол гэр бүлийн үнэт зүйл, цус ойртолтоос хамгаалах чухал арга, иймээс хамгийн анхаарч хуулийн зохицуулалтыг тодорхой заах.	Гэр бүлийн тухай Соёлын тухай хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.
80	Хүний асуудлыг шийдвэрлэх бейгаа тохиолдолд заавал бүрэлдэхүүнтэй асуудал шийддэг, бүрэлдэхүүнд нэр заавал эрхтэй, амгартай төлөөлөл оруулахаар хуульчилгах. Гэр бүлийн харьцаа нь асуудал энэ хуулийн асуудал биш ч гэсэн тухайн гэр бүлд таарч тохирсон үйлчилгээ үзүүлэх.	Хуулийн төслийн 28 дугаар зүйл. Гэр бүлийн үйлчилгээний цахим мэдээллийн систем гэж тодорхой үйлчилгээг зааж өгсөн.
81	Хүүхэд, гэр бүл, залуучуудын асуудлуудыг хүлээн авч онлайн сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх, дэг компани.	Хуулийн төслийн 28 дугаар зүйл. Гэр бүлийн үйлчилгээний цахим мэдээллийн систем гэж тодорхой үйлчилгээг зааж өгсөн.
82	Технологийн шийдлийг ашиглах, тогтвортой шийдлийг дэмжих.	Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.
83	Холбоон суучлах үйлчилгээнд хэрхэн хамруулахыг тусгайлан анхаарах	Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг эцэг, эхийн адил тэгш дэмжихээр заасан.
84	Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг дэмжих	Нийгмийн халамжийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд тусгагдсан учраас давхардуулан оруулах боломжгүй.
85	Гэр бүлд Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх	Хуулийн төслийн 30 дугаар зүйлд тодорхой тусгасан.
86	Хуулийн хэрэгжилт, тайлагнах, улирал бүрийн мэдээллийг хүргүүлэх талаар тусгах	

87	Зөвхөн мэдээллийн сан бүрдүүлэхийг тодорхой тусгах	Хуулийн төслийн 28 дугаар зүйл. Гэр бүлийн үйлчилгээний цахим мэдээллийн систем гэж тодорхой үйлчилгээг зааж өгсөн.
89	Төрөөс гэр бүлийг дэмжих үйлчилгээ дээр дараах саналууд байна: • Гэр бүлийг бэхжүүлэх тогтвортой байдлыг хангахын тулд гэр бүлийн хэв шинжид тулгуурлан дэмжих үйлчилгээг бий болгох арга зүйг боловсруулах журамлах шаардлагатай. • Гэр бүлийн харилцааг дэмжих төвүүдийг дүүрэг суман дээр Соёлын төвийг түшиглэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг явуулж, олон хуулийн төсөлд жил бүр оруулах. • Гэр бүлийн төслүүдийг харилцананаас болж хүүхдийг гадаад руу авч явдаг. Үүнийг олон улсын эрх зүйд хүүхэд хулгайлах гэж үздэг, хүүхдийн тэтгэмж төлөгч гадаадад гарсан болсон ГААГ-ын конвенцод нэгдэн орсон орнууд эрх зүйн тусалцаа үзүүлэх асуудалд санал өгөх. Гэр бүлийн бат бөх байдлыг хангахын тулд Гэр бүлийн үнэ цэнэ, эрх зүйн харилцааныг нэмэгдүүлэх заалтыг ГБТХ-нд шүүрээс даалгахыг Гаг-ын бага хурлаас даалгасан 1996 онд баталсан.	Гэр бүлийн хэв шинжид тулгуурлан дэмжих үйлчилгээг бий болгоход хуулийн төслийн 11 дүгээр зүйлд тодорхой заасан. Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулга хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй. Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.
90	Гэр бүлд нөлөөлөд байгаа архидан согтуурахтай тэмцэх хамгаалалт үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Санал хэлье. Эцэсгүйн хууль үйл ажиллагааг бид хэрэгжүүлж байна. Үүнийг илүү хөгжүүлэх.	Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.
91	Хүүхдийн өсөн санааны аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдал, үнэ баримтанд өсөн санааны аюулгүй байдалын талаар оруулах гээд чадахгүй байна.	Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хуульд тодорхой заасан тул давхардуулан заах боломжгүй.
92	ТББ-ын үйл ажиллагааг төр өснөхгүй байна. ТББ төр иргэн эцэг холбож байгаа хүмүүсийг бүлэглэл, Тэднийг дэмжиж ажиллах хэрэгтэй, төрийн биш гэж хүн байхгүй. Зарим улс оронд эвлэлд өгөөд байна.	Хуулийн төсөлд ТББ-ыг дэмжих заалт тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
93	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль ГБТХ-тай эргэлтэд байна. Эцэсгүйн хууль ажиллагааг оруулах арга байдлыг Архидан согтуурахтай ГТХ-д өнөөдөр нь өргөдөл бичүүлээд албадан эмчилгээнд явуулж байна. Шүүхийн шийдвэрээр эхнэрийн хүсэлтээр албадан эмчилгээнд хамруулж байна гэхээр эргээд Гэр бүлийн	Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд энэ харилцааг зохицуулахаар заасан тул давхардуулан заах боломжгүй.

	хүчирхийлэл даамжруулж байна. Эрэгтэй хүн талаас хараад байна, сэтгэл зүйд хүнд цочрол үзүүлээд оюун санааны хохирол учруулж байгаа эмэгтэйчүүдэд ч гэсэн хариуцлага тооцдог байж болохгүй юу.	Хуулийн төсөлд гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвүүдийг байгуулахаар заалт тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
94	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төв, хөгжлийн төв байгуулах ёстой. Эрэгтэйчүүдийг соён гэгээрүүлэх төв дүүргүүдэд байхгүй байна.	Хуулийн төсөлд гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвүүдийг байгуулахаар заалт тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
95	Ариудан оогтууруулахтай төмцөх төрийн бус байгууллагатай уулзалт зохион байгуулсан. Тус тус нь спорт заалаар даамжруулж хамтаралтай иргэдийг уулзуулан ууртгалтай хөдөөлүүлдэг. Ариудан хамгааралтай иргэд хамгааралтай хүмүүстээ нөлөөлдөг.	Хуулийн төсөлд гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвүүдийг байгуулахаар заалт тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
96	Гэр бүлийн нийгмийн ажиглан, сэтгэл зүйчийг мэргэшүүлэн бэлтгэх, Төрийн албан хаагчийн шалгалт өгөх болон хууль, зүйрл, журмуудад гэр бүл судлаач гэдэг мэргэжил орхигдож байна. Төрийн албан хаагчийн шалгалтад хүртэл мэргэжлийн нэр орж ирдэггүй. Иймд энэ асуудлыг анхаарч өгнө үү.	Боловсролын ерөнхий хуулиар тус хэрэгцээг зохицуулсан тул давхардуулан заах боломжгүй.
97	Гэр бүл хүүхдэдээ зарцуулах үр бүтээмжтэй цагийг олон улсын хуулиудад зааж өгсөн байдаг. 7 хоногт гэр бүл, үр хүүхдэдээ зарцуулах, гэрлэлт цуцлуулсны дараа хүүхдэдээ тэдгээрийг зарцуулна гэж тусгаж өгмөөр байна.	Хуулийн төслийн 8 дугаар зүйл. Ажил, амьдралын тэнцвэрийг хангах гэж тодорхой заалтуудыг оруулсан.
98	Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн газрууд сургалтын танхим, өрөөнтэй байна гэсэн заалт байна. Үүн дээр нэмээд гэр бүл, хөгжлийн төвтэй байна гэж хуульдаа оруулж өгөөрэй.	Хуулийн төсөлд гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвүүдийг байгуулахаар заалт тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.
99	Нэгдүгээд гэр бүлийн өв соёлыг хамгаалах зүйл заалтыг нэмж өгсөөрэй. Үндэстний өв соёл, үнэт зүйлээ хадгалсан ганц заалт, ганц зүйл нэмж оруулж өгсөөрэй.	Соёлын зүйг хамгаалах тухай болон Соёлын тухай хуульд тодорхой зааж өгсөн тул давхардуулан заах боломжгүй.
100	Хууль дээр иргэний нийгмийн байгууллагатай хамтарч ажиллах хамтын ажиллагааны талаар бичигдээгүй байна. Иймд энэ асуудлыг тусгаж тодорхой болгох	Хуулийн төсөлд ТББ-ыг дэмжих заалт тусгасан боловч Сангийн яамны саналаар хассан.

ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАН БОЛОН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНД ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭД ОРОЛЦОХ
АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛТНУУДЫН НЭРС

2026 оны 06 дугаар сарын 05-ны өдөр

№	НЭР	АЛБАН ТУШААЛ	ХОЛБОО БАРИХ УТАС
1	А.Даваажаргал	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга	99113482
2	Д.Мөнгөнтуул	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга	99119720
3	Б.Баярсайхан	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	99111851
4	М.Цогтбаатар	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын Хүн ам, гэр бүлийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч	99011359
5	Б.Номин-Эрдэнэ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын Гэр бүлийн хөгжил, хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	99816339

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ